



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА

2023



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛС
ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА
2023

Улаанбаатар
2024

МОНГОЛ УЛС
ЦАГ АШИГЛАЛТЫН СУДАЛГАА 2023

Тайлан хянасан

Б.БАТДАВАА, ҮСХ-ны дарга

М.ОЮУНЦЭЦЭГ, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын дарга

Д.ДАВААЖАРГАЛ, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга

Тайлангийн өгөгдөл боловсруулсан

Д.ГАНЧИМЭГ, ҮСХ-ны Нийгмийн статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн статистикч

Ц.МӨНХ-ОРГИЛ, ҮСХ-ны гэрээт ажилтан

Б.ЦЭНДМАА, ҮСХ-ны гэрээт ажилтан

Тайлан боловсруулсан

ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

Өгөгдлийн дүрслэл ба тайлангийн дизайн

ТУНГААХУЙ ӨГӨГДЛИЙН УРЛАН

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

📍 Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу - 44
Засгийн газрын III байр

☎ 976-70141212

🌐 www.nso.mn, www.1212.mn

✉ information@nso.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ	6
ӨМНӨХ ҮГ	7
СУДАЛГААНЫ ТОЙМ	8
1. ТАНИЛЦУУЛГА	13
1.1. Судалгааны тухай танилцуулга	14
1.2. Судалгааны хүрээнд бүтээсэн өгөгдөл	16
2. СУДАЛГААНЫ ЗАГВАР	19
2.1. Зорилго, зорилтууд	20
2.2. Ойлголт, тодорхойлолт	20
2.3. Түүврийн арга зүй	20
2.4. Мэдээлэл цуглуулалт ба дүн шинжилгээ	25
3. СУДАЛГААНД ХАМРАГДАГЧ	27
3.1. Судалгаанд хамрагдсан өрх	28
3.2. Судалгаанд хамрагдсан хүн ам	30
4. ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ	33
4.1. Хүн амын амьдралын хэв маяг	42
4.2. Цаг ашиглалт ба хүйсийн ялгаа	80
4.3. Цаг ашиглалт ба амьдралын мөчлөг	114
4.4. Цаг ашиглалт ба үйлдлийн чадварын хүндрэл	142
4.5. Цаг ашиглалт ба боловсрол	156
4.6. Цаг ашиглалт ба хөдөлмөр эрхлэлт	178
4.7. Цаг ашиглалт ба гэр бүлийн байдал	196
4.8. Цаг ашиглалт ба өрхийн аж байдлын түвшин	230
4.9. Цаг ашиглалтын тэнцвэрт ба зохист байдал	260
ХАВСРАЛТ	274
Хавсралт 1. Хүн амын цаг ашиглалт, сонгосон үзүүлэлтээр	274
Хавсралт 2. Цаг ашиглалтын хүйсийн харьцаа тооцох аргачлал	406
Хавсралт 3. Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал	407
Хавсралт 4. Цаг ашиглалтын судалгааны асуулгын хуудас	411

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
МАА	Мал аж ахуй
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ЦАС	Цаг ашиглалтын судалгаа
ЦАСҮАА	Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал
САPI	Computer Assisted Personal Interview
САTI	Computer Assisted Telephone Interview
САWI	Computer Assisted Web Interview
DEFF	Design effect
РАPI	Paper Assisted Personal Interview
RME	Relative Mean Error

ӨМНӨХ ҮГ

Цаг ашиглалтын судалгаа нь тухайн улсын хүн амын амьдралын хэв маяг, онцлогийг судлахаас гадна нийгмийн харилцаан дахь хүйсийн тэгш байдлыг илэрхийлэх боломжтой, амьдралын чанарыг сайжруулахад хэрэгцээтэй мэдээллээр баялаг цогц судалгааны нэг юм. Үүнээс гадна, эдийн засгийн өсөлтөд хамгийн их нөлөө үзүүлдэг хүн амын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай цагийн зөв зохицуулалтаар хангах бодлого боловсруулах суурь мэдээлэл болох утгаараа энэ судалгааны ач холбогдол нь зөвхөн эдийн засгийн үр ашгийн хэмжүүр биш бөгөөд хүмүүсийн ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хадгалах, зохицуулах чухал мэдээллийн эх үүсвэр болно.

Тодруулбал, уг судалгаа нь Тогтвортой хөгжлийн зорилгын нэг үзүүлэлт болох "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг"-ийг хэмжих, үнэлэх үндэсний хэмжээний суурь мэдээлэл болдог онцлогтой.

Үндэсний Статистикийн Хороо нь Монгол Улсын статистикийн тухай хуулийн дагуу 4 жил тутам уг судалгааг зохион байгуулан явуулж, үр дүнг бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид болон бусад хэрэглэгчдэд хүргэж байна.

Энэ удаагийн судалгаанд хүн амын амьдралын хэв маягийн улирлын онцлогийг харуулах зорилготойгоор сар бүр мэдээлэл цуглуулан, жилийн турш улсын хэмжээнд 20 гаруй мянган өрхийг хамруулснаас гадна мэдээлэл цуглуулалтад утсаар ярилцлага авах (CATI), цахим хуудсаар ярилцлага авах (CAWI), цахим төхөөрөмж ашиглан нүүр тулан ярилцлага авах (CAPI) аргуудыг хослуулан ашигласан нь өмнөх судалгаануудаас онцлог болсон.

Судалгааг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган ажилласан удирдах зөвлөл болон ажлын хэсэг, үндсэн багийн гишүүд, мэдээллийг цуглуулах амаргүй ажлыг гүйцэтгэсэн ажилтнууд болон судалгаанд хамрагдсан нийт өрхүүдэд талархал илэрхийлж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА
Б.БАТДАВАА

СУДАЛГААНЫ ТОЙМ

Цаг ашиглалтын судалгаа (ЦАС) нь хүн амын амьдралын хэв маягийг зураглаж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, өрх гэрт оруулж буй хувь нэмрийг тодорхойлох өгөгдлийн чухал эх үүсвэрийг бүрдүүлдэг. Хүний биологийн болон нийгмийн хэрэгцээнээс хамааран цаг ашиглалтад нийтлэг зүйлс бий. Нөгөөтэйгүүр нийгэм, соёл, эдийн засгийн нөхцөл байдал, хувь хүний онцлог, сонголт зэрэг олон хүчин зүйлээс хамааран хүн амын цаг ашиглалт ялгаатай. Монголчууд цагаа хэрхэн хуваарилдаг, хүн амын цаг ашиглалтын төлөв өөр хоорондоо хэр ялгаатай вэ?

ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

Монгол хүн өдрийн 24 цагийн 51.0 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээндээ, 33.8 хувийг хөдөлмөр эрхлэхэд, 15.1 хувийг боловсрол болон чөлөөт цагтаа зарцуулж байна. Тодруулбал, 2023 оны байдлаар улсын дунджаар 12 ба түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдрийн 12 цаг 15 минутыг унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээнд, 4 цаг 36 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 3 цаг 31 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд, 32 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж, үлдсэн 3 цаг 6 минутыг чөлөөт цагт хуваарилжээ.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг нь хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цагийн 76.4 хувьтай тэнцэхүйц буюу ийм хэмжээний хөдөлмөр эдийн засгийн хувьд ямар нэг байдлаар үнэлэгдээгүй байна. Монголчууд чөлөөт цагаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад ихэвчлэн хуваарилдаг. Өдөрт дунджаар 1 цаг 58 минутыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулдаг ба энэ нь хобби, спорт, соёлын үйл ажиллагаанд зарцуулсан цагаас 4.9 дахин их юм.

Монгол орны хаана амьдарч байгаагаас хамааран хүн амын цаг ашиглалт ялгаатай. Хүн амын амьдарч буй байршлаар илрэх цаг ашиглалтын хамгийн том ялгаа нь хөдөөд хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хотынхоос илүү их цаг зарцуулдаг. Хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд хөдөөгийн хүн ам хотын хүн амаас өдөрт дунджаар 13.9 хувиар илүү цаг зарцуулдаг. Хотод ААНБ-д ажиллах зонхилсон хөлстэй хөдөлмөр давамгайлдаг бол хөдөөд мал маллах зонхилсон өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөлстэй хөдөлмөр давамгайлна. Хөдөөд МАА эрхлэх хөлстэй хөдөлмөр эрхлэлт их учраас боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулах цаг хотынхоос хомс.

ЦАГ АШИГЛАЛТ БА ХҮЙСИЙН ЯЛГАА

Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү хөдөлмөрлөдөг, гэхдээ хөлсгүй. Хөдөлмөр эрхлэлтийг хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрийн нийлбэр дүнгээр тооцвол эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 59 минутыг хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй бол эмэгтэйчүүд дунджаар 8 цаг 13 минутыг хөдөлмөр эрхлэхэд зарцуулж байна. Гэхдээ илүү чухал ялгаа нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хөлстэй, хөлсгүй шинж чанараар илэрнэ. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулдаг бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.0 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зориулж байна. **Тодруулбал, эрэгтэйчүүдийн өдрийн дундаж хөдөлмөр эрхэлсэн цагийн 71.6 хувь нь хөлстэй хөдөлмөр бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхэлсэн нийт цагийн тал хүрэхгүй хувь буюу 44.6 хувь нь хөлстэй хөдөлмөрт зарцуулагджээ.**

Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа төвөөс алслагдах тусам улам гүнзгийрдэг. Хотод хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их цаг зарцуулдаг бол хөдөөд 1.6 дахин их цаг зарцуулдаг. Хөлсгүй хөдөлмөрт хотод амьдардаг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.9 дахин их цаг зарцуулдаг бол хөдөөд энэ тоо 2.3 болж нэмэгджээ.

Цаг ашиглалтын судалгаа нь ТХЗ-ын “5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг” үзүүлэлтийг хэмжих, хянах боломжийг олгодог. 2023 оны байдлаар эрэгтэйчүүд нэг өдрийн 24 цагийнхаа 9.0 хувийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулдаг бол эмэгтэйчүүд 18.5 хувийг энэ үйл ажиллагаанд зарцуулж байна. 2019 онд энэ үзүүлэлт 7.4 ба 19.0 хувь байсан. Хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйс хоорондын ялгаа 30 минутаар буурсан үр дүнтэй байна. Энэ нь эрэгтэйчүүдийн цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг 23 минутаар нэмэгдэж, эмэгтэйчүүдийнх 7 минутаар буурсантай холбоотой. Хүйсийн ялгаа буурч байгаа ч хөлсгүй хөдөлмөрийг үнэлэх, гэр бүл дэх хөлсгүй хөдөлмөрийн үүргийг гэр бүлийн гишүүд тэгш хуваалцах хандлага бий болоход хугацаа шаардлагатай хэвээр байна. Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйсийн ялгаа 25-44 насны бүлэгт хамгийн өндөр, 65 ба түүнээс дээш насны бүлэгт харьцангуй бага боловч ялгаатай хэвээр.

ЦАГ АШИГЛАЛТ БА АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

Хүн амын амьдралын мөчлөг буюу наснаас хамааран амьдрах хэв маяг, дадал хувьсан өөрчлөгдөж байдаг. 12-17 насанд суралцах болон чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цагт хамгийн их цаг зарцуулдаг. 18-24 наснаас эхлэн боловсролд зарцуулах цаг буурч, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд цаг зарцуулах нь нэмэгдэнэ. Хүн амын хөдөлмөр эрхлэлт 18-24 насны бүлгээс эхлэн идэвхжих ба 25-39 насанд оргил үедээ хүрч, 59 нас хүртэл идэвхтэй үргэлжилсээр 60 ба түүнээс дээш наснаас буурч эхэлдэг.

Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд илрэх хүйсийн ялгаа бага наснаас буюу 12-17 наснаас эхэлж, 18 ба түүнээс дээш насанд илүү гүнзгийрдэг. 12-17 насанд хөвгүүд окидоос 1.8 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол окид хөвгүүдээс 1.5 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Хүйсийн энэ ялгаа нь насны бүлэгт харгалзах хөдөлмөр эрхлэлтийн идэвхийг даган нэмэгдэнэ. Ялангуяа хөдөлмөрийн хамгийн идэвхтэй 18-39 насанд энэ ялгаа оргил үедээ хүрч, 40 наснаас хойш буурах буюу хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага зэрэг буурч, эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэх хандлага илэрч байна. Хөлстэй хөдөлмөр эрхлэлт эрэгтэйчүүдэд, хөлсгүй хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдэд хуваарилагдах байдал эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг насан туршид дагах ба насны бүлгүүдэд нэмэгдэх, буурах хэдий ч тэнцвэргүй хэвээр байдаг аж.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн дунджаар 6.4 хувийг хөлстэй хөдөлмөрт, 13.8 хувийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 19.6 хувийг боловсрол, чөлөөт цагт, 60.2 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээндээ зарцуулж байна. **Үйлдлийн чадварын хүндрэл нь хөлстэй хөдөлмөр эрхлэх цагийг хязгаарлаж буй ч хөлсгүй хөдөлмөрийн хувьд огтхон ч хязгаарлалт болдоггүй.** Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 19 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад ердөө 13 минутаар бага байна. Харин хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 3.1 дахин бага, эсрэгээрээ чөлөөт цаг нь 1.6 дахин их байна.

ЦАГ АШИГЛАЛТ БА БОЛОВСРОЛ

Хөдөлмөр эрхлэлтийн статус хөлстэй хөдөлмөрт шилжих нь боловсролын түвшинтэй нягт уялдаатай. Дээд боловсролтой хүн амтай харьцуулахад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн өдөрт дунджаар 6.2 хувиар бага цагийг, бүрэн дунд боловсролтой хүн 9.4 хувиар бага цагийг, суурь боловсролтой хүн 28.0, боловсролгүй, бага боловсролтой хүн 26.4 хувиар бага цагийг тус тус хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. **Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа буурдаг.** Боловсролын түвшнээс үл хамааран хөдөлмөрийн хуваарьт хөлстэй хөдөлмөрийг эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрийг эмэгтэйчүүд голчлон гүйцэтгэх хандлага хэвээр. Гэхдээ эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэхэд тэдний хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг илүү болж, хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа арилахгүй ч буурч байна. Боловсролгүй, бага боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.3 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад дээд боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.


ЦАГ АШИГЛАЛТ БА ГЭРЛЭЛТ

Гэрлэлтийг даган хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж байна. Огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэр бүлээ батлуулсан хүн амын хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цаг 42.1 хувиар илүү, гэр бүлээ батлуулаагүй хүн амынх 56.6 хувиар илүү, тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүнийх 45.3 хувиар илүү байна. Гэрлэлтийн төлөв ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлыг насны бүлгээр нарийвчилж үзвэл аль ч насанд гэрлэлт нь хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагийг нэмэгдүүлэх ба 18-39 насанд буюу төрөлтийн түвшин өндөр, залуу гэр бүлийн хувьд хөлсгүй хөдөлмөрийн ачаалал хамгийн их нэмэгдэж байна. Цаашилбал хүүхэдтэй болох нь хүн амын, тэр дундаа эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагийг нэмэгдүүлдэг.

Гэрлэсэн хүн амын дунд хөдөлмөр эрхлэлтийн хүйсийн ялгаа илүү гүнзгий. Гэрлэлт нь цаг ашиглалтын хувьд эрэгтэйчүүдэд хөлстэй хөдөлмөр эрхлэх хариуцлага, эмэгтэйчүүдэд хөлсгүй хөдөлмөр эрхлэх үүргийг авчирдаг гэж хэлж болно. Огт гэрлээгүй эрэгтэй огт гэрлээгүй эмэгтэйгээс 1.2 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол батлуулсан/батлуулаагүй гэр бүлтэй тохиолдолд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5-1.7 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Хөлсгүй хөдөлмөрийн хувьд хүйсийн ялгаа илүү гүнзгийрч, огт гэрлээгүй эмэгтэй огт гэрлээгүй эрэгтэйгээс 1.7 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байхад гэрлэсэн эмэгтэй гэрлэсэн эрэгтэйгээс гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүйгээс үл хамааран 2.2 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.

ЦАГ АШИГЛАЛТ БА ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШИН

Өрхийн аж байдлын түвшин өндөр байх тусам хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулж байна. Дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн ам 3 цаг 43 минут, дундаж аж байдлын түвшинтэй хүн ам 4 цаг 7 минутыг хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар зарцуулж байхад дунджаас дээгүүр болон дээгүүр аж байдлын түвшинтэй хүн ам 4 цаг 36-54 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Харин аж байдлын түвшин хамгийн бага буюу доогуур ангилалд багтах хүн амын хувьд хандлага биелэхгүй буюу хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд бусад ангилалтай харьцуулахад хамгийн их цагийг зарцуулах хэдий ч энэ цагийнхаа дийлэнх буюу 80.4 хувийг өөрийн өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулжээ. Дунджаас дээгүүр болон дээгүүр аж байдлын түвшинтэй хүн ам өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо бага, эсрэгээрээ ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд илүү цаг зарцуулж байна. Түүнчлэн аж байдлын түвшин нэмэгдэхэд хүн амын гэрийн ажилд зарцуулах цаг тодорхой хэмжээгээр буурах бол хүүхэд асрахад зарцуулах цаг буурдаггүй ажээ.



1

ТАНИЛЦУУЛГА



1.1. СУДАЛГААНЫ ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Цаг ашиглалтын судалгаа (ЦАС) нь хүн амын амьдралын хэв маягаас гадна эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, өрх гэрт оруулж буй хувь нэмрийг тодорхойлоход ашиглагддаг мэдээллийн чухал эх үүсвэрүүдийн нэг юм. Дэлхийн 85 улс орон 1966 оноос хойш ЦАС-г зохион байгуулж¹ ирсэн бөгөөд 2000 оноос хойш ЦАС-г зохион байгуулж байгаа улс орны тоо нэмэгдэж байна.

Манай улсын хувьд цаг ашиглалтын туршилтын судалгааг анх 2000 онд НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүү, техникийн тусламжтайгаар 1086 өрхийг хамруулан олон улсын жишиг аргачлалын дагуу нэг улиралд зохион явуулсан. Энэ судалгаа нь олон улсын нийтлэг ойлголт, тодорхойлолт, арга зүйг ашиглан хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлт, албан бус секторын ажил эрхлэлт, хүн амын өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулж буй дундаж хугацааг тодорхойлон гаргаснаараа чухал ач холбогдолтой байв.

Монгол Улсын Статистикийн тухай хуульд 2004 онд нэмэлт өөрчлөлт орж, тус хуулийн 7-р зүйлийн 1 дэх хэсгийн "к"-д "цаг ашиглалтын түүвэр судалгааг 4 жил тутам улирлаар" явуулна гэж заасан. Энэ дагуу анхны судалгааг 2007 онд улсын хэмжээнд 3200 өрх, 2011, 2015, 2019 онд тус бүр 4000 өрхийг хамруулан зохион байгуулсан. Судалгаа нь хүн амын хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цагийг хүйсээр гаргаж мэдээлэх, хүн амын амьдралын хэв маягийг тодорхойлох, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай тоо мэдээллийг бий болгоход чиглэгдсэн.

Түүнчлэн уг судалгаа нь Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг" үзүүлэлтийг тооцож, ТХЗ-ын хэрэгжилт, явцыг үнэлэх бололцоог олгож байна.

Хуульд заасны дагуу энэ удаагийн Цаг ашиглалтын судалгааг 2023 онд зохион байгуулж явуулсан ба судалгаанд 23394 өрхийг хамруулж, улирал бүрийн онцлогийг харуулах зорилготойгоор сар бүр мэдээлэл цуглуулж, үр дүнг үндэсний болон бүсийн түвшинд, мөн суурьшлаар тооцон гаргалаа.

2023

2019

2015

2011

2007

2000

¹ <https://unstats.un.org/UNSDWebsite/demographic-social/time-use/>

Зураг 1. Цаг ашиглалтын судалгааны он цагийн дараалал

Улсын хэмжээнд 23394 өрхийг хамруулан зохион байгуулсан.

8 аймаг, Улаанбаатар хотын 4000 өрхийг хамруулан зохион байгуулсан.

8 аймаг, Улаанбаатар хотын 4000 өрхийг хамруулан зохион байгуулсан.

8 аймаг, Улаанбаатар хотын 4000 өрхийг хамруулан зохион байгуулсан.

ҮСГ бие даан 8 аймаг, Улаанбаатар хотын 3200 өрхийг хамруулан (4 улирал) анхны судалгааг зохион байгуулсан.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүү, техникийн тусламжтайгаар 7 аймаг, Улаанбаатар хотын 1086 өрхийг хамруулан туршилтын судалгааг зохион байгуулсан.

1.2. СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД БҮТЭЭСЭН ӨГӨГДӨЛ

Цаг ашиглалтын судалгаагаар Монгол Улсын 12 ба түүнээс дээш насны хүн амын өдөр тутмын үйл ажиллагааг хэмжиж, амьдралын хэв маягийг судалдаг. Хүн амын цаг ашиглалтыг хэмжихдээ тодорхой үйл ажиллагаанд нэг өдөрт дунджаар хэдэн минут зарцуулж буйгаар тооцдог.

Цаг ашиглалтын судалгаанд дараах ангиллын дагуу хүн амын цаг ашиглалтын өгөгдлийг бүрдүүлэв.

ЦАГ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Цаг ашиглалтын судалгаанд зориулсан олон улсын цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын² дагуу хүн амын өдөр тутмын үйл ажиллагааг хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа гэж гурав ангилан хэмжих ба эдгээр нь дотроо 9 бүлэг, 52 дэд бүлэг, 165 үйл ажиллагаанд хуваагддаг.

1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

ХУГАЦАА


БАЙРШИЛ


ЗАДАРГАА

² Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал (ЦАСҮАА), НҮБ-ын Статистикийн хэлтэс, 2016 онд шинэчлэгдсэн хувилбар

Судалгаанд санамсаргүйгээр сонгогдсон өрхөөс Өрхийн асуулга (ЦАС-1), Өрхийн асуулга - Утсаар ярилцлага авах (САТI)-д зориулсан хувилбар (ЦАС-1а), Өдрийн тэмдэглэл (ЦАС-2), Өдрийн тэмдэглэл - Утсаар (САТI) эсвэл цахим хуудас (САWI) ашиглахад зориулсан хувилбар (ЦАС-2а)-ийн маягтаар цуглуулсан холбогдох мэдээллийн санг бүрдүүлж, Цаг ашиглалтын судалгаанд зориулсан үйл ажиллагааны ангилал (ЦАСҮАА)-ийн хүрээнд дараах ангилал, задаргааны дагуу өгөгдөл бүрдүүлэв.

Зураг 2. Цаг ашиглалтын судалгааны хүрээнд бүтээсэн өгөгдлийн задаргаа





2

СУДАЛГААНЫ ЗАГВАР



2.1. ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Цаг ашиглалтын судалгаа нь өрхийн түвшинд зах зээлийн бус үйл ажиллагаанд зарцуулж байгаа цагийг тооцож үнэлэх зорилготой ба дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хүн амын амьдралын хэв маяг, түүнд гарч буй өөрчлөлтийг судлах, амьдралын чанарын талаарх мэдээллийг бий болгох, дэд бүтэц болон нийгмийн үйлчилгээний хангамж, хүртээмжийг сайжруулахад шаардагдах мэдээллийг бүрдүүлэх;
- ТХЗ-ын хэрэгжилтийг хянах, ялангуяа эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн талаарх мэдээлэл, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг тодорхойлох мэдээллийг бүрдүүлэх;
- Өрх, хувь хүний нууцлал хангасан мэдээллийн санг хэрэглэгчдэд хүргэх;
- Бодлого боловсруулахад хэрэгцээтэй тоон мэдээллийг бий болгох.

2.2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Цаг ашиглалтын судалгаанд нийгмийн чиглэлийн түүвэр судалгаанд нийтлэг ашигладаг ойлголт, тодорхойлолтыг мөрдлөг болгож, өмнөх судалгаанд ашигласан ойлголт, тодорхойлолт, Хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, Хүн ам, орон сууцны тооллогын асуулга, заавартай уялдуулсан. Мөн судалгааны мэдээлэл цуглуулах асуулгыг боловсруулахад НҮБ-ын Статистикийн комиссоос баталсан олон улсад хэрэглэж байгаа нийтлэг аргачлал, арга зүйг мөрдлөг болгосон.

2.3. ТҮҮВРИЙН АРГА ЗҮЙ

Цаг ашиглалтын судалгааг 2023 онд 2019 онтой харьцуулагдахуйц, үндэсний болон бүсийн түвшинд төлөөлөх чадвартай байхаар түүврийн хэмжээг тооцсон.

Түүврийн хүрээ

Судалгааны хамрах хүрээ нь Монгол Улсын нийт өрх, 12 ба түүнээс дээш насны хүн ам байна. Нийт эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн хүн амын цаг ашиглалтыг үнэлсэн.

Түүврийн нэгж

Судалгааны мэдээлэл цуглуулалтын үндсэн нэгж нь өрх байна. Цэргийн анги, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) иргэдийг өрхийн гишүүнд тооцохгүй.

Судалгааны үр дүнг тархаах түвшин

Судалгааны үр дүнг үндэсний болон бүсийн түвшинд, байршлаар төлөөлөхүйц чадвартай байхаар түүврийн дизайныг боловсруулсан. Аймгийн түвшинд үр дүнг боловсруулах зорилт тавигдаагүй.

Түүврийн хэмжээ

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын бүлэгт хоёр үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцсон. Үүнд:

$$n = \frac{z^2 * r(1-r)}{(RME * r)^2} * deff$$

Үүнд:

n – Шаардлагатай түүврийн хэмжээ

z – 95 хувийн итгэх магадлалд хүргэх утга

r – түлхүүр үзүүлэлтийн эзлэх хувь

$deff$ – түүврийн зохиомжийн нөлөөлөл буюу вариациудын харьцаа, өмнөх судалгаанаас тооцоогүй тохиолдолд 2 байхаар ихэвчлэн сонгодог

RME – 95 хувийн итгэх магадлалын түвшинд таамаглаж байгаа харьцангуй алдаа

Тухайн долоо хоногт дор хаяж нэг удаа гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдийг асрах, өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд оролцох, хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаанд оролцох гэсэн үзүүлэлтүүдийн хувийн жинг хүйсээр ялган түлхүүр болгон тооцооллод ашигласан. Үүнээс хамгийн тохиромжтой түлхүүр үзүүлэлт нь “Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асарч буй 12 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн хувь” байна.

Түлхүүр үзүүлэлтийн хувь 2019 оны ЦАС-ны дүнгээр 12.91 хувь, харьцангуй алдааг 6.1 хувь, судалгаанд хамрагдалтын хувийг судалгааны зохион байгуулалтаас хамааруулан 60 хувь гэж үзэн түүврийн хэмжээг тооцоход улсын хэмжээнд 23236 өрх байна.

Түүврийн хуваарилалт

Судалгааны үр дүнгийн нарийвчлалыг хангахын тулд бүсийн хувьд квадрат язгуурын аргаар, судалгааны бүлэг буюу аймаг, дүүргийн хувьд зохион байгуулалтыг харгалзан тэнцүү хуваарилалтыг хийж гүйцэтгэсэн. Түүврийн хуваарилалт, зохион байгуулалтаас хамааран түүврийн хэмжээг 23394 болгон тэгшитгэв.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдах өрхийн тоо, стандарт алдаа, бүсээр

	Түүвийн хэмжээ	Түлхүүр үзүүлэлт	Харьцангуй алдаа	Итгэх интервал (95%)		Стандарт алдаа
				Доод	Дээд	
Баруун бүс	3,478	11.7	16.6	9.8	13.7	0.010
Хангайн бүс	4,868	8.0	17.4	6.6	9.4	0.007
Төвийн бүс	4,992	9.4	15.7	7.9	10.9	0.007
Зүүн бүс	2,496	15.9	16.5	13.2	18.5	0.013
Улаанбаатар	7,560	19.6	8.3	18.0	21.2	0.008
Улсын дүн	23,394	12.9	6.1	12.1	13.7	0.004

Судалгаанд нийт 324 түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хамруулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төвд утсаар, хөдөөгийн багийн түвшинд нүүр тулсан ярилцлагын хэлбэрээр явуулав.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдах ТАШН-ийн тоо, бүс, аймаг, суурьшлаар

	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт
Баруун бүс		18	11	31	60
Баян-Өлгий		4	3	5	12
Говь-Алтай		3	2	7	12
Завхан		2	2	8	12
Увс		5	1	6	12
Ховд		4	3	5	12
Хангайн бүс		29	17	26	72
Архангай		2	3	7	12
Баянхонгор		5		7	12
Булган		2	6	4	12
Орхон		12			12
Өвөрхангай		4	4	4	12
Хөвсгөл		4	4	4	12
Төвийн бүс		27	21	24	72
Говьсүмбэр		2		1	3
Дархан-Уул		10	2		12
Дорноговь		3	4	2	9
Дундговь		3	1	8	12
Өмнөговь		5	1	6	12
Сэлэнгэ		2	10	0	12
Төв		2	3	7	12
Зүүн бүс		15	9	12	36
Дорнод		7	3	2	12
Хэнтий		4	3	5	12
Сүхбаатар		4	3	5	12
Улаанбаатар	84				84
Багануур, Багахангай, Налайх	12				12
Баянгол	12				12
Баянзүрх	12				12
Сонгинохайрхан	12				12
Сүхбаатар	12				12
Хан-Уул	12				12
Чингэлтэй	12				12
Нийт	84	89	58	93	324

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдах ТАШН, өрхийн тоо, бүс, аймаг, суурьшлаар

	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт
Баруун бүс		1,620	990	868	3,478
Баян-Өлгий		360	270	140	770
Говь-Алтай		270	180	196	646
Завхан		180	180	224	584
Увс		450	90	168	708
Ховд		360	270	140	770

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдах ТАШН, өрхийн тоо, бүс, аймаг, суурьшлаар
(үргэлжлэл)

	Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө	Нийт
Хангайн бүс		2,610	1,530	728	4,868
Архангай		180	270	196	646
Баянхонгор		450	0	196	646
Булган		180	540	112	832
Орхон		1,080	0	0	1,080
Өвөрхангай		360	360	112	832
Хөвсгөл		360	360	112	832
Төвийн бүс		2,430	1,890	672	4,992
Говьсүмбэр		180	0	28	208
Дархан-Уул		900	180	0	1,080
Дорноговь		270	360	56	686
Дундговь		270	90	224	584
Өмнөговь		450	90	168	708
Сэлэнгэ		180	900	0	1,080
Төв		180	270	196	646
Зүүн бүс		1,350	810	336	2,496
Дорнод		630	270	56	956
Хэнтий		360	270	140	770
Сүхбаатар		360	270	140	770
Улаанбаатар	7,560				7,560
Багануур, Багахангай, Налайх	1,080				1,080
Баянгол	1,080				1,080
Баянзүрх	1,080				1,080
Сонгинохайрхан	1,080				1,080
Сүхбаатар	1,080				1,080
Хан-Уул	1,080				1,080
Чингэлтэй	1,080				1,080
Нийт	7,560	8,010	5,220	2,604	23,394

Түүврийн үе шат

Түүврийг үндсэн 2 үе шаттай хийсэн бөгөөд сүүлийн нэмэлт шатанд сонгогдсон өрхөөс судалгаанд оролцох боломжтой 12, түүнээс дээш насны нэг гишүүнийг санамсаргүйгээр сонгосон (зөвхөн Улаанбаатар хот, аймгийн төв, сумын төвийн түвшинд).

Эхний үе шатанд үүсгэсэн судалгааны бүлгийн нийт баг, хэсгийн жагсаалтаас харгалзах тооны түүврийн анхан шатны нэгж буюу кластеруудыг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргыг ашиглан сонголтыг хийсэн. Энд судалгааны ТАШН-ээр аймаг, дүүргийн баг, хэсгийг сонгосон.

Хоёрдугаар шатанд сонгогдсон ТАШН-ийн өрхийн жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт бэлтгүүлэн хүлээн авч, энгийн санамсаргүй/системт түүврийн аргыг ашиглан кластер бүрээс 90 (Улаанбаатар, аймгийн төв, сумын төв) болон 28 (хөдөө) өрхийг сонгосон.

Улаанбаатар, аймгийн төв, сумын төвийн түвшинд сонгогдсон өрхийн 12, түүнээс дээш насны судалгаанд хамрагдах боломжтой иргэдээс Кишийн аргыг ашиглан нэг гишүүнийг сонгож судалгаанд хамруулсан.

Түүврийн жин

Үр дүнгийн тооцоо, дүн шинжилгээ хийхэд түүврийн жинг тооцож ашигласан. Түүврийн жинг тооцоход дараах тоо мэдээлэл шаардлагатай. Үүнд:

- Кластерын тоо
- Сонгогдсон кластерын өрхийн тоо
- Сонгогдсон өрхөөс судалгаанд хамрагдсан 12, түүнээс дээш насны хүн амын тоо

Түүврийн жинг уг судалгааны зорилгоос хамааруулан өрхийн түвшинд болон 12 ба түүнээс дээш насны хүн амын дунд тооцох шаардлагатай. Түүврийн жин нь тухайн шатанд сонгогдсон элементүүдийн магадлалын урвуу хэмжигдэхүүн байх бөгөөд дараах байдлаар тооцсон:

Өрхийн жин тооцох:

Нэгдүгээр шатны түүврийн жин:

$$W_{1k} = \frac{A_k}{A_{ks}} \quad \begin{array}{l} A_k - k \text{ дугаар бүлгийн нийт өрхийн тоо} \\ A_{ks} - k \text{ дугаар бүлгээс сонгогдсон } s \text{ ширхэг кластерын нийт өрхийн тоо} \end{array}$$

Хоёрдугаар шатны түүврийн жин:

$$W_{2kj} = \frac{M_{kj}}{m_{kj}} \quad \begin{array}{l} M_{kj} - k \text{ бүлгийн } j \text{ кластерын нийт өрхийн тоо} \\ m_{kj} - k \text{ бүлгийн } j \text{ кластерын судалгаанд хамруулахаар төлөвлөсөн өрхийн тоо} \end{array}$$

Өрхийн түвшний түүврийн суурь жин нь дээрх 2 жингийн үржвэр байна:

$$W_{kj} = \frac{A_k}{A_{ks}} * \frac{M_{kj}}{m_{kj}}$$

Хамрагдаагүй түвшнээр засварласан жин:

$$W_{kj'} = \frac{A_k}{A_{ks}} * \frac{M_{kj'}}{m_{kj'}} * B_{nr}$$

Энд B_{nr} нь судалгаанд хамрагдсан өрхийн тоо болон судалгаанд хамруулахаар төлөвлөсөн өрхийн тооны харьцаагаар илэрхийлэгдэх тохируулагч үржүүлэгч байна.

$$B_{nr} = \frac{m_{kj'}}{m_{kj}} \quad m_{kj'} - k \text{ бүлгийн } j \text{ кластерын судалгаанд хамрагдсан өрхийн тоо}$$

Хувь хүний жин (12, түүнээс дээш насны)

Хувь хүний түүврийн суурь жин нь өрхийн суурь жинг өрхөд байгаа судалгаанд хамрагдах боломжтой хүн амын тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

$$W_{kjl} = W_{kj} * C_{kjl} \quad C_{kjl} - k \text{ бүлгийн } j \text{ кластерийн } l \text{ өрхөд байгаа } 12, \text{ түүнээс дээш насны хүний тоо}$$

Хариулагдаагүй түвшнээр засварласан жин:

$$W_{kjl'} = W_{kj} * C_{kjl'} * D_{nr}$$

Энд D_{nr} нь судалгаанд хамрагдсан хүний тоо болон судалгаанд хамруулахаар төлөвлөсөн хүний тооны харьцаагаар илэрхийлэгдэх тохируулагч үржүүлэгч байна.

$$D_{nr} = \frac{C_{kjl'}}{C_{kjl}} \quad C_{kjl'} - k \text{ бүлгийн } j \text{ кластерын } l \text{ өрхөөс судалгаанд хамрагдсан хүний тоо}$$

2.4. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

Маягт, маягт нөхөх заавар

Цаг ашиглалтын судалгааны асуулга нь 2 үндсэн маягт болох Өрхийн асуулга (ЦАС-1, ЦАС-1а), Өдрийн тэмдэглэл (ЦАС-2, ЦАС-2а)-ээс бүрдэнэ. Мөн судалгааны ахлагч, хянагч, мэдээлэл цуглуулагч нарт зориулсан “Цаг ашиглалтын судалгаа”-ны асуулгын маягт нөхөх заавар багтана.

Мэдээлэл цуглуулах арга

Нийслэл, аймгийн төв, сумын төвийн өрхийн хувьд ярилцлага өгөгчийн сонголтоор телефон утсаар судалгаа авах (Computer assisted telephone interview - CATI) эсвэл компьютерт суурилсан цахим ярилцлага авах (Computer Assisted Web Interview - CAWI) аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан. Хөдөөгийн өрхүүдийн хувьд таблет ашиглан ярилцлага хийх (Computer Assisted Personal Interview - CAPI) болон цаасан асуулга ашиглан ярилцлага хийх (Paper Assisted Personal Interview - PAPI) аргыг хослуулан ашигласан.

Судлагдах нэгж

Судалгаа явагдах хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрийн тухайн өрхөд 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдарч байгаа эсвэл 6 сар хүрээгүй боловч цаашид 6, түүнээс дээш сарын хугацаагаар амьдрах гишүүд нь судалгааны судлагдах нэгж байна.

Мэдээлэл цуглуулалт


Цаг ашиглалтын судалгаа хариуцсан нэгж нь уг судалгааг зохион явуулах ба судалгааны бэлтгэл ажлыг хангах, ахлагч, хянагч, мэдээлэл цуглуулагч нарт сургалт хийх, судалгааг зохион явуулах, мэдээллийн санг нэгтгэн үр дүнг тооцох ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Мэдээлэл цуглуулах үе шат

1. Мэдээллийн технологи хариуцсан нэгж нь ХАӨМС-гаас түүвэрт сонгогдсон өрхийн жагсаалтыг бэлтгэж, судалгаа хариуцсан нэгжид хүргүүлнэ.
2. Судалгаа хариуцсан нэгж нь аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст өрхийн жагсаалтыг хүргүүлж, тухайн өрх байршилдаа байгаа эсэх, өрхийн гишүүдийн утасны лавлагаа, тодруулгыг сар тутам авна.
3. Хэрэв үндсэн өрх тухайн байршил дээр байхгүй тохиолдолд хаяг дээр байгаа өрхийн гишүүдийн ХАӨМС-гийн өрхийн бүртгэлийн дугаар, овог, нэр, утасны дугаарыг авна.
4. Судалгаа хариуцсан нэгж нь нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөөд судалгааг авах нийслэл, аймгийн нэгжийн тооны тодруулгыг хийнэ. Сар тутам 27 нэгжээс мэдээлэл цуглуулна.
5. Ирүүлсэн тодруулгын дагуу өрхийн мэдээллийг шинэчилж, жагсаалтыг бэлтгэн, эцэслэсэн өрхийн жагсаалтыг аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтэст илгээнэ.
6. Мэдээлэл цуглуулагч нь хүлээн авсан асуулгыг компьютерт шивж, эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, ажил мэргэжлийн ангиллыг кодолно.
7. Багийн ахлагч хянаж, мэдээлэл цуглуулагч мэдээллийг ҮСХ-ны төв серверт дамжуулна.

Мэдээлэл боловсруулалт

CSPro программ хангамж ашиглан ЦАС-ны мэдээллийн сан үүсгэн, мэдээллийг боловсруулахдаа “Ждеметра+” программ хангамж ашиглан улирлын нөлөөллийг арилган, SPSS/STATA/RStudio статистикийн программ хангамжийг ашиглан боловсруулалт хийсэн.



3

СУДАЛГААНД
ХАМРАГДАГЧ



СУДАЛГААНЫ ХАМРАЛТ

Цаг ашиглалтын судалгааны түүвэрт сонгогдсон 23394 өрхөөс судалгаанд 15076 өрх хамрагдаж, хамралтын хувь 64.4 хувь байв.

Хүснэгт 4. ЦАС-нд хамрагдсан өрхийн тоо, бүсээр

	Хамрагдалтын хувь	Түүврийн хэмжээ	Түүврийн хүрээ
Бүс			
Баруун бүс	76.3	2,653	3,478
Хангайн бүс	71.9	3,499	4,868
Төвийн бүс	66.1	3,302	4,992
Зүүн бүс	73.4	1,833	2,496
Улаанбаатар	50.1	3,789	7,560
Улсын дундаж	64.4	15,076	23,394

3.1. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХ

Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 47.3 хувь нь нийслэлд, 18.2 хувь нь Хангайн бүсэд, 15.9 хувь нь Төвийн бүсэд, 11.4 хувь нь Баруун бүсэд, 7.2 хувь нь Зүүн бүсэд амьдардаг өрхүүд байна. Суурьшлаар судалгаанд хамрагдсан өрхийн 47.3 хувь нь нийслэлд, 20.8 хувь нь аймгийн төвд, 11.6 хувь нь сумын төвд, 20.3 хувь нь хөдөөд амьдарч байна.

Нийт өрхийн 52.3 хувь нь 3 хүртэл гишүүнтэй бол 47.7 хувь нь 4 ба түүнээс дээш гишүүнтэй.

Сууцны төрлөөр судалгаанд хамрагдсан өрхийн 34.4 хувь нь гэрт амьдардаг, 34.3 хувь нь орон сууцны байшинд, 29.7 хувь нь сууцны тусдаа байшинд, 0.5 хувь нь бие даасан тохилог сууцанд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.

Нийт өрхийн 81.0 хувь нь цахилгааны төвлөрсөн системд холбогдсон бол 0.7 хувь нь цахилгааны эх үүсвэргүй амьдарч байна. Мөн өрхүүдийн 13.1 хувь нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр цахилгаанаа шийдэж байна. Халаалтын төвлөрсөн системд нийт өрхийн 36.2 хувь нь холбогдсон бол 55.6 хувь нь ердийн галлагаа, 5.4 хувь нь нам даралтын зуух, 2.7 хувь нь цахилгаан халаагуур ашиглаж байна.

Хүснэгт 5. Судалгаанд хамрагдсан өрхийн тоо, хувь, сонгосон үзүүлэлтээр

	Дүнд эзлэх хувь	Өрхийн тоо	Жинлэсэн өрхийн тоо
Бүс			
Баруун бүс	11.4	2,653	111,637
Хангайн бүс	18.2	3,499	179,321
Төвийн бүс	15.9	3,302	156,784
Зүүн бүс	7.2	1,833	70,684
Улаанбаатар	47.3	3,789	465,059
Суурьшил			
Нийслэл	47.3	3,789	465,059
Аймгийн төв	20.8	5,353	204,489
Сумын төв	11.6	3,381	113,819
Хөдөө	20.3	2,553	200,118
Өрхийн ам бүлийн тоо			
1	15.6	2,402	153,638
2	19.3	3,083	189,315
3	17.4	2,609	171,264
4	19.8	2,896	194,751
5	15.0	2,205	147,338
6+	12.9	1,881	127,180
Өрхийн амьдарч буй сууцны төрөл			
Гэр	34.4	5,530	339,104
Орон сууцны байшин	34.3	3,884	336,930
Бие даасан тохилог сууц	0.5	132	5,074
Сууцны тусдаа байшин	29.7	5,343	292,579
Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)	0.7	120	6,409
Зориулалтын бус сууц	0.2	18	1,481
Бусад сууц	0.2	49	1,908
Цахилгаан эрчим хүчний эх үүсвэр			
Төвлөрсөн систем	81.0	12,440	797,042
Дизель станц	0.1	22	1,397
Сэргээгдэх эрчим хүч	13.1	2,016	128,872
Бага оврын цахилгаан үүсгүүр	5.0	511	49,239
Цахилгааны эх үүсвэргүй	0.7	87	6,935
Халаалтын эх үүсвэр			
Төвлөрсөн систем	36.2	4,312	356,273
Нам даралтын зуух	5.4	962	52,791
Ердийн галлагаа	55.6	9,465	547,552
Цахилгаан халаагуур	2.7	331	26,440
Бусад	0.1	6	429


3.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХҮН АМ

Судалгаанд хамрагдсан хүн амын 54.7 хувь нь эмэгтэй, 45.3 хувь нь эрэгтэй хүн байна. Насны бүлгийн хувьд 9.4 хувь нь 12-17 настай, 5.7 хувь нь 18-24 настай, 6.6 хувь нь 25-29 настай, 23.0 хувь нь 30-39 настай, 18.7 хувь нь 40-49 настай, 17.2 хувь нь 50-59 настай, 12.6 хувь нь 60-69 настай, 6.8 хувь нь 70 ба түүнээс дээш настай хүн амын төлөөлөл байна.


Хүн амын боловсролын түвшинг харвал 30.2 хувь нь дээд боловсролтой, 5.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.9 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой ажээ. Харин 57.4 хувь нь бүрэн дунд болон түүнээс бага боловсролтой байна.

Нийт хүн амын 57.5 хувь нь гэрлэсэн бөгөөд гэр бүлээ батлуулсан, 9.1 хувь нь гэрлэсэн боловч гэрлэлтээ батлуулаагүй байна. Харин хүн амын 15.5 хувь нь огт гэрлээгүй, 17.9 хувь нь тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн төлөвтэй байна.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан хүн ам, насны бүлгээр




Зураг 4. Судалгаанд хамрагдсан хүн ам, хүйсээр



Хүснэгт 6. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12, түүнээс дээш насны хүн амын тоо, хувь, сонгосон үзүүлэлтээр

	Дүнд эзлэх хувь	Хүн амын тоо	Жинлэсэн хүн амын тоо
Бүс			
Баруун бүс	12.2	3,609	301,611
Хангайн бүс	18.1	4,072	448,634
Төвийн бүс	15.3	3,689	378,847
Зүүн бүс	6.8	2,081	167,662
Улаанбаатар	47.6	3,790	1,176,730
Суурьшил			
Нийслэл	47.6	3,790	1,176,730
Аймгийн төв	21.8	5,355	539,344
Сумын төв	10.5	3,381	259,437
Хөдөө	20.1	4,715	497,973
Хүйс			
Эрэгтэй	45.3	7,814	1,120,120
Эмэгтэй	54.7	9,427	1,353,364
Насны бүлэг			
12-17	9.4	1,656	230,147
18-24	5.7	993	142,203
25-29	6.6	1,180	163,614
30-39	23.0	3,780	569,312
40-49	18.7	3,259	462,039
50-59	17.2	3,107	424,789
60-69	12.6	2,154	311,974
70+	6.8	1,112	169,407
Боловсрол			
Боловсролгүй	2.9	625	70,979
Бага	9.0	1,966	221,706
Суурь	13.4	2,852	331,524
Бүрэн дунд	32.1	5,717	797,007
Техникийн болон мэргэжлийн	6.9	972	169,677
Тусгай мэргэжлийн дунд	5.5	958	135,643
Дээд	30.2	4,151	746,948
Гэрлэлтийн байдал (15, түүнээс дээш насны хүн ам)			
Огт гэрлээгүй	15.5	2,531	361,523
Гэрлэсэн - батлуулсан	57.5	9,722	1,344,194
Гэрлэсэн - батлуулаагүй	9.1	1,290	212,754
Тусгаарласан	2.5	325	58,042
Цуцалсан	3.0	415	70,663
Бэлэвсэн	12.4	1,984	289,266
Ярилцлага авсан хэлбэр			
Уулзаж ярилцлага авах (CAPI, PAPI)	20.1	4,715	497,973
Утсаар ярилцлага авах (CATI)	79.9	12,526	1,975,511



4

ХҮН АМЫН ЦАГ
АШИГЛАЛТ



ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТЫГ ХЭМЖИХ НЬ


Цаг хугацаа нь аливаа үйлийн үргэлжлэх хугацааны хэмжүүр болдог. Цаг хугацааг хэмжсэнээр үйл ажиллагааг жишиж харьцуулах, эрэмбэлэх боломжтой болно.

Цаг хугацааны хэмжүүр хүн бүрийн хувьд ижил хэдий ч нийгэм, соёл, эдийн засгийн нөхцөл байдал, хувь хүний онцлог, сонголт зэрэг олон хүчин зүйлээс хамааран хүн амын цаг ашиглалт ялгаатай. Энэ ялгааг хэмжих нь хүн амын амьдралын хэв маяг, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн зүй тогтол, ижил төстэй болон ялгаатай байдлыг судлахад тусална.

Цаг ашиглалтын судалгаа нь Монгол Улсын 12 ба түүнээс дээш насны хүн амын өдөр тутмын үйл ажиллагааг хэмжиж, амьдралын хэв маягийг зурагладаг.

| - 1 минут

24 цаг 1440 МИНУТ



Хүн амын цаг ашиглалтыг хэмжихдээ тодорхой үйл ажиллагаанд өдөрт дунджаар хэдэн минут зарцуулж буйгаар тооцдог. Өдрийн **24 цаг** нь **1440 минут** болох ба, энэхүү 1440 минутыг ямар үйл ажиллагаанд, хэрхэн зарцуулж буйг тооцсон.

Хүн амын дундаж нэг өдрийг долоо хоногийн нэг өдөр, ажлын нэг өдөр, амралтын нэг өдөр гэсэн гурван түвшинд авч үздэг.

Хүмүүсийн өдөр тутамдаа хийдэг үйл ажиллагаанууд нь маш олон янз байх боломжтой бөгөөд хүн амын цаг ашиглалтыг хооронд нь харьцуулахад хялбар байх үүднээс нэгдсэн ангилал буюу олон улсын цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангиллыг³ ашигладаг.

Өдөр тутмын үйл ажиллагааг хөлстэй хөдөлмөр эрхлэх, хөлсгүй хөдөлмөр эрхлэх, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа гэж гурав ангилна. Энэ гурван ангилал нь дотроо 9 бүлэг, 56 дэд бүлэг, 165 үйл ажиллагаанд хуваагддаг.

1. ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


2. ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ийнхүү цаг ашиглалтын судалгаагаар 12 ба түүнээс дээш насны хүн ам цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд долоо хоногийн нэг өдөр, ажлын нэг өдөр, амралтын нэг өдрийн 24 цаг буюу 1440 минутыг хэрхэн зарцуулж байгааг тооцдог.

Хүн амын цаг ашиглалтын ялгаатай байдлыг судлах зорилгоор хүйс, нас, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гэрлэлтийн байдал, амьдарч буй нутаг дэвсгэр гэх мэт олон үзүүлэлтээр нарийвчлан хэмждэг.

3. ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОН ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

³Цаг ашиглалтын статистикт зориулсан үйл ажиллагааны ангилал (ЦАСҮАА), НҮБ-ын Статистикийн хэлтэс, 2016 онд шинэчлэгдсэн хувилбар



Цаг ашиглалтын үйл ажиллагааны дэлгэрэнгүй ангиллыг Хавсралт 3-аас харна уу.

ДҮРСЛЭЛ 1.
ЦАГ АШИГЛАЛТ,
УЛСЫН ДУНДАЖ



Долоо хоногийн
нэг өдөрт 12,
түүнээс дээш
насны хүн амын
дундаж цаг
ашиглалт, үйл
ажиллагаагаар,
минутаар, 2023

276


ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

211

953



ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА





ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ
БОЛОН ХУВИЙН
ХЭРЭГЦЭЭНИЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

| - 1 минут

1440

МИНУТ



— 1 МИНУТ

Дүрслэл 2.
ЦАГ АШИГЛАЛТ, УЛСЫН ДУНДАЖ

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



4.1.

ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ


Хүн бүрийн хувьд өдөр бүр адилхан 24 цаг бий. Гэхдээ энэ 24 цагийг бүгд өөр өөрөөр ашиглах боломжтой. Хаана амьдарч байгаа, ямар ажил хийдэг, амьдралынхаа ямар мөчлөг дээр яваа, “Хэн бэ?” гэдгээсээ хамаарч цагаа янз бүрээр төлөвлөж, зарцуулдаг. Цагийг хэрхэн ашиглах нь хувь хүний сонголт боловч эргэн тойрны нөхцөл, нийгэм, эдийн засгийн байдлаас хамаарч өөрийн сонголт, хүслээс үл хамааран тодорхой үйл ажиллагаанд цагаа заавал зарцуулах шаардлага ч гардаг.

Монгол хүн гэж хэн бэ? Монгол хүн цагаа хэрхэн ашиглаж байгаа нь энэ асуултын тодорхой хэсгийн хариулт болж болох юм. Монгол хүний амьдралын хэв маяг ямар вэ? Хоорондоо хэр ялгаатай вэ? Эдгээр асуултын хариуг цаг ашиглалтын судалгааны үр дүнгээс олж болно.

ЦАГ АШИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Хүний биологийн болон нийгмийн хэрэгцээнээс хамааран цаг ашиглалтад нийтлэг зүйлс бий. Хооллох, амрах зайлшгүй хэрэгцээ, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх хэрэгцээ бүгдэд байдаг. Энэ бүх хэрэгцээнүүдэд Монголчууд цагаа хэрхэн хуваарилдаг вэ?

Дүрслэл 3. Цаг ашиглалт, улсын дундаж
Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




МОНГОЛ ХҮНИЙ ДУНДАЖ НЭГ ӨДРИЙН 24 ЦАГИЙН 51.0 ХУВЬ НЬ ЗАЙЛШГҮЙ ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНД, 33.8 ХУВЬ НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД, 15.1 ХУВЬ НЬ БОЛОВСРОЛ БОЛОН ЧӨЛӨӨТ ЦАГТ ЗАРЦУУЛАГДДАГ.

2023 оны байдлаар улсын дунджаар 12 ба түүнээс дээш насны хүн амын долоо хоногийн нэг өдрийн цаг ашиглалтын дүр зургийг харвал 12 цаг 15 минутыг унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээнд, 4 цаг 36 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 3 цаг 31 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 32 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж, үлдсэн 3 цаг 6 минут нь чөлөөт цагт зориулагдаж байна.

Хүн амын цаг ашиглалтын хувьслыг харвал 2019 онтой харьцуулахад хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цаг буурч, хувийн хэрэгцээний цаг нэмэгдэх хандлагатай болжээ. Тодруулбал, хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд долоо хоногийн нэг өдөрт зарцуулдаг дундаж цаг 32 минутаар буурч, эсрэгээрээ хувийн хэрэгцээнд зориулсан цаг 50 минутаар нэмэгдсэн байна. Хувийн хэрэгцээний цагийн өсөлт нь унтах цаг 20 минут, бусад хувийн хэрэгцээний цаг (хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт) 30 минутаар нэмэгдсэнтэй холбоотой.

Түүнчлэн хувийн хэрэгцээний цаг нэмэгдсэнтэй холбоотой чөлөөт цаг 10 минутаар, боловсролд зарцуулсан цаг 6 минутаар тус тус хумигдсан байна.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй. Гэрийн ажил хийх, хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдийг асрах гэх мэт хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 3 цаг 31 минут зарцуулж буй нь 4 жилийн өмнөхөөс ердөө 3 минут буурсан байна.



Дүрслэл 4.
Цаг ашиглалт,
улсын дундаж, ЦАС
явагдсан оноор


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар

* 2011, 2015 оны ЦАС-ны үр дүнг тооцоход жин ашиглаагүй бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон.

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛСАН ЦАГИЙН 76.4 ХУВЬТАЙ ТЭНЦЭХҮЙЦ ЦАГИЙГ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛДАГ.

Дүрслэл 5. Цаг ашиглалт, улсын дундаж

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Хөдөлмөр эрхлэлт нь амьдралын нэг салшгүй хэсэг. 12 ба түүнээс дээш насны Монгол хүн хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн ойролцоогоор гуравны нэгийг буюу өдөрт дунджаар 8 цаг 7 минутыг зарцуулсан байна. Энэ нь сэрүүн байх нийт цаг (14 цаг 28 минут)-ийн талаас илүү буюу 56.1 хувийг бүрдүүлжээ.


12 ба түүнээс дээш насны хүн ам хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 4 цаг 36 минут зарцуулсан бөгөөд үүний 71.4 хувь (3 цаг 17 минут) нь ААНБ-д ажиллах гэх мэт гэрээт хөдөлмөр эрхлэлтэд зарцуулагдсан бол 28.6 хувь (1 цаг 19 минут) нь уламжлалт амьдралын хэв маягтай уялдсан мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаа зонхилсон өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдаж байна.

Харин хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 31 минут зарцуулсны дийлэнх нь буюу 73.5 хувь (2 цаг 35 минут) нь гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд туслахад зарцуулагджээ. Асрах ажлын тухайд хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан нийт цагийн 19.4 хувь (41 минут) нь хүүхэд асрах, 3.8 хувь (8 минут) нь өрхийн бусад гишүүдийг асрахад зориулагддаг. Сайн дурын ажилд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 минутыг хуваарилдаг.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цаг нь хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан цагийн 76.4 хувьтай тэнцэхүйц буюу ийм хэмжээний хөдөлмөр эдийн засгийн хувьд ямар нэг байдлаар үнэлэгдээгүй байна. Хүн амын хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн цаг 2019 оны цаг ашиглалтын судалгааны үр дүнтэй харьцуулахад төдийлөн өөрчлөгдөөгүй, бүтцийн хувьд ч хэвээр байгаа нь хөлсгүй хөдөлмөрийг хөнгөвчлөх, орлуулах төрлийн үйлчилгээ авахаас илүү гэр бүлийн гишүүд өөрсдөө хийх хандлагатайг харуулж байна. Өөрөөр хэлбэл хөлсгүй хөдөлмөр хөлстэй хөдөлмөрт шилжих өөрчлөлт явагдахгүй байна гэж дүгнэж болохоор байна.


Дүрслэл 6. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 7. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ХҮН АМЫН ЧӨЛӨӨТ ЦАГАА ӨНГӨРҮҮЛДЭГ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ АШИГЛАХ.

Дүрслэл 8. Цаг ашиглалт, улсын дундаж

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын дагуу хөдөлмөр эрхлэхээс бусад цаг нь суралцах, хүмүүстэй харилцах, чөлөөт цаг болон зайлшгүй хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд хамаарна. Үүнд 12 ба түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 15 цаг 53 минут зарцуулж байгаагаас 77.1 хувь нь буюу 12 цаг 15 минут нь зайлшгүй хувийн хэрэгцээнд зарцуулагддаг. Хүн амын хамгийн их цаг зарцуулдаг үйл ажиллагааны нэг болох унтах, амрах, босохтой холбоотой үйл ажиллагаанд зарцуулах цаг болон хооллох, бусад хувийн хэрэгцээний цаг үүнд багтаж буй. Монголчууд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 9 цаг 32 минутыг унтах, амрах, босохтой холбоотой үйл ажиллагаанд зарцуулж, 1 цаг 26 минут хооллож, 1 цаг 17 минутыг бусад хувийн хэрэгцээнд зарцуулжээ.

Боловсролын үйл ажиллагаа буюу суралцахад өдөрт дунджаар 32 минут зарцуулсан байна. Мөн хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцоход өдөрт дунджаар 24 минутыг тусгайлан зориулжээ.

Ингээд үлдсэн 2 цаг 42 минут нь чөлөөт цаг буюу хобби, спорт, соёлын үйл ажиллагаанд оролцох боломжтой цаг. Монголчууд чөлөөт цагаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад ихэвчлэн хуваарилж байна. Тодруулбал, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийн 72.8 хувь (өдөрт дунджаар 1 цаг 58 минут)-ийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан өнгөрүүлжээ. Харин хобби, спорт, соёлын үйл ажиллагаанд үүнээс 4.9 дахин бага буюу өдөрт дунджаар 24 минут зарцуулсан байна. Үүнийг задалж харвал спортоор хичээллэхэд өдөрт дунджаар 9 минут зарцуулж, 2 минутыг спорт, соёлын арга хэмжээнд оролцох, үзэхэд зориулж байна. Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд 13 минут зориулагджээ.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах үйл ажиллагаа нь унших, үзэх, сонсох байдлаар мэдээлэл авах бүх хэлбэрүүдийг багтааж буй. Үүнд өдөрт зарцуулж буй 1 цаг 58 минутаас биет байдлаар ном, сонин, сэтгүүл уншихад зарцуулсан цагийг ялгаж харвал ердөө 3 минут байна. Зурагт, радио, гар утас, ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан мэдээлэл авах нь илүү түгээмэл ажээ.

Дүрслэл 9. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа
 Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

32

Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох


24

Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

162

Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

735



ӨӨРИЙГӨӨ
 ХӨГЖҮҮЛЭХ
 БОЛОН
 ХУВИЙН
 ХЭРЭГЦЭЭ
 953

АМРАЛТЫН ӨДӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БУУРДАГГҮЙ, ХАРИН ХӨЛСТЭЙГӨӨС ХӨЛСГҮЙД ШИЛЖДЭГ.


Цаг ашиглалтын хэв маяг ажлын болон амралтын өдрүүдэд ялгаатай ч амралтын өдөр хөдөлмөр эрхлэлт төдийлөн их хэмжээгээр буурдаггүй. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн нийлбэр дүнгээр авч үзвэл хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг амралтын өдрүүдэд 5.1 хувь (25 минут)-иар буурсан байна.

Хүмүүс амралтын өдрүүдэд ч хөлстэй хөдөлмөр эрхэлж, тодорхой цагийг зарцуулсаар байдаг. Мөн амралтын өдөр хөлсгүй хөдөлмөрт илүү цаг төлөвлөдөг.

Дүрслэл 10. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, ажлын болон амралтын өдрөөр


12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

| — 1 минут



Ажлын өдөр хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд дунджаар 4 цаг 50 минут зарцуулдаг бол амралтын өдөр энэ цаг 20.3 хувь (59 минут)-иар буурч, 3 цаг 51 минут зарцуулж байна. Амралтын өдөр хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаан дотроос ААНБ-д ажиллах давамгайлсан хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг 34.0 хувь (1 цаг 13 минут)-иар буурч, харин өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулсан цаг 18.7 хувь (14 минут)-иар нэмэгджээ. Мал аж ахуй эрхлэх, ногоо тарих гэх мэт өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа нь ажлын, амралтын өдөр ялгаагүй цаг зарцуулах шаардлагатай байдаг онцлогтой. Түүгээр зогсохгүй энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг амралтын өдөр нэмэгдэх буюу хөлстэй хөдөлмөр нь бүтцийн хувьд амралтын өдөр ААНБ-д ажиллах гэх мэт гэрээт хөдөлмөр эрхлэлтээс өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа руу шилжих хандлагатай байна.


Амралтын өдөр хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанаас хэмнэгдэж буй цагийн багагүй хэсэг нь хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа руу хуваарилагддаг. Хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд ажлын өдөр дунджаар 3 цаг 23 минут зарцуулдаг бол энэ нь амралтын өдөр 16.7 хувь (34 минут)-иар нэмэгдэж, 3 цаг 57 минутыг зарцуулж байна. Гэрийн ажил давамгайлсан хөлсгүй хөдөлмөрийг гэр бүлийн гишүүд өөрсдөө хийх хандлагатайн дээр амралтын өдрүүдэд хөлсгүй хөдөлмөртэй холбоотой үйл ажиллагаанд илүү их цаг төлөвлөдөг.



Дүрслэл 11. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, ажлын болон амралтын өдрөөр

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

38

14

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

22

32

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

156

180

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	4
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	12	17
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	9	10
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	115	129
- Бусад	18	20

3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

731

746

- Унтах, амрах, босох	569	583
- Хооллох, цай уух	85	88
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	45	46
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	6	3
- Бусад	26	26

Ялангуяа хувцас, гутал угаах, арчлах цаг илүү их нэмэгдэх хандлагатай. Үүний дараа гэр цэвэрлэх, хоол хийх цагууд амралтын өдөр нэмэгддэг.

Асрах ажил буюу хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх мэт гэр бүлийн гишүүдийг асрахад зарцуулсан нийт цаг амралтын өдөр ажлын өдрөөс 4 минутаар буурч байна. Энэ нь амралтын өдрүүдэд асрах ажил буурдагтай холбоотой гэхээс илүү хөлсгүй хөдөлмөр гэх мэт бусад ажлыг хийх зуураа асрах ажлыг хамтатган хийх байдлаар зохицуулдагтай холбоотой байж болох юм.

Цалин хөлсгүй, сайн дурын ажилд зарцуулах цаг амралтын өдөр бага зэрэг нэмэгддэг. Ийм зорилгоор ажлын өдөр дунджаар 6 минут зарцуулдаг бол амралтын өдөр 8 минут зарцуулж байна.

Амралтын өдөр хөдөлмөр эрхлэлт хөлтэйгөөс хөлсгүйд шилждэг тул чөлөөт цаг төдийлөн ахиу нэмэгддэггүй. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан цаг амралтын өдөр ажлын өдрийн дундажтай харьцуулахад 2.6 хувиар буюу 25 минутаар нэмэгдэж байна.

Унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээний цаг ажлын өдөртэй харьцуулахад амралтын өдөр 15 минут нэмэгджээ. Энэ өөрчлөлт нь унтах, амрах цагт илүү их хуваарилагдах буюу амралтын өдөр өдөрт дунджаар 14 минутаар илүү цагийг унтаж, амрахад зориулж байна.

Боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зарцуулах цаг амралтын өдөр хамгийн их буюу 63.2 хувь (24 минут)-иар буурч, энэ хэмнэсэн цаг нь чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа, хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцох цаг руу шилжих хандлагатай. Гэхдээ дийлэнхдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах үйл ажиллагаа руу хуваарилагдаж байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах цаг амралтын өдөр ажлын өдрөөс 12.2 хувь (14 минут)-иар нэмэгдэж буй нь энэ үйл ажиллагаа хүмүүсийн чөлөөт цагаа зарцуулах гол сонголтын нэг болохыг илтгэж байна.

Монголчууд спортоор хичээллэхэд тусгайлан цаг гаргах нь бага хэдий ч амралтын өдөр энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг дунджаар 1 минутаар нэмэгдэж, 10 минутыг спорт хийхэд зориулжээ. Спортоор хичээллэх цагийг зориуд төлөвлөхөөс илүү бусад үйл ажиллагааг эрхлэх зуураа хөдөлгөөн хийх хэрэгцээгээ хангадаг байж болох юм.

Соёл, спортын арга хэмжээ болон хобби, бусад чөлөөт цагийн арга хэмжээнд мөн л төдийлөн их цаг зарцуулдаггүй ч амралтын өдөр эдгээр үйл ажиллагаанд зарцуулах цаг тодорхой хэмжээгээр нэмэгддэг. Соёл, спортын арга хэмжээнд зарцуулах цаг 2 минутаар нэмэгдэж 4 минут, хобби, бусад чөлөөт цагт зориулах цаг 5 минутаар нэмэгдэж 17 минут болдог ажээ.

МОНГОЛ ОРНЫ ХААНА АМЬДАРЧ БАЙГААГААС ХАМААРАН ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТ ЯЛГААТАЙ.


Монгол орны нутаг дэвсгэр өргөн уудам, хотын болон хөдөөгийн нийгэм, эдийн засаг, соёлын ялгаа зэрэгцэн оршдог онцлогтой. Харин энэ ялгаа хүн амын амьдралын хэв маягт хэр тод илэрч байна вэ?

Хамгийн том ялгаа нь хөдөөд хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хотынхоос илүү их цаг зарцуулдаг. Хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд хотын хүн ам өдөрт дунджаар 7 цаг 47 минут зарцуулдаг бол хөдөөд 13.9 хувь (65 минут)-иар илүү буюу 8 цаг 52 минутыг зарцуулдаг. Энэ нь хот, хөдөөгийн амьдрах хэв маягийн онцлогтой холбоотой бөгөөд ихэвчлэн хөлстэй хөдөлмөр эрхлэлт, тэр дундаа өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах цагт илүү тод ялгаа ажиглагдаж байна.

Дүрслэл 12. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хот, хөдөөгөөр


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

| — 1 минут



Хотод ААНБ-д ажиллах зонхилсон хөлстэй хөдөлмөр давамгайлдаг бол хөдөөд мал маллах зонхилсон өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөлстэй хөдөлмөр давамгайлдаг. Тодруулбал, ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд хотод амьдардаг 12, түүнээс дээш насны хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 58 минут, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 16 минут зарцуулж байхад хөдөөгийн хүн амын хувьд ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд 1 цаг 43 минут, эсрэгээрээ өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 3 цаг 39 минутыг зарцуулдаг.


Цаг ашиглалтын үйл ажиллагаануудад түүнд хамаарах зорчих цагуудыг багтааж тооцдог бөгөөд хөдөлмөр эрхлэх цагт хамаарах ажилдаа явах, зорчих цаг хотод хөдөөгөөс 3 дахин өндөр буюу хөдөөд өдөрт дунджаар 11 минут зарцуулж байхад хотод 34 минут зарцуулж буй нь хөдөөд хөдөлмөр эрхэлж буй үндсэн цаг бүр илүү болохыг харуулж байна.



Дүрслэл 13. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хот, хөдөөгөөр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

38

19

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

26


21

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

175

133

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 3
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 15
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 12
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 125
- Бусад 20




3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

735

735

- Унтах, амрах, босох 575
- Хооллох, цай уух 79
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 45
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 6
- Бусад 30



Хот, хөдөөгийн амьдралын хэв маягийн ялгаа хөлстэй хөдөлмөрт ийнхүү илрэх бол хөлсгүй хөдөлмөрийн тухайд хот, хөдөөд ерөнхийдөө ижил. Хотод хөлсгүй хөдөлмөрт долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 32 минут, хөдөөд 3 цаг 30 минутыг зарцуулдаг. Харин бүтцийн хувьд хөдөөд гэрийн ажилд зарцуулах цаг хотынхтой харьцуулахад өндөр, эсрэгээрээ хүүхэд, өрхийн бусад гишүүдийг асрахад зарцуулах цаг хотынхоос бага байна. Хөлсгүй хөдөлмөрийн нэг бүрдэл болох сайн дурын ажилд хотод 7 минут, хөдөөд ялимгүй бага буюу 6 минут зарцуулж байна.

Хөдөөд хөлстэй хөдөлмөр эрхлэлт их учраас боловсролын үйл ажиллагаа, чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулах цаг хотынхоос хомс.


Хөдөөд боловсролын үйл ажиллагаанд хотынхоос 2 дахин бага буюу хотод 38 минут зарцуулж байхад хөдөөд өдөрт дунджаар 19 минут зарцуулдаг. Мөн чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд хотод 2 цаг 55 минут зарцуулдаг бол хөдөөд 24.0 хувь (42 минут)-иар бага буюу 2 цаг 13 минут зарцуулж байна.

Хүн ам чөлөөт цагийнхаа дийлэнхийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулах хандлага хотод ч, хөдөөд ч ижил. Гэхдээ хөдөөд хотынхоос 18.4 хувь (23 минут)-иар бага буюу өдөрт дунджаар 1 цаг 42 минутыг, хотод 2 цаг 5 минутыг энэ үйл ажиллагаанд зарцуулж байна. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцоход хотод өдөрт дунджаар 26 минут зарцуулдаг бол хөдөөд 21 минутыг зарцуулж байна.

Хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах нийт цаг хот, хөдөөд ижил буюу хотод ч, хөдөөд ч өдөрт дунджаар 12 цаг 15 минутыг зарцуулдаг. Үүнээс дийлэнх хэсгийг унтах цаг эзлэх ба хотод унтах, амрах, босохтой холбоотой үйл ажиллагаанд өдөрт дунджаар 9 цаг 35 минут зарцуулдаг бол хөдөөд 10 минутаар бага буюу 9 цаг 25 минутыг зарцуулж байна. Хөдөөд хооллох, цай уухад хотынхоос илүү цаг (хотод 1 цаг 19 минут, хөдөөд 1 цаг 39 минут) зарцуулахаас гадна хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад ялимгүй илүү цаг (хотод 45 минут, хөдөөд 48 минут) зарцуулж байна.

Дүрслэл 14. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




СУМЫН ТӨВ




247

158




89




212

161




43




8

ХӨДӨӨ




362

75




287



208

180



23



5

Цаг ашиглалтын байдал суурьшлаар мөн ялгаатай. Суурьшил алслагдах тусам буюу нийслэл хотоос хөдөө рүү дөхөх тусам хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулж мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанаас хамааран улам бүр нэмэгдэх хандлагатай. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулж мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нийслэл хоттой харьцуулахад аймгийн төвд 3.1 дахин их цагийг, сумын төвд 8.9 дахин их цагийг, хөдөөд 28.7 дахин их цагийг зарцуулдаг. Энэ үйл ажиллагаанд хотод 12 ба түүнээс дээш насны хүн ам өдөрт дунджаар 10 минут зарцуулж байхад хөдөөд 4 цаг 47 минутыг зарцуулж буй юм. Үүний эсрэгээр төвөөс алсрах тусам ААНБ-д ажиллах цаг буурч байна.


Суурьшил дундаас аймгийн төв арай онцлогтой буюу ААНБ-д ажиллах цаг хотынхоос бага ч хөдөөгийнхтэй харьцуулахад өндөр бөгөөд сумын төв, хөдөөтэй харьцуулахад өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд эрс бага цаг зарцуулдаг.

Хөлсгүй хөдөлмөрийн хувьд хотоос хөдөө рүү дөхөх тусам гэрийн ажилд зарцуулах цаг нэмэгдэж, харин хүүхэд, өрхийн бусад гишүүдийг цалин хөлсгүй асрах ажилд зарцуулах цаг буурдаг. Хоол хүнс бэлтгэх, гэр цэвэрлэх цаг төвөөс алсрах тусам нэмэгдэх бол хувцас, гутал угаах, арчлах цаг нийслэл хот болон хөдөөд хамгийн бага, аймгийн төв, сумын төвд энэ үйл ажиллагаанд илүү их цаг зарцуулж байна.

Дүрслэл 15. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

37

40

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

25

28

3.3 Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

170

185

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад

2

3

14

12

117

143

24

13

3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

728

749

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад

570

587

77

85

45







44

6

7

30

26



Төвөөс илүү алслагдсан сумын төв болон хөдөөд нийслэл хоттой харьцуулахад хөдөлмөр эрхлэлтэд их цаг зарцуулдаг тул өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг харьцангуй бага. Харин аймгийн төвд нийслэл хот болон алслагдсан бүсүүдтэй харьцуулахад бага цагийг хөдөлмөр эрхлэлтэд зарцуулдаг тул өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг суурьшил дундаас хамгийн өндөр. Аймгийн төвд боловсролын үйл ажиллагаа, хүмүүстэй харилцах үйл ажиллагаанд бусад суурьшлуудтай харьцуулахад их цаг зарцуулахын дээр чөлөөт цаг, тэр дундаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулсан цаг өндөр байна.

Спортоор хичээллэхэд нийслэл хотод болон аймгийн төв, сумын төвд амьдардаг хүмүүс тусгайлан цаг гаргадаг бол хөдөөд энэ үйл ажиллагаанд зориулж тусгай цаг гаргадаггүй, амьдралын хэмнэл нь өөрөө хөдөлгөөний идэвхтэй байхад тусалдаг гэж хэлж болохоор байна.

Унтах, амрахад хөдөөд хамгийн бага цаг буюу өдөрт дунджаар 9 цаг 11 минут зарцуулдаг.

Харин хотод үүнээс 19 минутаар илүү буюу 9 цаг 30 минутыг зарцуулж байхад сумын төв, аймгийн төвд хамгийн их буюу 9 цаг 47-51 минутыг унтахад зарцуулж байна. Харин хооллохтой холбоотой үйл ажиллагаанд төв рүү дөхөх тусам бага цаг зарцуулдаг аж.

Дүрслэл 16. Хөлстэй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, бүсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




Цаг ашиглалтын хэв маягийг бүсээр авч үзвэл хөдөлмөр эрхлэлт төвөөс алслагдах тусам нэмэгдэх хандлага бүсүүдэд мөн илэрч байна. Улаанбаатар хот болон Төвийн бүсэд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 58 минутаас 8 цагийг хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд зарцуулдаг бол Хангайн бүсэд 8 цаг 6 минут, Баруун бүсэд 8 цаг 20 минут, Зүүн бүсэд 8 цаг 54 минут болж нэмэгдэж байна.



Хөлстэй хөдөлмөрийн нэг бүрдэл болох ААНБ-д ажиллахад Улаанбаатар хоттой харьцуулахад бүсүүдэд 2.2-3.3 дахин бага цаг зарцуулдаг ба төвөөс алслагдсан Баруун, Зүүн бүсүүдэд амьдардаг хүн ам энэ төрлийн хөдөлмөр эрхлэлтэд хамгийн бага цаг зарцуулж байна.

Харин өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд Улаанбаатар хотод маш бага цаг зарцуулдаг ба бүсүүдэд энэ үйл ажиллагаанд 2 цагаас 3 цаг 3 минутыг өдөрт дунджаар зарцуулж байна. Үүнээс Зүүн бүсийн хүн ам хамгийн их цагийг буюу өдөрт дунджаар 3 цаг 3 минутыг өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулдаг.

ТӨВИЙН БҮС




150




ЗҮҮН БҮС



104




УЛААНБААТАР



265




120



183



10



| — 1 минут


Хөлсгүй хөдөлмөрт алслагдсан бүсийн хүн ам илүү их цаг зарцуулж байна. Улаанбаатар хот, Төвийн бүс, Хангайн бүсэд хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 3 цаг 18-28 минут зарцуулж байхад Баруун бүсэд 3 цаг 59 минут, Зүүн бүсэд 4 цаг 7 минут зарцуулжээ. Зүүн бүсэд хоол хүнс бэлтгэхэд хамгийн их буюу өдөрт 1 цаг 38 минут зарцуулж буй нь улсын дунджаас 36 минутаар өндөр байна. Хүүхэд, өрхийн гишүүдийг асрахад Улаанбаатар хотод бусад бүсүүдээс илүү их цаг зарцуулж байна.

Баруун бүсэд цалин хөлсгүй сайн дурын ажилд 13 минутыг зарцуулж буй нь бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд Зүүн бүсийн хүн ам хамгийн бага цаг зарцуулдаг бол бусад бүсүүдэд ойролцоо түвшинд байна. Зүүн бүсэд хувийн хэрэгцээнд улсын дунджаас 23 минут, унтах, амрахад 26 минут бага цаг зарцуулжээ. Боловсролын үйл ажиллагаанд Улаанбаатар хот болон Төвийн бүсийн хүн ам илүү их цаг зарцуулдаг. Эдгээр бүсүүдэд боловсролд өдөрт дунджаар 37-38 минут зарцуулж байхад Баруун, Зүүн, Хангайн бүсэд 20-27 минут зарцуулж байна.

Дүрслэл 17. Хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, бүсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




Бүсүүд дотроос чөлөөт цагт хамгийн бага цаг зарцуулдаг нь Баруун бүсийн хүн ам. Энд өдөрт дунджаар 1 цаг 46 минутыг чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулдаг бол бусад бүсүүдэд өдөрт дунджаар 2 цаг 30-59 минутыг зарцуулж байна. Баруун бүсэд хувийн хэрэгцээний цагт илүү их цаг зарцуулж буй нь үүнд нөлөөлжээ.

Бүтцийн хувьд чөлөөт цагийнхаа дийлэнхийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулж буй нь бүсүүдэд ижил. Гэхдээ төвөөс алсрах тусам энэ хандлага илүү гүнзгийрч байна. Тодруулбал, Улаанбаатар хотод чөлөөт цагийнхаа 68.8 хувийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулсан бол Хангайн болон Төвийн бүсэд 73.1-77.7 хувийг, Баруун болон Зүүн бүсэд 81.1-82.0 хувийг энэ үйл ажиллагаанд зарцуулжээ.


ТӨВИЙН
БҮС



162



41




4


ЗҮҮН
БҮС



204




36




7

УЛААНБААТАР



141



58



6

| — 1 минут

Бүсүүд хоорондын цаг ашиглалтын онцлог ялгааг дүгнэвэл Баруун бүсэд хөлстэй хөдөлмөрт улсын дунджаас бага цаг зарцуулж, хөлсгүй хөдөлмөрт их цагийг зарцуулдаг. Мөн хувийн хэрэгцээнд бусад бүсүүдтэй харьцуулахад хамгийн их цаг зарцуулдаг.

Хангайн бүсэд хөлсгүй хөдөлмөрт, ялангуяа хоол, хүнс бэлтгэхэд улсын дунджаас хамгийн бага цаг зарцуулдаг.


Төвийн бүсийн хүн амын цаг ашиглалт улсын дундажтай ойролцоо. Гэхдээ чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд улсын дундажтай харьцуулахад хамгийн их цаг зарцуулдаг.

Зүүн бүсэд хөлсгүй хөдөлмөрт хамгийн их цаг зарцуулдаг ба өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд, тэр дундаа унтахад хамгийн бага цаг зарцуулдаг.

Дүрслэл 18. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, бүсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

20

27

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

21


31

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

106

167

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад




3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа


792

728

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад




ТӨВИЙН БҮС




38

18


179



728




ЗҮҮН БҮС




21

23


150



712




УЛААНБААТАР




37

25

170



728




ХОТОД ЯВАХ, ЗОРЧИХОД ИЛҮҮ ЦАГ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ.

Цаг ашиглалтын үйл ажиллагааны ангилалд тусгагдсан үйл ажиллагаа бүрд түүнд хамаарах явах, зорчих цаг багтсан байдаг онцлогтой. Эдгээр цагуудыг нэгтгэн тооцвол улсын дунджаар 12 ба түүнээс дээш насны хүн ам өдөрт дунджаар 1 цаг 13 минутыг явах, зорчиход зарцуулж байна. Хотод энэ цаг хөдөөгөөс 69.4 хувь өндөр буюу өдөрт дунджаар 34 минутыг илүү зарцуулдаг. Өөрөөр хэлбэл хотод явах, зорчиход илүү цаг төлөвлөх шаардлагатай.

Суурьшлаар тодруулж харвал Улаанбаатар хотод өдөр бүр дунджаар 1 цаг 35 минут буюу хамгийн их цагийг явах, зорчиход зарцуулж байна. Харин суурьшлийн хөдөөд хамгийн бага буюу 42 минутыг зарцуулдаг. Мөн Баруун болон Төвийн бүсэд амьдардаг бол явах, зорчиход бага цаг зарцуулах хандлагатай байна.

Дүрслэл 19. Явах, зорчиход зарцуулсан хугацаа, улсын дундаж, хот, хөдөөгөөр, суурьшлаар, бүсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023



Монгол орон жилийн дөрвөн улиралтай, цаг уурын нөхцөл нь хүн амын цаг ашиглалтын байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг. Өвлийн улиралд буюу 1 дүгээр улиралд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн идэвх буурч, унтах, амрахтай холбоотой цаг нэмэгдэх хандлагатай бол жилийн бусад үед хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг тогтмол өндөр түвшинд байна.

1 дүгээр улиралд хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг жилийн дунджаас 14.9 хувиар буурч буй бөгөөд үүнд ААНБ-д ажиллахад зарцуулах цаг 31.9 хувиар буурсан нь нөлөөлж байна. Харин өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах цаг жилийн эхний 3 улиралд өндөр, 4 дүгээр улиралд илүү буурах хандлагатай.

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг улирал хооронд ерөнхийдөө тогтвортой боловч 1 дүгээр улиралд жилийн дунджаас 9.0 хувиар нэмэгддэг. Үүнд гэрийн ажилд зарцуулах цаг 1 дүгээр улиралд жилийн дунджаас 11.0 хувиар нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.


Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нийт дүнгээрээ 1 дүгээр улиралд жилийн дундажтай харьцуулахад 2.3 хувиар нэмэгдэх бол бусад улиралд харьцангуй тогтмол түвшинд байна. Энэ үйл ажиллагааг бүтцийн хувьд нарийвчилж харвал илүү ялгаа ажиглагдах ба тухайлбал унтах, амрах, хооллохтой холбоотой цаг 1 дүгээр улиралд бусад улиралтай харьцуулахад өндөр бөгөөд жилийн дунджаас 6.8 хувиар нэмэгдсэн байна. 1 дүгээр улиралд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг буурч, хөлсгүй хөдөлмөр болон амрахад зарцуулах цаг нэмэгдэх бол чөлөөт цаг энэ улиралд төдийлөн нэмэгдээгүй байна. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зарцуулах цаг 2 дугаар улиралд жилийн бусад үетэй харьцуулахад хамгийн өндөр. Өвөл дуусч хавар эхлэх энэ улиралд чөлөөт цаг нэмэгдэхээс гадна хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг хамгийн бага түвшинд хүрдэг ажээ. Мөн хүмүүс 2 болон 3 дугаар улиралд спортоор хичээллэхэд илүү цаг зарцуулдаг. Хүмүүсийн чөлөөт цагаа зарцуулдаг гол үйл ажиллагааны сонголт нь жилийн аль ч улиралд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах хэвээр байна.

Зуны 3 дугаар улиралд боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зарцуулах цаг эрс багасч, хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг болон хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцох цаг нэмэгддэг.

4 дүгээр улиралд ААНБ-д ажиллах гэх мэт цалинтай хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг хамгийн өндөр түвшинд хүрдэг. Мөн жилийн энэ үед хүмүүс хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад зарцуулах цагаа хамгийн их нэмэгдүүлдэг бол эсрэгээрээ жилийн эхний улиралд энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг хамгийн бага байна.

Дүрслэл 20. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, улирлаар







Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



III УЛИРАЛ



IV УЛИРАЛ




| — 1 минут

Дүрслэл 21. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, улирлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

39

36

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

18


25

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

154

180

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 3
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 15
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 5
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 115
- Бусад 16






3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

764

710

- Унтах, амрах, босох 611
- Хооллох, цай уух 92
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 36
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 4
- Бусад 21





15



37

28

25



160

156




739

734





Дүрслэл 22. Цаг ашиглалт, улирлаар, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ХӨДӨӨ



Монголчууд эртнээс байгаль, цаг уурын байдал, улиралдаа бие, сэтгэл, ажил үйлээ тохируулан тэнцвэржүүлж ирсэн уламжлалтай. Хотжилт эрчимтэй хөгжсөнөөр энэ уялдаа саарсан ч уламжлалт мал аж ахуй эрхэлдэг амьдралын хэв маягтай хөдөөгийн иргэдийн цаг ашиглалтад улирлын ялгаа тод илэрсэн хэвээр байна.

Нийслэлд хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг оны эхнээс төгсгөл хүртэл үргэлжлэн өсч, 4 дүгээр улиралд хамгийн өндөр түвшиндээ хүрэх ба үүний нөлөөгөөр өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулах цаг оны эхний хагаст өндөр сүүлийн хагаст буурах хандлагатай. Аймгийн төвд улирал хоорондын ялгаа бусад суурьшилтай харьцуулахад хамгийн бага буюу илүү тогтвортой байна.

Хөдөөд хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цагийн улирлын ялгаа хамгийн өндөр. Энд оны эхний болон сүүлийн улиралд хөлстэй хөдөлмөрт бага цаг зарцуулж, 2 ба 3 дугаар улиралд илүү их цаг төлөвлөдөг. Мал аж ахуй голчлон эрхэлдэг хөдөөгийн хүн ам 2 дугаар улирлыг мал төллүүлэх, ноолуур, ноос самнах зэргээр жилийн бусад үетэй харьцуулахад хамгийн завгүй өнгөрүүлнэ. Мөн 3 дугаар улиралд буюу зуны саруудад отор, нүүдэл хийх, айраг, цагаан идээгээ боловсруулах, шинэ мах бэлтгэх гээд хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулах шаардлагатай. Хөдөөд 1 ба 4 дүгээр улиралд жилийн бусад үетэй харьцуулахад арай бага цагийг хөдөлмөр эрхлэхэд зарцуулах хэдий ч бусад суурьшилтай харьцуулахад өндөр хэвээр байна.


Хөдөөгийн хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цагийн улирлын ялгаа сумын төвд мөн ажиглагдах хэдий ч улирал хоорондын ялгаа хөдөөгийнхөөс бага.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулах, амрах цаг нийслэлд оны эхэнд илүү өндөр бол оны төгсгөл рүү буурах хандлагатай. Харин аймгийн төвд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нь улирал хооронд харьцангуй тогтмол.

Сумын төвд амьдардаг хүн амын хувьд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нь 3 дугаар улиралд бага, бусад улиралд өндөр байна. Хөдөөд хөдөлмөр эрхлэлт өндөр ч 1, 4 дүгээр улиралд ачаалал харьцангуй бага буюу энэ улиралд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж байна.

Дүрслэл 23. Хүн амын амьдралын хэв маяг, 24 цагаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, дүнд эзлэх хувиар, 2023



ХҮН АМЫН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ 24 ЦАГТ

Цаг ашиглалтын судалгаагаар тодорхой үйл ажиллагаанд зарцуулсан хугацааг хэмжихээс гадна тухайн үйл ажиллагааг өдрийн аль цагт гүйцэтгэж байгааг хэмждэг. Энэ нь хүн амын амьдралын хэв маягийг илүү тодруулж харуулдаг. Монгол Улсын 12, түүнээс дээш насны хүн амын долоо хоногийн нэг өдрийн амьдралын хэв маягийг 24 цагаар авч үзье.

- Хүн амын 68.5 хувь нь өглөөний 7 цагт, 82.0 хувь нь өглөөний 8 цагт, 88.0 хувь нь өглөөний 9 цагт, 92.4 хувь нь өглөөний 10 цаг гэхэд боссон байдаг.
- Өглөөний цайгаа ихэнх хүн 7-10 цагийн хооронд уудаг.
- Унтах, хооллохоос бусад хувийн хэрэгцээ буюу хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих зэрэг үйл ажиллагаа нь өглөөний, оройны гэж хуваагдах ба өглөөд өглөөний 6-9 цагийн хооронд энэ үйл ажиллагаанд илүү цаг зарцуулдаг.
- Гэрийн ажил өглөөний 7 цагаас оройны 20 цаг хүртэл идэвхтэй үргэлжилнэ. Энэ цагт нийт хүн амын 13.1-22.7 хувь нь тогтмол гэрийн ажил хийж байдаг. Мөн өглөөний 8 цагаас оройны 22 цаг хүртэл хүн амын 4.5-6.9 хувь нь гэр бүлийн гишүүдийг цалин хөлсгүй асарч байдаг.

- Өглөөний 8 цагаас оройны 19 цагийн хооронд хүн амын хамгийн өндөр хувь буюу 11.4-21.1 хувь нь хөлстэй хөдөлмөр эрхэлдэг. Хөдөлмөр эрхлэлт өглөөний 11 цаг болон үдийн 15-16 цагт оргил үедээ хүрч, хүн амын 20.5-21.1 хувь нь хөдөлмөр эрхлэхэд цагаа зориулж байдаг.
- Өдрийн 12-14 цагийн хооронд өдрийн хоолоо идэх нь хамгийн түгээмэл. Хүн амын 22 хувь нь өдрийн 13 цагт хооллодог.
- Боловсролын үйл ажиллагаанд цаг зарцуулалт өглөөний 7 цагаас оройны 19 цагт идэвхтэй.
- Хүмүүстэй харилцах үйл ажиллагаа өглөөний 10 цагаас оройны 22 цаг хүртэл идэвхтэй үргэлжилдэг.
- Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд өглөөний 10 цагаас оройны 22 цагт цаг гаргах нь элбэг, тэр дундаа үдийн 15 цагт хамгийн идэвхтэй цаг зарцуулах хандлагатай.
- Хүн амын дийлэнх нь оройн хоолыг 18-20 цагийн хооронд иддэг. Оройны 19 цагт хамгийн их буюу хүн амын 19.7 хувь нь хооллож байдаг.
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих оройны үйл ажиллагаа нь оройны 20-22 цагт илүү түгээмэл. Тэр дундаа оройны 22 цагт хамгийн их буюу хүн амын 20.5 хувь нь хувийн ариун цэвэр, эрүүл ахуйдаа цаг зарцуулж байдаг.
- Харин олон нийтийн мэдээллийн хэрэгслийг оройны 18-23 цагийн хооронд ашиглах нь түгээмэл бөгөөд оройны 21 цагт хүн амын 30.2 хувь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж байгаа нь хамгийн өндөр хандалттай цаг юм.
- Хүн амын талаас илүү хувь буюу 66.6 хувь нь 23 цагт, 87.0 хувь нь шөнийн 00 цагт, 92.9 хувь нь шөнийн 01 цагт, 96.0 хувь нь шөнийн 2 цаг гэхэд унтсан байдаг.

Унтах

Хоол идэх, цай уух

Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх

Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ

Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах


Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

Дүрслэл 24. Хүн амын амьдралын хэв маяг, 24 цагаар, ажлын болон амралтын өдрөөр

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, дүнд эзлэх хувиар, 2023



АЖЛЫН БОЛОН АМРАЛТЫН ӨДРИЙН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ 24 ЦАГТ

Ажлын болон амралтын аль аль өдөр өглөөний 8 цагаас оройны 19 цагийн хооронд хүн амын тодорхой хэсэг нь идэвхтэй хөлстэй хөдөлмөр эрхэлсээр байдаг. Гэхдээ ажлын өдөр эдгээр цагуудад хүн амын 19.1-34.6 хувь нь хөлстэй хөдөлмөр эрхэлж буй бол амралтын өдөр 15.8-26.8 хувь болж буурдаг.

Хөлсгүй хөдөлмөрт ажлын өдрүүдэд өглөөний 7 цагаас оройны 20 цагт хүн амын олонх нь буюу 17.0-28.8 хувь нь цаг зарцуулдаг бол амралтын өдрүүдэд өглөөний 8 цагаас оройны 20 цагт хүн амын дийлэнх болох 20.7-33.8 хувь нь хөлсгүй хөдөлмөр эрхэлж байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулах цаг ажлын болон амралтын өдрүүдэд оройны 18-23 цагт идэвхтэй бөгөөд ажлын өдөр хүн амын 9.7-29.8 хувь, амралтын өдөр 10.2-31.3 хувь нь эдгээр цагуудад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж байдаг.

Амралтын өдөр өглөө босох, өглөөний цай уух цаг ажлын өдрүүдээс оройтох хандлагатай. Ажлын өдөр өглөөний 7 цагт хүн амын 70.0 хувь нь, 8 цагт 83.4 хувь нь аль хэдийн боссон байдаг бол амралтын өдөр өглөөний 7 цагт хүн амын 63.2 хувь нь, 8 цагт 77.3 хувь нь, 9 цагт 84.5 хувь нь боссон байдаг.

Өдрийн хоол идэх хугацаа амралтын өдрүүдэд сунах хандлагатай. Ажлын өдөр хүн амын хамгийн их хувь нь 12-14 цагийн хооронд өдрийн хоолоо идэж байдаг бол амралтын өдөр 12-15 цаг болж сунадаг. Оройн хоол идэх цаг ажлын, амралтын өдрүүд хооронд төдийлөн ялгаагүй.

Боловсролд зарцуулах цаг амралтын өдөр буурахаас гадна хойшилдог. Ажлын өдөр өглөөний 7 цагаас оройны 18 цаг хүртэл хүн амын 2.4-4.8 хувь нь суралцаж байдаг бол амралтын өдөр суралцах цаг өглөөний 9 цагаас оройны 19 цаг хүртэл илүү идэвхтэй. Энэ цагт хүн амын 0.9-1.8 хувь нь суралцаж байдаг.

Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох идэвхтэй цаг өглөөний 10 цагаас оройны 22 цаг хүртэл байдаг нь ажлын болон амралтын өдрүүдэд адилхан. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд өглөөний 10 цагаас оройны 22 цагт илүү идэхтэй цаг зарцуулдгаас ажлын өдөр хүн амын 3.0-5.3 хувь нь, амралтын өдөр хүн амын 3.7-7.0 хувь нь чөлөөт цагтаа цаг гаргаж байдаг.

Унтах цаг амралтын өдрүүдэд ерөнхийдөө хойшилж, ажлын өдөр оройны 23 цагт хүн амын 66.8 хувь нь, шөнийн 00 цагт 87.1 хувь нь унтсан байхад амралтын өдөр 23 цагт хүн амын 66.0 хувь нь, шөнийн 00 цагт 86.6 хувь нь унтсан байдаг.

Унтах

Хоол идэх, цай уух

Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх

Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ

Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

4.2.

ЦАГ АШИГЛАЛТ БА ХҮЙСИЙН ЯЛГАА

Цаг ашиглалтын судалгаа нь хүйсээр ангилсан өгөгдлийн нэгэн томоохон эх үүсвэр юм. Тусгайлан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн зөрүүтэй байдлыг багасгах ТХЗ-ын "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг" үзүүлэлтийг хэмжих, хянах боломжийг олгодог.


Нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг олон хүчин зүйлээс хамааран хүн амын цаг ашиглалт өөр хоорондоо ялгаатай. Тэр дундаас хүйсээс хамаарсан цаг ашиглалтын ялгаа нь зарим тохиолдолд хувь хүний сонголт байдаг хэдий ч ихэвчлэн тухайн хүйсэд оноосон нийгмийн дүр, үүрэг, сонголтын хязгаарлалт байж, тэгш бус

байдал үүсгэдэг тул анхааран авч үзэх шаардлагатай сэдэв болдог. Биологийн өгөгдлөөс хамааран эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зарим хэрэгцээ, сонголт өөр байж болох ч хүйсээс хамааран сонголтоо хязгаарлуулж буй бол тэгш бус байдал үүснэ.

Монгол Улсын хүн амын цаг ашиглалтын төлөвт хүйсийн тодорхой ялгаа байгаа нь өмнөх судалгааны үр дүнгүүдээс харагдаж байсан. Ялангуяа хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн хувьд хүйсийн ялгаа мэдэгдэхүйц байгаа нь илэрсэн. Тэгвэл энэ ялгаа арилсан уу эсвэл гүнзгийрсэн үү?

Дүрслэл 25. Цаг ашиглалт, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




Эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 12 цаг 8 минутыг хувийн хэрэгцээнд (унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт), 5 цаг 43 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 2 цаг 16 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 31 минутыг суралцах, 3 цаг 22 минутыг чөлөөт цаг, хүмүүстэй харилцахад зориулж байна. Өөрөөр хэлбэл эрэгтэйчүүдийн дундаж нэг өдрийн 24 цагийн **50.6 хувь** нь зайлшгүй хувийн хэрэгцээнд, **33.3 хувь** нь хөдөлмөр эрхлэлтэд, **16.2 хувь** нь боловсрол болон чөлөөт цагт зарцуулагддаг.


Харин эмэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт 12 цаг 21 минутыг хувийн хэрэгцээнд (унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт), 3 цаг 40 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд, 4 цаг 33 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 33 минутыг суралцах, 2 цаг 53 минутыг чөлөөт цаг, бусадтай харилцахад зориулж байна. Тодруулбал, эмэгтэйчүүдийн дундаж нэг өдрийн 24 цагийн **51.5 хувь** нь зайлшгүй хувийн хэрэгцээнд, **34.2 хувь** нь хөдөлмөр эрхлэлтэд, **14.3 хувь** нь боловсрол болон чөлөөт цагт зориулагдаж байна.

Дүрслэл 26.
Цаг ашиглалт, хүйсээр, ЦАС явагдсан оноор

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар




* 2007, 2011, 2015 оны ЦАС-ны үр дүнг тооцоход жин ашиглаагүй бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон.




ХӨЛСГҮЙ АСРАХ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА

(Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын **өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрахад** зарцуулсан хугацаа, хүйсээр, минутаар, ЦАС явагдсан оноор)



ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА

(Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын **гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэхэд** зарцуулсан хугацаа, хүйсээр, минутаар, ЦАС явагдсан оноор)



ЭМЭГТЭЙЧҮҮД ЭРЭГТЭЙЧҮҮДЭЭС ИЛҮҮ ХӨДӨЛМӨРЛӨДӨГ, ГЭХДЭЭ ХӨЛСГҮЙ.

Хөдөлмөр эрхлэлтийг хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрийн нийлбэр дүнгээр тооцвол эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 59 минутыг хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй бол эмэгтэйчүүд дунджаар 8 цаг 13 минутыг хөдөлмөр эрхлэхэд зарцуулах буюу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 14 минутаар илүү цагийг хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зориулж байна.

Гэхдээ үүнээс илүү чухал ялгаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хөлстэй, хөлсгүй шинж чанараар илэрч байна. Үндсэндээ эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулах, эсрэгээрээ эмэгтэйчүүд ямар нэг байдлаар хөлсгүй хөдөлмөрт илүү цаг зарцуулах хандлага хэвээр.

Эрэгтэйчүүд өдөрт дунджаар 5 цаг 43 минутыг, эмэгтэйчүүд 3 цаг 40 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулж буй буюу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байна. Эсрэгээрээ эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4 цаг 33 минутыг, эрэгтэйчүүд 2 цаг 16 минутыг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зарцуулж буй буюу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.0 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зориулж байна. Тодруулбал, эрэгтэйчүүдийн өдрийн дундаж хөдөлмөр эрхэлсэн цагийн 71.6 хувь нь хөлстэй хөдөлмөр бол эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхэлсэн нийт цагийн тал хүрэхгүй хувь буюу 44.6 хувь нь хөлстэй хөдөлмөрт зарцуулагджээ.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт зарцуулсан цагийн хүйс хоорондын зөрүү 2 цаг 3 минут байгаа нь 2019 онтой харьцуулахад 9 минутаар буурсан. Харин хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цагийн хүйс хоорондын зөрүү 2 цаг 17 минут байгаа нь 2019 онтой харьцуулахад 27 минутаар буурчээ. Энэ нь өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд зарцуулсан өдрийн дундаж цаг 19 минутаар нэмэгдэж, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн цаг 8 минутаар буурсантай холбоотой. Мөн энэ хугацаанд хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг буурах хандлага эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алинд илэрсэн. Ямартай ч хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн хүйсийн ялгаанд маш алгуур буурах хандлага ажиглагджээ. Гэсэн хэдий ч хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цагийн хүйс хоорондын ялгаа 2 цагаас илүү хэвээр байгаа нь энэ хурдаар буурвал хөдөлмөрийн үнэлэмжийн хүйсийн ялгаа арилахад багагүй хугацаа шаардлагатайг харуулж байна.

Хөдөлмөрийн үнэлэмжийн ялгааг арилгах гэдэг нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гэр бүлдээ болон нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг адил тэгш үнэлэх тухай асуудал. Ялангуяа ялгаатай үнэлэмж нь ялгаатай боломж, ялгаатай оролцоог үүсгэх боломжтой тул дэлхий дахинд энэ талаар анхаарч, тогтвортой хөгжлийг бүтээхэд шаардлагатай нэг шалгуур нь үнэлэгддэг болон үнэлэгддэггүй хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн тэгш бус байдлыг арилгахад чиглэж байна.




ХӨЛСТЭЙ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХӨЛСГҮЙ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГАА

ӨӨРИЙГӨӨ
ХӨГЖҮҮЛЭХ
БОЛОН ХУВИЙН
ХЭРЭГЦЭЭНИЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА

Дүрслэл 27. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цаг ашиглалтын зөрүү, ЦАС явагдсан оноор

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар



* 2007, 2011, 2015 оны ЦАС-ны үр дүнг тооцоход жин ашиглаагүй бөгөөд судалгаанд хамрагдсан хүн амын хувьд тооцсон.

- Эрэгтэй
- Улсын дундаж
- Эмэгтэй


Дүрслэл 28. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



| — 1 минут

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



Цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын дагуу нарийвчилж харвал эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт эмэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг зарцуулж байгаагаас ААНБ-д ажиллахад 1.3 дахин их цагийг, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 2.0 дахин их цагийг зарцуулж байна. Харин эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүдээс 2.0 дахин их цагийг зарцуулж байгаагаас гэрийн ажил хийхэд 2.0 дахин их цагийг, үүнд гэр, сууц, хашаагаа цэвэрлэхэд 2.3 дахин их цаг, хоол хүнс бэлтгэхэд 2.8 дахин их цаг, хувцас, гутал угаах, арчлахад 4.8 дахин их цагийг зарцуулдаг. Мөн хүүхэд асрахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.4 дахин их цагийг, өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрахад 2.0 дахин их цаг зориулжээ. Эдгээр үйл ажиллагаанд харгалзах цаг ашиглалтын хүйсийн харьцаанаас хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн тэнцвэр хэр зэрэг алдагдсаныг нарийвчлан харж болно.

Монгол Улсад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 2008 оноос эхлэн буурах хандлагатай болж, 2008 онд 62.8 хувь байсан бол 2023 онд 50.2 хувьд хүрсэн нөхцөл байдалтай байна.⁴ Хөлсгүй хөдөлмөр нэг хүйсийн үүрэг мэт хуваарилагдаж буй нь хөдөлмөрийн зах зээл дэх хүйсийн тэнцвэрт байдал алдагдахад аль хэдийн нөлөөлж, цаашлаад шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэнцвэрт бус байдалд ч нөлөөлж буйг анхаарах шаардлагатай. Тухайлбал, ажлын байрны сонголтыг хүйсээр харвал асрахууд суурилсан эрүүл мэнд, зочид буудал, нийтийн хоолны салбар болон боловсролын салбарт эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь 71.9-77.4 хувь байхад уул уурхай, тээвэр, барилгын салбарт ажиллагчдын 83.1-86.7 хувь нь эрэгтэй ажиллагчид байна.⁵

Мөн дэлхийн хэмжээнд эмэгтэй парламентын гишүүдийн эзлэх хувь 26.9%⁶ байхад Монгол Улсын хувьд 2020-2024 онуудад ажилласан парламент дахь эмэгтэйчүүдийн хувь 17.1 хувь буюу дэлхийн дунджаас 9.8 нэгж хувиар доогуур үзүүлэлттэй байсан. Харин 2023 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт орж, хүйсийн квотыг шинэчлэн тусгаж өгснөөр Монгол Улсын

⁴ Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, ҮСХ, 2023


⁵ Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, ҮСХ, 2023

⁶ "Парламент дахь эмэгтэйчүүд" судалгаа, Олон улсын Парламентын холбоо (IPU), 2024.01.01

Дүрслэл 29. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

31

33

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

25


24

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

177

149

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 2
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 16
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 9
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 131
- Бусад 19




3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

728

741

- Унтах, амрах, босох 561
- Хооллох, цай уух 90
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 43
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 4
- Бусад 30




-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 25.4 хувьд хүрсэн ахицтай байгаа ч дэлхийн дунджаас доогуур, эмэгтэйчүүд квотоор дэмжигддэг хэвээр байна.

Хөлсгүй хөдөлмөр нь үнэндээ эдийн засгийн ихээхэн боломжийг агуулж байдаг. Хөлсгүй хөдөлмөрийг хөлстэй хөдөлмөрт шилжүүлэн эдийн засгийн үр ашиг бүтээх замаар эмэгтэйчүүдийн болон өрхийн орлогыг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэй. Зарим төрлийн хөлсгүй хөдөлмөрийг орлох үйлчилгээнүүд түгээмэл болох, хөлсгүй хөдөлмөрийг гэр бүлийн эмэгтэй гишүүн бус бусдад төлбөр төлж үйлдүүлэх боломжтой нөхцөл нийгэмд бүрэлдэх шаардлага бий.

ЭМЭГТЭЙЧҮҮД ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНДЭЭ ИХ ЦАГ ЗАРЦУУЛДАГ БОЛ ЭРЭГТЭЙЧҮҮД ЧӨЛӨӨТ ЦАГТАА ИХ ЦАГ ЗАРЦУУЛДАГ.

Цаг ашиглалтын судалгаагаар хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэхээс бусад цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт тооцдог. Эрэгтэйчүүд энэ үйл ажиллагаанд нийт 16 цаг 1 минут зарцуулж буй бол эмэгтэйчүүд 15 цаг 47 минут зарцуулж байна. Харин энэхүү цагаа эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ямар үйл ажиллагаанд, хэрхэн хуваарилж байна вэ?

Эмэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний нийт цагийнхаа 78.2 хувийг унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээнд, 15.7 хувийг чөлөөт цагт, 3.5 хувийг боловсролд, 2.5 хувийг хүмүүстэй харилцахад зарцуулжээ. Харин эрэгтэйчүүд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагаа хуваарилахдаа унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт хувийн хэрэгцээндээ эмэгтэйчүүдээс арай бага хувийг буюу нийт цагийнхаа 75.8 хувийг, чөлөөт цагтаа арай илүү хувийг буюу 18.4 хувийг, боловсролд 3.2 хувийг, хүмүүстэй харилцахад 2.6 хувийг хуваарилжээ.

Зайлшгүй хувийн хэрэгцээ буюу унтах, амрах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих

зэрэгт эрэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 12 цаг 8 минутыг зарцуулж байхад эмэгтэйчүүд 13 минут илүү буюу 12 цаг 21 минутыг зарцуулж буй юм. Үүнд унтах, амрах, босох зэрэг унтахтай холбоотой үйл ажиллагаанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 20 минут илүү зарцуулдаг. Харин хооллоход эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 8 минут бага цаг зарцуулдаг ажээ. Мөн хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс дунджаар 5 минут илүү цаг зарцуулж байна.

Эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхлэлт болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг эрэгтэйчүүдийнхээс их байгаа зөрүү нь тэдний чөлөөт цагт зарцуулах цагийг хорогдуулж байна. Эрэгтэйчүүд чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 2 цаг 57 минут зарцуулж байхад эмэгтэйчүүд 28 минутаар бага буюу 2 цаг 29 минут зарцуулсан байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиных нь чөлөөт цагаа өнгөрүүлдэг түгээмэл үйл ажиллагаа нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах ажээ. Гэхдээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 24 минут бага цагийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулсан байна. Мөн хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүд 6 минут бага цагийг зарцуулжээ. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн спортоор хичээллэхэд зарцуулах өдрийн дундаж цаг адилхан 9 минут байна.

АМРАЛТЫН ӨДӨР ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЦАГ, ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ӨРХИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭХ ЦАГ НЭМЭГДДЭГ.

Амралтын өдөр хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг буурдаг ч ихэнх хэсэг нь хөлстэй хөдөлмөр эрхлэлтээс өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа руу шилждэг. Амралтын өдөр эрэгтэйчүүдийн өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг илүү нэмэгдэнэ.

Эрэгтэйчүүд хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд ажлын өдөр өдөрт дунджаар 8 цаг 4 минут зарцуулдаг бол амралтын өдөр 21 минут буурч, 7 цаг 43 минут зарцуулсан байна. Эрэгтэйчүүдийн хувьд амралтын өдөр ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг 1 цаг 14 минутаар буурч, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг 25 минутаар, гэрийн ажилд зарцуулах цаг 26 минутаар тус тус нэмэгджээ. Харин эмэгтэйчүүдийн нийт хөдөлмөр эрхлэлт ажлын өдөр 8 цаг 21 минут байдаг бол амралтын өдөр 29 минутаар буурч, 7 цаг 52 минут болсон байна. Үүнд эмэгтэйчүүдийн ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг 1 цаг 10 минутаар буурч, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг 8 минутаар, гэрийн ажилд зарцуулах цаг 41 минутаар тус тус нэмэгджээ.

Эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр дэх оролцоо амралтын өдөр тодорхой хэмжээнд нэмэгдсэнээр хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн харьцаа буурч байгаа ч тэнцвэргүй хэвээр буюу эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс ажлын өдөр 2.1, амралтын өдөр 1.9 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.

Амралтын өдөр өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цаг нэмэгддэгийн дийлэнх нь эрэгтэйчүүдэд ногдох буюу эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдтэй харьцуулахад энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг ажлын өдөр 2.0, амралтын өдөр 2.1 дахин их байна.

Амралтын өдөр хөлстэй хөдөлмөр тодорхой хэмжээгээр буурахаас гадна боловсролын үйл ажиллагаанд зориулах цаг хумигддаг тул эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины чөлөөт цаг, хүмүүстэй харилцах болон хувийн хэрэгцээнд зарцуулах цаг нэмэгдэж байна.

Эмэгтэйчүүд амралтын өдөр хувийн хэрэгцээ болон хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцох цагаа нэмэх хандлагатай.

Унтах, хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих гэх мэт зайлшгүй хувийн хэрэгцээнд зарцуулах цагаа эмэгтэйчүүд амралтын өдөр 24 минутаар нэмдэг бол эрэгтэйчүүдийн хувьд 3 минут нэмэгдсэн байна. Хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцох цагаа эмэгтэйчүүд амралтын өдөр 13 минутаар нэмэгдүүлж байхад эрэгтэйчүүд 7 минутаар нэмжээ.

Эрэгтэйчүүд амралтын өдөр ажлын өдрөөс хэмнэсэн цагаа хувийн хэрэгцээ, хүмүүстэй харилцахад зарцуулахаас илүүтэй чөлөөт цагтаа хуваарилдаг.


Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд зориулах цаг нь эрэгтэйчүүдэд амралтын өдөр 34 минутаар нэмэгддэг бол эмэгтэйчүүдийнх 18 минутаар нэмэгддэг. Үүнд хоббиндоо зарцуулах цагаа эрэгтэйчүүд 8 минут нэмэхээс гадна олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах цагаа 20 минут нэмж байна. Мөн эрэгтэйчүүд спортоор хичээллэх цагаа амралтын өдөр 3 минут нэмсэн бол эмэгтэйчүүдийнх ажлын өдрөөс өөрчлөгдөөгүй байна. Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс ялгаатай нь амралтын өдөр чөлөөт цагтаа их цаг зарцуулахаас илүү унтах, амрах, бусад хувийн хэрэгцээний цагаа нэмэх сонирхолтой байдаг ажээ.

Дүрслэл 30. Цаг ашиглалт, ажлын болон амралтын өдрөөр, хүйсээр, хүйсийн харьцаа

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	АЖЛЫН НЭГ ӨДӨР		АМРАЛТЫН НЭГ ӨДӨР	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	355	236	305	174
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	252	184	178	114
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	174	135	111	77
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	15	6	20	6
- Ажилдаа явах, зорчих	34	26	25	14
- Бусад	29	17	22	17
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	102	52	127	60
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	75	30	94	35
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	12	8	15	11
- Бусад	16	14	17	15
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	129	265	158	298
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	94	191	120	232
- Хоол хүнс бэлтгэх	30	86	35	91
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	29	66	34	75
- Хувцас, гутал угаах, арчлах	3	18	9	39
- Бусад	32	21	42	27
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	30	67	29	59
- Хүүхэд асрах	22	57	24	53
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	1	2	2	2
- Бусад	6	8	3	4
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	7	9	7
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	956	939	977	968
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	37	40	14	14
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	23	21	30	34
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	169	144	203	162
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	2	4	5
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	14	9	22	12
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	9	9	12	9
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	126	105	146	115
- Бусад	19	19	19	21
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	727	734	730	758
- Унтах, амрах, босох	560	576	565	596
- Хооллох, цай уух	89	81	91	85
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	43	47	41	49
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	5	7	3	4
- Бусад	30	23	30	24

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ДҮРСЛЭЛ 31.
ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ
ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН
ХУГАЦАА, ХҮЙСЭЭР,
ХОТ, ХӨДӨӨГӨӨР

Долоо хоногийн нэг өдөрт 12,
түүнээс дээш насны хүн амын
дундаж цаг ашиглалт, минутаар,
2023

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эмэгтэй

Эрэгтэй

Эрэгтэй

Эмэгтэй

ХОТ



266 минут

141 минут

292 минут

127 минут

ХӨДӨӨ



ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТӨВӨӨС АЛСЛАГДАХ ТУСАМ ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГАА ИЛҮҮ ГҮНЗГИЙРДЭГ.

Хот, хөдөөгийн хүн амын цаг ашиглалтын хүйсийн ялгаа нь хөлстэй, хөлсгүй хөдөлмөрийн хуваариар буюу эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөр, тэр дундаа өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлыг, эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөр буюу ар гэрийн ажлаа хариуцах төлөв хөдөөд илүү гүнзгийрэх байдлаар илэрч байна. Хөдөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг их бөгөөд тэдний аль алины хувьд боловсрол, чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цаг хотын хүн амтай харьцуулахад хумигдмал байна.

Хотод амьдардаг 12 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд өдөрт дунджаар 7 цаг 36 минутыг хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байхад хөдөөгийн эрэгтэйчүүд үүнээс 1 цаг 7 минутаар илүү буюу өдөрт дунджаар 8 цаг 43 минутыг зарцуулдаг. Эмэгтэйчүүдийн хувьд хотод эмэгтэйчүүд өдөрт дунджаар 7 цаг 55 минутыг хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байхад хөдөөд амьдардаг бол 1 цаг 6 минутаар илүү буюу 9 цаг 1 минутыг зарцуулж байна.

Хотод хүйсийн ялгаа хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд давамгайлах байдлаар илэрч байсан нь хөдөөд бүр илүү гүнзгийрч, хөлстэй хөдөлмөрийн нэг бүрэлдэхүүн өрхийн хэрэглээнд зориулж мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоо түлхүү болсноор хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа нэмэгдэж байна. Хотод хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их цаг зарцуулдаг бол хөдөөд 1.6 дахин их цаг зарцуулдаг.

Хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа мөн л хөдөөд хотынхоос гүнзгийрч, хөдөөгийн эрэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт оролцох байдал хотынхоос буурч, эмэгтэйчүүд илүү их цаг зарцуулах шаардлагатай байна. Хөлсгүй хөдөлмөрт хотод амьдардаг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.9 дахин их цаг зарцуулдаг бол хөдөөд энэ тоо 2.3 болж нэмэгджээ.

Хөдөөд эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүн амын боловсрол, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах болон бусад чөлөөт цаг, унтах, амрах цаг хумигдаж байна. Хотод боловсролын үйл ажиллагаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс арай их цаг зарцуулах (эрэгтэйчүүд өдөрт дунджаар 39 минут, эмэгтэйчүүд 37 минут) хандлагатай бол хөдөөд эсрэгээрээ (эрэгтэйчүүд өдөрт дунджаар 15 минут, эмэгтэйчүүд 23 минут).

Хотын эрэгтэйчүүд чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд эмэгтэйчүүдээс өдөрт дунджаар 37 минут илүү зарцуулдаг бол хөдөөд мөн эрэгтэйчүүдийн чөлөөт цагт зарцуулах цаг эмэгтэйчүүдийнхээс өндөр бөгөөд 18 минутаар илүү байна. Мөн хотын эмэгтэйчүүд унтах, амрахад, хотын эрэгтэйчүүд хооллоход хөдөөгийн эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдээс тус тус арай их цаг зарцуулжээ.

Монгол Улсад хот, хөдөөгийн ялгаанаас гадна төвөөс алслагдах байдлаар нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөөд хүн амын амьдралын хэв маяг тодорхой хэмжээнд ялгаатай. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн ялгаа төвөөс алслагдах тусам улам гүнзгийрдэг. Суурьшлын хөдөөд хөлстэй хөдөлмөрийг эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрийг эмэгтэйчүүд давамгайлсан хийх хүйсийн ялгаа хамгийн өндөр.

Хөлстэй хөдөлмөрийн хувьд төвөөс алслагдах тусам ААНБ-д хөдөлмөр эрхлэх цаг буурч, харин мал аж ахуй эрхлэх буюу өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зарцуулах цаг өсөх байдал эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн аль алины хувьд илэрнэ. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд аль ч суурьшилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулах бөгөөд хүйсийн ялгааны хувьд сумын төвд илүү өндөр байна.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа суурьшлын бүх байршилд мөн илрэх ба сумын төв болон хөдөөд аймгийн төв, нийслэлтэй харьцуулахад хүйсийн тэнцвэр илүү алдагдсан.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд суурьшуудаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн зарцуулах цаг ойролцоо боловч бүтцийн хувьд задалж харвал зарим ялгаа бий. Тухайлбал, боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цаг нийслэлд хүйсийн ялгаа багатай бол сумын төв, хөдөөд эмэгтэйчүүд боловсролд илүү цаг зарцуулах хандлагатай. Мөн эрэгтэйчүүд суурьшлын аль ч байршилд эмэгтэйчүүдээс арай илүү цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулдаг. Үүнд чөлөөт цагт аль ч суурьшилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулдаг. Мөн хооллоход суурьшил үл харгалзан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс арай их цаг зарцуулж байна. Харин хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд нийслэлд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс их цаг зарцуулдаг бол хөдөөд эсрэгээрээ эрэгтэйчүүд илүү цаг зарцуулжээ.

Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа бүсүүдэд мөн ижил. Хөлстэй хөдөлмөрт зарцуулсан цагийн хүйсийн харьцаа бүх бүсүүдэд ойролцоо буюу эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулах хандлага нь бүсүүдэд ижил. Хөлсгүй хөдөлмөрийн хувьд Хангайн бүсээс бусад бүсэд хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цагийн хүйсийн харьцаа ойролцоо бол Хангайн бүсэд энэ ялгаа хамгийн өндөр буюу хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүдийн оролцоо хамгийн их байна.


Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цагийн хүйсийн ялгаа бүх бүсүүдэд бага буюу хүйсийн ялгаа бараг байхгүй. Гэхдээ үйл ажиллагаанн ангилаар задалж үзвэл Улаанбаатар хотод боловсролд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс үл ялиг илүү цаг зарцуулж байхад бусад бүх бүсүүдэд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү цагийг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж байна. Хобби, спорт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах зэрэгт бүх бүсүүдэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс арай илүү цаг зориулах хандлагатай.

Дүрслэл 32. Цаг ашиглалт, хот, хөдөөгөөр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ХОТ		ХӨДӨӨ	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	315	209	396	249
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	294	195	116	91
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	218	150	41	45
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	2	1	44	17
- Ажилдаа явах, зорчих	42	28	13	10
- Бусад	32	17	18	18
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	21	13	280	159
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	7	4	222	101
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	7	3	23	23
- Бусад	6	6	35	34
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	141	266	127	292
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	96	187	109	238
- Хоол хүнс бэлтгэх	32	79	28	107
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	32	64	27	78
- Хувцас, гутал угаах, арчлах	5	22	4	28
- Бусад	27	22	49	25
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	38	72	13	47
- Хүүхэд асрах	29	61	11	42
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	3	1	2
- Бусад	7	8	2	3
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	7	7	5	7
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	984	965	917	899
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	39	37	15	23
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	27	26	21	21
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	196	159	142	124
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	3	1	2
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	19	11	11	7
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	12	11	4	4
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	142	113	110	94
- Бусад	21	21	16	17
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	722	744	739	732
- Унтах, амрах, босох	562	586	560	569
- Хооллох, цай уух	82	77	105	94
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	40	48	48	47
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	5	7	2	4
- Бусад	33	26	24	18

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 33. Цаг ашиглалт, суурьшлаар, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	НИЙСЛЭЛ		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	340	221	0.21
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	328	213	0.21
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	249	167	0.20
- Орлого олох зорилгоор МAA эрхлэх	2	1	0.33
- Ажилдаа явах, зорчих	50	35	0.18
- Бусад	27	11	0.42
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	12	8	0.20
- Өрхийн хэрэглээнд зориулж МAA эрхлэх	3	2	0.20
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	5	2	0.43
- Бусад	4	5	-0.11
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	139	259	-0.30
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	93	179	-0.32
- Хоол хүнс бэлтгэх	32	76	-0.41
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	32	64	-0.33
- Хувцас, гутал угаах, арчлах	4	17	-0.62
- Бусад	25	22	0.06
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	40	73	-0.29
- Хүүхэд асрах	30	61	-0.34
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	3	-0.20
- Бусад	8	9	-0.06
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	7	-0.08
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	961	960	0.00
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	38	37	0.01
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	25	25	0.00
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	188	156	0.09
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	3	-0.20
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	18	12	0.20
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	12	12	0.00
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	132	105	0.11
- Бусад	24	24	0.00
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	711	742	-0.02
- Унтах, амрах, босох	553	584	-0.03
- Хооллох, цай уух	80	75	0.03
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	39	50	-0.12
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	5	7	-0.17
- Бусад	34	26	0.13

АЙМГИЙН ТӨВ			СУМЫН ТӨВ			ХӨДӨӨ		
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
254	182	0.17	300	202	0.20	440	277	0.23
212	158	0.15	173	145	0.09	90	58	0.22
145	115	0.12	92	92	0.00	18	17	0.03
1	0	1.00	6	1	0.71	61	27	0.39
22	14	0.22	29	19	0.21	6	4	0.20
44	29	0.21	46	33	0.16	6	10	-0.25
42	23	0.29	127	57	0.38	350	219	0.23
18	7	0.44	90	33	0.46	282	142	0.33
13	7	0.30	17	8	0.36	26	32	-0.10
11	9	0.10	20	16	0.11	42	45	-0.03
147	281	-0.31	129	283	-0.37	126	298	-0.41
102	202	-0.33	98	214	-0.37	114	253	-0.38
33	86	-0.45	31	100	-0.53	27	111	-0.61
32	63	-0.33	31	71	-0.39	26	83	-0.52
6	32	-0.68	7	29	-0.61	2	27	-0.86
32	22	0.19	28	13	0.37	59	32	0.30
33	72	-0.37	24	59	-0.42	8	40	-0.67
26	63	-0.42	20	51	-0.44	6	37	-0.72
2	3	-0.20	2	4	-0.33	0	1	-1.00
5	6	-0.09	3	4	-0.14	1	2	-0.33
12	7	0.26	7	9	-0.13	4	5	-0.11
1,039	977	0.03	1,011	955	0.03	874	865	0.01
43	38	0.06	34	43	-0.12	7	11	-0.22
31	26	0.09	24	19	0.12	20	22	-0.05
215	165	0.13	193	152	0.12	118	107	0.05
3	3	0.00	3	4	-0.14	0	0	-
21	9	0.40	20	10	0.33	7	5	0.17
13	11	0.08	10	7	0.18	1	2	-0.33
165	128	0.13	138	108	0.12	97	85	0.07
13	14	-0.04	22	23	-0.02	13	15	-0.07
750	748	0.00	760	742	0.01	730	726	0.00
583	590	-0.01	594	588	0.01	545	558	-0.01
89	82	0.04	92	87	0.03	111	99	0.06
43	45	-0.02	38	39	-0.01	53	51	0.02
5	7	-0.17	5	6	-0.09	1	2	-0.33
30	24	0.11	31	22	0.17	20	16	0.11

Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 34. Цаг ашиглалт, бүсээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	БАРУУН БҮС		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	322	206	0.22
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	146	95	0.21
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	62	60	0.02
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	52	13	0.60
- Ажилдаа явах, зорчих	20	13	0.21
- Бусад	12	10	0.09
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	176	111	0.23
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	124	60	0.35
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	15	21	-0.17
- Бусад	36	30	0.09
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	163	307	-0.31
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	135	239	-0.28
- Хоол хүнс бэлтгэх	35	101	-0.49
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	25	75	-0.50
- Хувцас, гутал угаах, арчлах	6	27	-0.64
- Бусад	69	36	0.31
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	16	53	-0.54
- Хүүхэд асрах	13	48	-0.57
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	1	1	0.00
- Бусад	2	3	-0.20
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	12	15	-0.11
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	955	927	0.01
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	18	23	-0.12
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	19	23	-0.10
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	116	98	0.08
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	1	0.00
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	9	5	0.29
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	5	3	0.25
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	92	80	0.07
- Бусад	9	9	0.00
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	802	784	0.01
- Унтах, амрах, босох	621	617	0.00
- Хооллох, цай уух	109	101	0.04
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	40	40	0.00
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	3	5	-0.25
- Бусад	29	21	0.16

ХАНГАЙН БҮС			ТӨВИЙН БҮС			ЗҮҮН БҮС			УЛААНБААТАР		
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
362	225	0.23	338	215	0.22	351	231	0.21	340	221	0.21
167	128	0.13	163	139	0.08	95	111	-0.08	328	213	0.21
85	75	0.06	96	91	0.03	58	79	-0.15	249	167	0.20
44	19	0.40	1	0	1.00	1	1	0.00	2	1	0.33
13	11	0.08	20	13	0.21	10	7	0.18	50	35	0.18
25	22	0.06	46	35	0.14	26	24	0.04	27	11	0.42
195	98	0.33	175	75	0.40	255	120	0.36	12	8	0.20
144	56	0.44	142	54	0.45	207	73	0.48	3	2	0.20
27	19	0.17	13	7	0.30	21	18	0.08	5	2	0.43
24	23	0.02	20	14	0.18	27	29	-0.04	4	5	-0.11
112	271	-0.42	128	272	-0.36	153	328	-0.36	139	259	-0.30
81	202	-0.43	102	211	-0.35	130	268	-0.35	93	179	-0.32
16	74	-0.64	33	103	-0.51	49	142	-0.49	32	76	-0.41
29	78	-0.46	29	60	-0.35	37	73	-0.33	32	64	-0.33
3	31	-0.82	6	28	-0.65	4	36	-0.80	4	17	-0.62
32	19	0.25	34	21	0.24	41	18	0.39	25	22	0.06
24	64	-0.45	21	58	-0.47	17	53	-0.51	40	73	-0.29
19	58	-0.51	18	50	-0.47	12	44	-0.57	30	61	-0.34
1	2	-0.33	1	3	-0.50	1	2	-0.33	2	3	-0.20
4	4	0.00	3	5	-0.25	3	7	-0.40	8	9	-0.06
7	5	0.17	4	4	0.00	7	7	0.00	6	7	-0.08
966	944	0.01	974	953	0.01	936	881	0.03	961	960	0.00
25	28	-0.06	35	40	-0.07	18	23	-0.12	38	37	0.01
32	31	0.02	20	16	0.11	25	22	0.06	25	25	0.00
181	155	0.08	195	166	0.08	174	130	0.14	188	156	0.09
3	3	0.00	2	2	0.00	2	2	0.00	2	3	-0.20
12	7	0.26	23	13	0.28	16	6	0.45	18	12	0.20
8	8	0.00	9	9	0.00	6	5	0.09	12	12	0.00
137	110	0.11	149	131	0.06	140	108	0.13	132	105	0.11
21	27	-0.13	12	11	0.04	10	9	0.05	24	24	0.00
728	729	-0.00	724	731	-0.00	720	705	0.01	711	742	-0.02
543	560	-0.02	568	583	-0.01	543	548	-0.00	553	584	-0.03
101	89	0.06	90	81	0.05	97	83	0.08	80	75	0.03
50	51	-0.01	47	46	0.01	45	43	0.02	39	50	-0.12
4	6	-0.20	2	4	-0.33	5	8	-0.23	5	7	-0.17
30	23	0.13	17	17	0.00	30	23	0.13	34	26	0.13

Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ЦАГ АШИГЛАЛТЫН ХҮЙСИЙН ЯЛГАА УЛИРАЛ ХООРОНД ӨӨРЧЛӨГДДӨГ ҮҮ?

Хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн хувьд эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа улирал хамаарахгүй ойролцоо түвшинд байна. Үндсэндээ улирлын ялгаа хөлсгүй хөдөлмөрт илүү илэрч буй бөгөөд эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хандлага бүх улиралд хадгалагдсан хэвээр байгаа ч 1 дүгээр улиралд ялгаа илүү өндөр, оны төгсгөл рүү дөхөх тусам хүйсийн харьцаа бага багаар буурдаг. Эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн ачаалал оны эхний саруудад өндөр байдаг гэсэн үг.

	I УЛИРАЛ		
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	293	184	0.23
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	168	128	0.14
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	100	88	0.06
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	18	3	0.71
- Ажилдаа явах, зорчих	25	17	0.19
- Бусад	25	19	0.14
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	125	56	0.38
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	104	39	0.45
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	13	9	0.18
- Бусад	8	9	-0.06
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	139	309	-0.38
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	106	229	-0.37
- Хоол хүнс бэлтгэх	38	97	-0.44
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	35	81	-0.40
- Хувцас, гутал угаах, арчлах	5	30	-0.71
- Бусад	29	22	0.14
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	29	75	-0.44
- Хүүхэд асрах	22	64	-0.49
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	2	0.00
- Бусад	5	9	-0.29
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	4	5	-0.11
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,008	947	0.03
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	44	35	0.11
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	18	18	0.00
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	182	130	0.17
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	3	-0.20
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	21	10	0.35
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	7	4	0.27
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	137	97	0.17
- Бусад	15	16	-0.03
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	764	764	0.00
- Унтах, амрах, босох	605	616	-0.01
- Хооллох, цай уух	95	88	0.04
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	35	37	-0.03
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	3	4	-0.14
- Бусад	26	19	0.16

Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цагийг чөлөөт цагт зарцуулах байдал 1 дүгээр улиралд өндөр байна. Харин хувийн хэрэгцээний цаг ашиглалт дахь хүйсийн ялгаанд улирлын нөлөө төдийлөн ажиглагдахгүй байна.


Дүрслэл 35. Цаг ашиглалт, улирлаар, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

II УЛИРАЛ			III УЛИРАЛ			IV УЛИРАЛ			
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	
349	227	0.21	356	235	0.20	353	222	0.23	
237	171	0.16	231	168	0.16	263	178	0.19	
168	128	0.14	153	116	0.14	182	132	0.16	
15	9	0.25	25	10	0.43	11	2	0.69	
33	20	0.25	32	27	0.08	34	25	0.15	
20	15	0.14	21	14	0.20	36	20	0.29	
112	56	0.33	125	68	0.30	90	44	0.34	
84	38	0.38	90	35	0.44	61	22	0.47	
9	6	0.20	9	9	0.00	17	10	0.26	
19	12	0.23	26	24	0.04	12	12	0.00	
131	269	-0.35	133	270	-0.34	140	263	-0.31	Хүйсийн харьцаа:
93	191	-0.35	96	203	-0.36	103	194	-0.31	-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй
26	77	-0.50	27	90	-0.54	33	87	-0.45	
24	64	-0.45	31	67	-0.37	32	65	-0.34	
5	24	-0.66	3	22	-0.76	5	21	-0.62	
38	26	0.19	36	24	0.20	34	20	0.26	0 - хүйсийн ялгаа байхгүй
31	68	-0.37	25	60	-0.41	32	63	-0.33	
25	60	-0.41	21	55	-0.45	23	51	-0.38	
2	3	-0.20	2	2	0.00	1	2	-0.33	1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй
4	5	-0.11	3	3	0.00	8	9	-0.06	
6	10	-0.25	12	7	0.26	5	6	-0.09	
960	944	0.01	951	935	0.01	947	955	-0.00	
36	36	0.00	16	15	0.03	31	42	-0.15	
26	25	0.02	31	26	0.09	24	26	-0.04	
199	164	0.10	171	151	0.06	167	146	0.07	
3	5	-0.25	2	2	0.00	1	1	0.00	
19	13	0.19	18	12	0.20	12	7	0.26	
16	13	0.10	9	14	-0.22	7	6	0.08	
128	103	0.11	123	101	0.10	135	119	0.06	
33	30	0.05	19	22	-0.07	12	13	-0.04	
699	719	-0.01	733	743	-0.01	726	741	-0.01	
545	565	-0.02	561	581	-0.02	552	575	-0.02	
87	84	0.02	89	79	0.06	90	80	0.06	
35	39	-0.05	42	47	-0.06	51	58	-0.06	
4	7	-0.27	4	6	-0.20	4	7	-0.27	
28	24	0.08	37	30	0.10	29	21	0.16	

Дүрслэл 36. Хүн амын амьдралын хэв маяг, 24 цагаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, дүнд эзлэх хувиар, 2023



ЭРЭГТЭЙЧҮҮД ЭМЭГТЭЙЧҮҮДЭЭС ОРОЙТОЖ УНТАХ, ОРОЙ ХООЛЛОХ ХАНДЛАГАТАЙ.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нойрны хэмнэл ерөнхийдөө ижил боловч эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс арай эрт унтах хандлагатай. Шөнийн 00 цагт эрэгтэйчүүдийн 85.9 хувь нь унтсан байдаг бол эмэгтэйчүүдийн 87.9 хувь нь унтсан байдаг.

Өглөөний цай уух, өдрийн хоол идэх хэмнэл мөн ойролцоо бол оройн хоолны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс оройтож хооллодог. Эрэгтэйчүүдийн дийлэнх нь оройны 17-21 цагийн хооронд хооллодог бол эмэгтэйчүүд ихэвчлэн орой 17-20 цагт хооллодог.

Эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй цаг эрэгтэйчүүдийнхтэй ижил боловч хөлсгүй хөдөлмөр идэвхтэй эрхлэх цаг нь эрэгтэйчүүдээс 1 цагаар өмнө эхэлдэг. Эмэгтэйчүүдийн 26.3-37.4 хувь нь өглөөний 7 цагаас оройны 20 хүртэл гэрийн ажил, гэр бүлийн гишүүдийг асрах гэх мэт хөлсгүй хөдөлмөр хийж байдаг.

Боловсролын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд илүү эртэч ханддаг буюу суралцах идэвхтэй цаг нь өглөөний 7 цагаас оройны 19 цаг хүртэл байхад эрэгтэйчүүдийн хувьд өглөөний 8 цагаас оройны 18 цаг хүртэл идэвхтэй суралцдаг байна.

Хүн амын чөлөөт цагаа зарцуулдаг гол үйл ажиллагаа болох олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах цаг нь эрэгтэйчүүдийн хувьд оройны 18-23 цагуудад идэвхтэй буюу эрэгтэйчүүдийн 11.1-33.6 хувь нь энэ цагт идэвхтэй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж байдаг. Эмэгтэйчүүдийн 8.9-27.6 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг мөн энэ цагт идэвхтэй ашигладаг.

Хооллох, унтахаас бусад хувийн хэрэгцээ болох хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад эрэгтэй, эмэгтэй хүмүүс адилхан өглөөний 6-10 цаг болон оройны 20-22 цагт илүү цаг зарцуулдаг.

Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тодорхой үйл ажиллагааг аль цагт гүйцэтгэж байгаа хэв маяг ихэнх үйл ажиллагааны хувьд төстэй боловч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс оройтож унтах, орой хооллох хандлагатай, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү эрт хөлсгүй хөдөлмөрийг идэвхтэй хийж эхэлдэг зэрэг амьдралын хэв маяг дахь ялгаа ажиглагдаж байна.

Унтах

Хоол идэх, цай уух

Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх

Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ

Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа



ТХЗ “5.4.1 ЦАЛИН ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛ, АСРАХ АЖИЛД ЗАРЦУУЛСАН ЦАГ” ҮЗҮҮЛЭЛТИЙГ ХЭМЖИХ НЬ

Хүний эрхийг хангасан тогтвортой хөгжлийг бүтээхэд зайлшгүй нэг нөхцөл нь жендерийн тэгш байдал юм. Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын 5-р зорилго нь “Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охидыг чадавхжуулах” бөгөөд үүнд хамаарах нэг шалгуур үзүүлэлтээр ТХЗ “5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг” үзүүлэлтийг тусгайлан авч үздэг.

Цалин хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулах, үнэлэгддэг болгох замаар хөлсгүй хөдөлмөрт их цаг зарцуулж буй хүйсийн хөдөлмөрийн үнэлэмжийн тэгш бус байдлыг арилгах нь дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн чухал суурь гэж тооцогдож байна. Эмэгтэй эсвэл эрэгтэй гэдгээс үл хамааран хөгжилд хувь нэмрээ оруулах, хөгжлийн үр шимийг хүртэх, сонголт хийх ижил тэгш боломжоор хангагдах нь чухал.

ТХЗ “5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг” үзүүлэлтийг Цаг ашиглалтын судалгааны үр дүнгээр тооцох боломжтой бөгөөд энэ нь цаг ашиглалтын үйл ажиллагааны ангилал дахь дараах хоёр үйл ажиллагааны нийлбэрээр хэмжигдэнэ. Үүнд:

1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх
2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

Тус үзүүлэлтийг хугацаа буюу цаг, минутаар хэмжихээс гадна долоо хоногийн нэг өдрийн 24 цагт эзлэх хувиар тооцдог. Мөн ТХЗ-ын үзүүлэлтийг хэмжих удирдамжид заасны дагуу “хэнийг ч орхигдуулахгүй” зарчмаар хүйс, нас, байршлаар задалж тооцдог. Насны хувьд олон улсад 12 ба түүнээс дээш болон 15 ба түүнээс дээш гэсэн ангиллыг түгээмэл ашигладаг.

ЦАЛИН ХӨЛСГҮЙ ГЭРИЙН АЖИЛ, АСРАХ АЖЛЫН ҮР ШИМИЙГ БҮГД ХҮРТДЭГ Ч ГҮЙЦЭТГЭЛ НЬ НЭГ ХҮЙСИЙН ҮҮРЭГ ХЭВЭЭР БАЙНА.

2023 оны байдлаар 12 ба түүнээс дээш насны хүн амын цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйсийн ялгааг авч үзвэл эрэгтэйчүүд өдөрт дунджаар 2 цаг 10 минут зарцуулж буй бол эмэгтэйчүүд үүнээс 2.0 дахин их буюу 4 цаг 26 минут зарцуулж байна. Хөлсгүй гэрийн ажил, асрах ажлын үр шимийг бүгд хүртдэг боловч гүйцэтгэх үүрэг нь эмэгтэйчүүдэд илүү хуваарилагдаж, хүйсийн тэнцвэрт харьцаа алдагдсан нь харагдаж байна. Эмэгтэйчүүд нэг өдрийн 24 цагийнхаа 18.5 хувийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулдаг бол эрэгтэйчүүд 9.0 хувийг зарцуулжээ.

2019 оны үр дүнтэй харьцуулахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйсийн ялгаа 30 минутаар буурсан үр дүнтэй байна. Тодруулбал, 2019 онд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад өдөрт дунджаар 2 цаг 46 минутаар илүү цагийг цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулж байсан бол 2023 онд эмэгтэйчүүд 2 цаг 16 минутаар илүү цагийг зарцуулах болжээ. Энэ нь эрэгтэйчүүдийн цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг 23 минутаар нэмэгдэж, эмэгтэйчүүдийнх 7 минутаар буурсантай холбоотой. Хүйсийн ялгаа буурч байгаа ч хөлсгүй хөдөлмөрийг үнэлэх, гэр бүл дэх хөлсгүй хөдөлмөрийн үүргийг гэр бүлийн гишүүд тэгш хуваалцах хандлагыг бий болгох замаар ТХЗ-ын холбогдох үзүүлэлтийг 2030 он гэхэд тэнцвэрт байдлыг хангасан түвшинд хүргэхэд өөрчлөлтийн энэхүү хурд хараахан гүйцэхээргүй байна.

Хөдөлмөрийн үнэлэмжийн ялгаатай байдал нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавх, шийдвэр гаргах түвшин дэх оролцоо зэрэгт аль хэдийн тэгш бус байдлыг үүсгээд буйг олон статистик үзүүлэлтээс харж болно. Нөгөөтэйгүүр энэхүү ялгаа нь хүн амын насны бүлэг, амьдарч буй байршлаас үл хамааран илэрч байна.

Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйсийн ялгаа 25-44 насны бүлэгт хамгийн өндөр, 65 ба түүнээс дээш насны бүлэгт харьцангуй бага боловч ялгаатай хэвээр. Хотод эмэгтэйчүүд цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд эрэгтэйчүүдээс 1.9 дахин их цагийг зарцуулж буй бол хөдөөд 2.3 дахин их цагийг зарцуулж, ялгаа улам гүнзгийрсэн төлөвтэй. Хот, хөдөөгийн энэ ялгаа бүх насны бүлэгт ажиглагдаж байна. Энэ нь тус үзүүлэлтийн хувьд хүйсийн ялгаанаас гадна хот, хөдөөгийн ялгааг давхар анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Дүрслэл 37. ТХЗ "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг", хүйс, нас, хот, хөдөөгөөр, 2019, 2023

Долоо хоногийн нэг өдөрт, хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 24 цагт эзлэх хувиар



Дүрслэл 38. ТХЗ "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг", хүйс, насны бүлэг, хот, хөдөөгөөр, 2023

Долоо хоногийн нэг өдөрт, хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 24 цагт эзлэх хувиар




МОНГОЛ УЛСЫН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГАА ӨНДӨР ОРЛОГОТОЙ ОРНУУДАЙ ХАРЬЦУУЛАХАД ИХ БАЙНА.

НҮБ-ын ТХЗ-ын хэрэгжилтийн явцын мэдээгээр 2000-2022 оны статистикаас харахад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 2.5 дахин илүү цагийг цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулж байна.⁷ Дэлхий даяар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү хөдөлмөрийн зах зээлд оролцох, эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрийг хариуцах хандлагатай.

Монгол Улс нь Дэлхийн банкнаас гаргадаг орлогын ангиллаар⁸ дундаас дээгүүр дунд орлоготой орны ангилалд багтаж буй бөгөөд ижил орлогын ангилалд багтах Бразил, Мексик, БНХАУ, Гүрж улсуудтай харьцуулахад цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цагийн хүйсийн ялгаа харьцангуй бага ажээ. Тухайлбал, Гүрж улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 4.8 дахин их цагийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулдаг бол БНХАУ-д 2.6 дахин их цагийг зарцуулж байна.

Дүрслэл 39. ТХЗ "5.4.1 Цалин хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулсан цаг", хүйсээр, улсаар

15 ба түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, 24 цагт эзлэх хувиар, ЦАС явагдсан оноор




Эх сурвалж: <https://unstats.un.org/sdgs/dataportal/database>, 2024.06.28-нд шинэчлэгдсэн байдлаар

⁷ https://sdgs.un.org/goals/goal5#progress_and_info

⁸ Дэлхийн банкны 2024-2025 оны улс орнуудын орлогын ангилал, 2024.07.01-ны байдлаар

Хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хандлага дэлхийн ихэнх улс орнуудад ижил боловч өндөр орлоготой улсуудад, тухайлбал Их Британи, Финлянд, Канад, Австрали, АНУ, Швейцар, ХБНГУ улсуудад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 1.3-1.6 дахин их цагийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулж буй нь бага, дунд орлоготой улс орнуудтай харьцуулахад хэд дахин бага байна.

Монгол Улсын хувьд эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүдээс 2.1 дахин их цагийг зарцуулж буй нь өндөр хөгжилтэй улс орнуудтай харьцуулахад хүйсийн ялгаа гүнзгийрснийг илтгэж буй юм. Харин зарим өндөр орлоготой улсууд, жишээ нь ОХУ, БНСУ, Япон улсад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2.3-3.9 дахин их цагийг хөлсгүй гэрийн ажил, асрах ажилд зарцуулж буй нь хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа эдийн засаг, нийгэм, соёлын олон хүчин зүйлээс хамааралтай болохыг харуулж байна.



4.3.

ЦАГ АШИГЛАЛТ БА АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ

Хүн амын амьдралын мөчлөг буюу наснаас хамааран амьдрах хэв маяг, дадал хувьсан өөрчлөгдөж байдаг.

Хүүхэд нас нь хөгжих, идэвхтэй суралцах үе. Насанд хүрмэгц хөдөлмөр эрхлэлтэд цаг зарцуулах нь нэмэгдэж, хийж бүтээхэд төвлөрнө. Ахмад насанд хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг байсан цаг хувийн хэрэгцээ, амрах цаг руу шилжинэ. Энэ насанд хөлстэй хөдөлмөр эрхлэлт буурдаг ч хөлсгүй хөдөлмөр эрхлэлт үргэлжилсээр байна.

ХҮН АМЫН АМЬДРАЛЫН МӨЧЛӨГИЙГ ДАГАН ЦАГ АШИГЛАЛТЫН ТӨЛӨВ ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДДӨГ.

Цаг ашиглалтын судалгаа нь 12 ба түүнээс дээш насны хүн амын өдөр тутмын үйл ажиллагааны цаг ашиглалтыг хэмждэг. Хүн амын цаг ашиглалтын төлөвийг насны бүлгээр авч үзэхэд тодорхой ялгаа, хувьсал ажиглагдаж байна. 12-17 насанд суралцах болон чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цагт хамгийн их цаг зарцуулдаг. 12-17 насны хүүхдүүд боловсрол эзэмшихэд долоо хоногийн нэг өдөр дунджаар 4 цаг 23 минутыг зарцуулж байна. 18-24 наснаас эхлэн боловсролд зарцуулах цаг буурч, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд цаг зарцуулах нь нэмэгдэнэ. 18-24 насны хүн ам боловсролын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 1 цаг 24 минут зарцуулдаг бол 25-39 насанд энэ хугацаа 6 минут, 40 ба түүнээс дээш насанд 2 минут болж буурна.

Хүн амын хөдөлмөр эрхлэлт 18-24 насны бүлгээс эхлэн идэвхжих ба 25-39 насанд оргил үедээ хүрч, 59 нас хүртэл идэвхтэй үргэлжилсээр 60 ба түүнээс дээш наснаас буурч эхэлдэг.

18-24 насанд долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн дунджаар 18.4 хувь (4 цаг 25 минут)-ийг хөлстэй хөдөлмөрт, 12.8 хувь (3 цаг 5 минут)-ийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. 25-39 насанд хөлстэй хөдөлмөрт 24 цагийн дунджаар 24.9 хувь (5 цаг 59 минут)-ийг, хөлсгүй хөдөлмөрт 16.4 хувь (3 цаг 56 минут)-ийг зарцуулах буюу хөдөлмөр эрхлэлт хамгийн идэвхтэй үедээ ирдэг. 40-59 насанд хөдөлмөр эрхлэлт бага зэрэг буурах хэдий ч идэвхтэй хэвээр байх ба хөлстэй хөдөлмөрт өдрийн 24 цагийн дунджаар 24.0 хувь (5 цаг 46 минут)-ийг, хөлсгүй хөдөлмөрт 15.0 хувь (3 цаг 36 минут)-ийг зарцуулж байна. 60 ба түүнээс дээш насанд хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг эрс буурахаас гадна хөдөлмөр эрхлэлтийн төлөв хөлстэйгээс хөлсгүйд шилжих хандлагатай. Энэ үед хөлстэй хөдөлмөр эрхлэлт өдрийн 24 цагийн дунджаар 8.1 хувь (1 цаг 57 минут)-ийг эзлэх ба хөлсгүй хөдөлмөр эрхлэлт өдрийн 24 цагийн дунджаар 15.3 хувь (3 цаг 41 минут)-ийг эзэлж байна.

12-17 болон 60 ба түүнээс дээш насны хүн ам чөлөөт цагт хамгийн их цаг зарцуулдаг. 12-17 насны хүүхдүүд долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн 14.7 хувь (3 цаг 31 минут)-ийг чөлөөт цагт зарцуулдаг. 60 ба түүнээс дээш насанд хөлстэй хөдөлмөр эрхлэлт буурсантай холбоотой илүү цаг нь чөлөөт цаг руу шилжих ба энэ насны хүн ам чөлөөт цагт өдрийн 24 цагийн дунджаар 18.3 хувь (4 цаг 23 минут)-ийг чөлөөт цагт зарцуулдаг. 18 наснаас хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нэмэгдсэнээр 18-24 насныхны чөлөөт цаг буурч, өдрийн 24 цагийн 9.2 хувь (2 цаг 12 минут)-ийг эзэлж байна. Харин 25-39 насанд чөлөөт цагт хамгийн бага буюу өдөрт дунджаар 1 цаг 49 минут зарцуулдаг бол 40 ба түүнээс дээш насанд чөлөөт цаг өмнөх насны бүлгээс нэмэгдэж, 2 цаг 23 минут болно.

Хүн амын чөлөөт цагаа өнгөрүүлэх гол хэлбэр нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах буюу энэ нь аль ч насны бүлэгт илрэх ба 12-59 насанд өдөрт дунджаар 1 цаг 20-55 минут зарцуулдаг бол хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо буурсан 60 ба түүнээс дээш насныхны хувьд өдөрт дунджаар 3 цаг 19 минутыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулж байна.

Унтах, амрахад 12-17 насны хүүхдүүд өдөрт дунджаар 10 цаг 22 минут, 60 ба түүнээс дээш насныхан 10 цаг 28 минут зарцуулж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бол 18-24 насанд энэ үйл ажиллагаанд өдөрт дунджаар 9 цаг 54 минут, 25-39 насанд 9 цаг 6 минут, 40 ба түүнээс дээш насанд 9 цаг 7 минут тус тус зарцуулжээ.

Дүрслэл 40. Цаг ашиглалт, насны бүлгээр


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




25-39 HAC

40-59 HAC

60+ HAC



359



346



117



236



216



221



6



2




2




132




165




298



546



547



628



161



164



174


| — 1 минут

Дүрслэл 41. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, насны бүлгээр


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




25-39 HAC




287



40-59 HAC




242




60+ HAC



60




72



104




57




236




216




221




150



170




181




81



38



30



5


8

10

Дүрслэл 42. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, насны бүлгээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

263

84

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

16


23

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

211

132

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 7
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 54
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 17
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 115
- Бусад 18
















3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

762

752

- Унтах, амрах, босох 622
- Хооллох, цай уух 73
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 44
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 2
- Бусад 22





ХҮҮХДҮҮД ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАГҮЙ ХЭСГИЙГ ХАРИУЦДАГ.

12-17 насны хүүхдүүдийн хувьд хангалттай нойр авах нь чухал бөгөөд энэ насныхан өдөрт дунджаар 10 цаг 22 минутыг унтахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулж буй нь 18-59 насны хүн амтай харьцуулахад 28 минутаас 1 цаг 16 минутаар илүү цаг зарцуулжээ. Үүний дараа сэрүүн байх цагийнхаа дийлэнхийг боловсролын үйл ажиллагаанд болон чөлөөт цагтаа зориулдаг.

Боловсролын үйл ажиллагаанд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 4 цаг 23 минутыг зарцуулж байгаа нь 12-17 нас суралцах хамгийн идэвхтэй нас болохыг харуулж байна. Энэ насныхан өдөрт дунджаар 3 цаг 31 минутыг чөлөөт цагт зарцуулах боломжтой буюу 18-59 насны хүн амтай харьцуулахад 1.5-1.9 дахин их чөлөөт цагтай байдаг ажээ.

Харин эдгээр үйл ажиллагааны дараа цагаа зарцуулдаг гол үйл ажиллагаанд нь хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлт багтана. Тэд ААНБ-д ажиллах гэх мэт гэрээт хөдөлмөр эрхлэх нь бага ч өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд мал аж ахуй эрхлэх байдлаар оролцох болон бусад хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар 1 цаг 13 минутыг зарцуулдаг. 12-17 насны хүүхдүүд хөлстэй хөдөлмөрөөс гадна хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд багагүй хугацааг зарцуулдаг.

Хөлсгүй хөдөлмөрт хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан цагаас 42 минутаар илүү буюу өдөрт дунджаар 1 цаг 55 минутыг зарцуулах ба үүнийг үйл ажиллагаагаар задалж харвал хоол хүнс бэлтгэхэд өдөрт дунджаар 34 минут, гэр цэвэрлэхэд 32 минут, хүүхэд асрахад 26 минутыг тус тус зарцуулж, гэр бүлийн хөлсгүй хөдөлмөрийн тодорхой хэсгийг хариуцаж байна.

Тэд хүмүүстэй харилцахад бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн бага буюу өдөрт дунджаар 16 минутыг зарцуулах ба чөлөөт цагаа өнгөрүүлдэг гол үйл ажиллагаанууд нь олон нийтийн мэдээлэл хэрэгсэл ашиглах болон хобби, тоглоом, спортоор хичээллэх зэрэг юм. Чөлөөт цагтаа нийт 3 цаг 31 минутыг өдөрт дунджаар зарцуулж байгаагаас 54.5 хувь (1 цаг 55 минут) нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад, 25.6 хувь (54 минут) нь хобби, тоглоом, бусад чөлөөт цагт, 8.1 хувь (17 минут) нь спортоор хичээллэхэд, 3.3 хувь (7 минут) нь соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэхэд зарцуулагдаж байна. Энэ насны хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх гол хэлбэр нь олон нийтийн мэдээлэл хэрэгсэл ашиглах хэдий ч бусад насны бүлэгтэй харьцуулахад хобби, тоглоом, спорт, соёлын болон спортын арга хэмжээнд оролцоход хамгийн их цагийг зарцуулж байна.

12-17 насны хүүхдүүд хооллоход өдөрт дунджаар 1 цаг 13 минутыг зарцуулж буй нь бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн бага буюу бусад насны бүлгээс өдөрт дунджаар 9-16 минут бага зарцуулжээ. Харин хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад бусад насны бүлэгтэй харьцуулахад ерөнхийдөө ойролцоо буюу өдөрт дунджаар 44 минутыг зарцуулсан байна.

18-24 НАСАНД ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОН ХҮМҮҮСТЭЙ ХАРИЛЦАХАД ЗАРЦУУЛАХ ЦАГ НЭМЭГДЭЖ ЭХЭЛДЭГ.

18-24 насанд хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэж эхлэх ба хөлстэй хөдөлмөр, тэр дундаа ААНБ-д ажиллах цаг нэмэгдэнэ. Энэ насанд хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар 4 цаг 25 минут зарцуулах ба үүний 70.6 хувь нь ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулагдаж байна. Үүний хажуугаар өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд мөн оролцоно. Үүнд өдөрт дунджаар 1 цаг 18 минутыг зарцуулжээ.

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг өмнөх насны бүлгээс нэмэгдэх ба өдөрт дунджаар 3 цаг 5 минут зарцуулж байна. Хөлсгүй хөдөлмөрийн тухайд хүүхэд асрахад өдөрт дунджаар 51 минут, хоол хүнс бэлтгэхэд 48 минут, гэр цэвэрлэхэд 39 минут, хувцас угаахад 13 минут зарцуулжээ. Мөн цалин хөлсгүй сайн дурын ажилд энэ насны хүн ам өдөрт дунджаар 7 минутыг зориулах ба хүмүүстэй харилцах цаг өмнөх насны бүлгээс нэмэгдэж, өдөрт дунджаар 23 минутыг зарцуулж байна.

Хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнээр 18-24 насанд чөлөөт цаг өмнөх насны бүлгээс 1.6 дахин хумигдаж, өдөрт дунджаар 2 цаг 12 минутыг зарцуулах болжээ.

Хүүхэд наснаас “том хүн” болох шилжилтийн энэ насанд чөлөөт цагаа бууруулахдаа өмнөх насны бүлэгтэй харьцуулахад хобби, тоглоомд зарцуулсан цагаа хамгийн их хувиар буюу 66.7 хувиар, түүний дараа соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх цагаа 57.1 хувиар, спортоор хичээллэх цагаа 41.2 хувиар бууруулсан бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах цагаа хамгийн багаар буюу 20.0 хувиар бууруулсан байна. Аль ч насны бүлгийн хүн ам тодорхой цагийг чөлөөт цагтаа зарцуулдаг боловч нас нэмэгдэх тусам хөдөлгөөний идэвх бага шаардах үйл ажиллагаанд, тэр дундаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах үйл ажиллагаанд чөлөөт цагийнхаа дийлэнхийг зарцуулах нь нийгмийн нэг үзэгдэл болсон гэж хэлж болохоор байна.

18-24 насанд унтах, амрахтай холбоотой цаг өмнөх насны бүлгээс 28 минутаар буурах буюу өдөрт дунджаар 9 цаг 54 минутыг зарцуулж байна. Мөн боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зарцуулах цаг өдөрт дунджаар 1 цаг 24 минут болж, өмнөх насны бүлгээс 3.1 дахин буурчээ. Гэхдээ 25 ба түүнээс дээш насныхантай харьцуулахад 18-24 насанд суралцах идэвх өндөр хэвээр байна.

25-59 НАС НЬ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ХАМГИЙН ИДЭВХТЭЙ НАС.

Хүн амын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг 25-39 болон 40-59 насны мөчлөгт хамгийн өндөр байдаг. Энэ нь хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн аль ч төлөвт илэрч байна.

25-39 насанд хамгийн идэвхтэй хөдөлмөр эрхлэх буюу долоо хоногийн нэг өдөрт дунджаар 5 цаг 59 минутыг хөлстэй хөдөлмөрт, 3 цаг 56 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй нь энэ насны бүлгийн өдрийн сэрүүн байх дундаж хугацааны 66.6 хувийг эзэлж байна.

Харин 40-59 насанд өмнөх насны бүлгээс хөдөлмөр эрхлэх идэвх бага хэмжээгээр буурч хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд 5 цаг 46 минут, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд 3 цаг 36 минут зарцуулах боловч энэ нь 25-39 насны бүлгээс харгалзан 13 минут ба 20 минутаар тус тус бага байгаа нь хөдөлмөр эрхлэлт идэвхтэй хэвээр байгааг харуулж буй юм.

25-39 насанд хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагийн дийлэнх буюу 79.9 хувийг ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа эзлэх бол 40-59 насанд энэ хувь 69.9 болж буурах ба өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо 40-59 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр болно.

Хөлсгүй хөдөлмөр дэх оролцоо 25-39 насанд нэмэгдэж, өдөрт дунджаар 3 цаг 56 минут зарцуулдаг бол 40-59 насанд 3 цаг 36 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. 25-39 насныхны хөлсгүй хөдөлмөрт зарцуулж буй цагийн 1 цаг 10 минут нь хүүхэд асрахад зарцуулагдаж буй нь тэдний хөлсгүй хөдөлмөр дэх хамгийн өндөр хувь эзлэх үйл ажиллагааны төрөл юм. 40-59 насанд хүүхэд асрахад өдөрт дунджаар 29 минут зарцуулах буюу хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа нь хүүхэд асрахаас гэрийн ажил хийх үйл ажиллагаа руу шилжих хандлагатай.

Хөдөлмөр эрхлэлт идэвхтэй наснаас эхлэн боловсролд зарцуулах цаг эрчимтэй буурч эхлэх ба 25-39 насны бүлгийн хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 6 минутыг, 40-59 насны хүн ам 2 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж байна. Тэд хүмүүстэй харилцах, олон нийтийн арга хэмжээнд оролцоход өдөрт дунджаар 22-23 минутыг зарцуулжээ.

25-39 насанд чөлөөт цаг болон унтах, амрах цагууд хамгийн бага түвшинд хүрдэг. Өдөрт дунджаар 9 цаг 6 минутыг унтахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулах ба чөлөөт цагт долоо хоногийн нэг өдөрт дунджаар 1 цаг 49 минутыг хуваарилдаг. Энэ насны хүн амын чөлөөт цагийн 73.4 хувь нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зориулагдах ба өмнөх насны бүлгүүдтэй харьцуулахад хобби, тоглоом, спортоор хичээллэхэд зарцуулах цаг эрс багассан байна. 40-59 насанд 25-39 насныхантай харьцуулахад хөдөлмөр эрхлэлт, боловсролын үйл ажиллагаанаас буурсан зарим цагууд нь тэдний чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цаг руу шилжиж байна. Тэд чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 2 цаг 23 минутыг зарцуулсан нь 25-39 насны бүлэгтэй харьцуулахад 34 минутаар илүү байна.

ТЭТГЭВРИЙН НАСНААС ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ДЭХ ОРОЛЦОО ЭРС БУУРЧ, ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛАХ ЦАГ НЭМЭГДДЭГ.


Монгол Улсад өндөр насны тэтгэврийг 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй тогтоолгон авах эрхтэй⁹ бөгөөд ерөнхийдөө тэтгэврийн наснаас эхлэн хөлстэй хөдөлмөр эрхлэлт буурч эхэлдэг. 60 ба түүнээс дээш насанд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлт өмнөх насны бүлэгтэй харьцуулахад 39.9 хувиар буурч байна. Харин бүтцийн хувьд өмнөх насны бүлгээс хөлстэй хөдөлмөр эрхлэлт 66.2 хувиар буурах бол хөлсгүй хөдөлмөр эрхлэлт 2.3 хувиар нэмэгджээ.

60 ба түүнээс дээш насны хүн ам хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар 1 цаг 57 минутыг зарцуулж байна. Үүнээс 1 цагийг ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулж буй нь энэ насны хүн амын зарим хэсэг цалин хөлстэй хөдөлмөр эрхлэлтээс тэтгэвэрт гарах үйл явц руу шууд шилжилгүй хөлстэй хөдөлмөр эрхэлсээр байгаа ч дийлэнх нь хөлстэй хөдөлмөр эрхлэлтээ зогсоосныг харуулж байна. ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цагийг насны дэлгэрэнгүй бүлгээр харвал 50-59 насны бүлгээс эхлэн хөдөлмөр эрхлэлт буурах хандлага илэрч байна. Хөдөлмөр эрхлэлт идэвхтэй 40-49 насны бүлэгтэй харьцуулахад 50-59 насанд хөдөлмөр эрхлэлт 22.1 хувиар, 60-69 насанд 70.5 хувиар, 70 ба түүнээс дээш насанд 91.1 хувиар буурч байна.

60 ба түүнээс дээш насныхан хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 3 цаг 41 минутыг зарцуулж байгаа нь өмнөх насны бүлэгтэй харьцуулахад өссөн бөгөөд бүтцийн хувьд хүүхэд асрах цаг буурсан бол гэрийн ажилд зарцуулах цаг нэмэгджээ. Мөн энэ насанд амрах, хувийн арчилгаанд зориулах цаг, чөлөөт цаг нэмэгддэг. Чөлөөт цагт өдөрт дунджаар 4 цаг 23 минутыг зарцуулж байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаанд хамгийн их цаг зарцуулах боломжтой насны бүлэг болж байна. Энэхүү чөлөөт цагийн дийлэнх нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зориулагдаж байна. Тэтгэврийн насны хүн амын цаг ашиглалтад хөлстэй хөдөлмөр эрхлэлт эрс буурч, эсрэгээрээ хөлсгүй хөдөлмөр нэмэгдэхээс гадна чөлөөт цагаа зарцуулж буй үйл ажиллагаа нь бүтцийн хувьд төдийлөн олон янз бус байгаа нь тэдний амьдралын хэв маягт ямар нэг байдлаар зохист байдал алдагдсан болохыг илэрхийлж байх магадлалтай.

Дүрслэл 43 . Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, насны бүлгээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



⁹ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, 2023

АЖЛЫН, АМРАЛТЫН ӨДРИЙН ЦАГ АШИГЛАЛТЫН ЯЛГАА НАС АХИХ ТУСАМ БУУРДАГ.

Улсын дунджаар хүн амын цаг ашиглалт ажлын болон амралтын өдөр ялгаатай бөгөөд амралтын өдөр хөдөлмөр эрхлэлт хөлстэйгөөс хөлсгүйд шилжиж, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг нэмэгдэх хандлагатай. Энэхүү хандлага хүн амын насны бүлгээр ялгаатай эсэхийг тодруулбал 60 ба түүнээс дээш насны хүн амын хувьд ажлын болон амралтын өдрийн ялгаа бага, харин бусад насны бүлэгт дээрх хандлага илэрч байна.

12-17 насанд хөлсгүй хөдөлмөр эрхлэх цаг бусад насны бүлэгтэй харьцуулахад бага хэдий ч амралтын өдөр хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нь хамгийн их хувиар нэмэгддэг буюу ажлын өдөр өдөрт дунджаар 1 цаг 42 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан бол амралтын өдөр 53.9 хувь нэмэгдэж, 2 цаг 37 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Үүнд гэрийн ажилд зарцуулах цаг амралтын өдөр 1 цаг 57 минут болж, ажлын өдрөөс 60.3 хувиар нэмэгдэхээс гадна хүүхэд асрахад зарцуулах цаг 32 минут болж, ажлын өдрөөс 33.3 хувиар нэмэгддэг аж.

Хүн амын хөлсгүй хөдөлмөр дэх оролцоо амралтын өдөр нэмэгдэх хандлага нь 18-49 насанд илүү ажиглагдах ба 18-24 насанд хөлсгүй хөдөлмөр эрхлэх цаг ажлын өдөртэй харьцуулахад амралтын өдөр 9.4 хувь (17 минут), 25-39 насанд 21.5 хувь (48 минут), 40-59 насанд 22.0 хувь (45 минут)-иар тус тус нэмэгдэж байна.

18-49 насанд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг амралтын өдөр 21.1-25.8 хувиар буурдаг. Өөрөөр хэлбэл ажлын өдөртэй харьцуулахад амралтын өдөр хөдөлмөрийн идэвхтэй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг дунджаар 59 минутаас 1 цаг 39 минутаар буурч буй юм.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цагийн амралтын болон ажлын өдрийн ялгаа нь 12-17 насныхны хувьд боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цаг хумигдсантай холбоотойгоор чөлөөт цаг нь амралтын өдөр 3 цаг 8 минутаас 4 цаг 40 минут болж 48.9 хувиар нэмэгдэж буйгаар илэрч байна. Энэ насны хүн ам ажлын өдөрт дунджаар 5 цаг 14 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулах ба энэ нь амралтын өдөр 66.6 хувиар буурч 1 цаг 45 минут болжээ. Цаашилбал энэ насныхан амралтын өдөр унтах, амрах, хооллоход илүү цаг зарцуулах ба чөлөөт цагийн бүхий л үйл ажиллагааны цаг нь нэмэгдэж байна.

18-59 насанд хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулах цаг амралтын өдөр буурсны нөлөөгөөр өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж байна. Нарийвчилбал, 18-24 насанд энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг амралтын өдөр 4.3 хувь (42 минут), 25-39 насанд 6.1 хувь (51 минут), 40-59 насанд 3.8 хувь (33 минут)-иар тус тус нэмэгджээ. Харин 60 ба түүнээс дээш насанд амралтын өдөр өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулах цаг нь бага зэрэг буурах (4 минут буурсан) хандлагатай байна. Ерөнхийдөө амралтын өдөр 60 ба түүнээс дээш насныхнаас бусад насны бүлэгт чөлөөт цагт зарцуулах цаг нэмэгддэг.

Унтах, амрах, босохтой холбоотой цаг 60 ба түүнээс дээш наснаас бусад насны бүлэгт амралтын өдөр нэмэгдэж байна.

Тухайлбал, амралтын өдөр 12-17 насныхны унтах цаг ажлын өдрөөс 58 минутаар, 18-24 насныхны хувьд 38 минутаар, 25-39 насанд 19 минутаар, 40-59 насанд 9 минутаар нэмэгдэх бол 60 ба түүнээс дээш насанд амралтын өдөр унтах цаг ажлын өдөртэй харьцуулахад 16 минутаар буурч байна. Амралтын өдөр хооллоход зарцуулах цаг 25-39 насны бүлгээс бусад насны бүлэгт ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай.

Насны бүлгээрх ажлын болон амралтын өдрийн цаг ашиглалтын ялгааг дүгнэвэл 12-17 насныхан амралтын өдөр хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагаа нэмэгдүүлэхээс гадна боловсролд зарцуулах цагаа хумьж, тэрхүү цагаа соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх, спорт, хобби гэх мэт чөлөөт цаг руугаа хуваарилдаг. Мөн амралтын өдөр тэдний олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулах цаг нэмэгддэг.

18-59 насныхан амралтын өдөрт хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагаа багасгаж, хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагаа нэмэгдүүлэх ба чөлөөт цагаа бага зэрэг нэмэгдүүлж, хүмүүстэй харилцах, спорт, хобби, соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах зэргээр чөлөөт цагаа өнгөрүүлдэг.

60 ба түүнээс дээш насанд ажлын болон амралтын өдрийн ялгаа арилдаг.

Дүрслэл 44. Цаг ашиглалт, насны бүлгээр, ажлын болон амралтын өдрөөр

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


12-17 НАС

	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	72	75	▲
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	30	12	▼
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	14	2	▼
- Орлого олох зорилгоор МAA эрхлэх	7	5	▼
- Ажилдаа явах, зорчих	5	4	▼
- Бусад	4	1	▼
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	42	63	▲
- Өрхийн хэрэглээнд зориулж МAA эрхлэх	25	40	▲
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	8	12	▲
- Бусад	9	11	▲
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	102	157	▲
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	73	117	▲
- Хоол хүнс бэлтгэх	32	41	▲
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	28	44	▲
- Хувцас, гутал угаах, арчлах	4	14	▲
- Бусад	9	17	▲
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	26	32	▲
- Хүүхэд асрах	24	32	▲
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	1	0	▼
- Бусад	1	1	-
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	3	8	▲
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,266	1,208	▼
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	314	105	▼
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	16	17	▲
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	188	280	▲
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	6	11	▲
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	46	78	▲
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	15	24	▲
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	105	147	▲
- Бусад	16	20	▲
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	748	806	▲
- Унтах, амрах, босох	608	666	▲
- Хооллох, цай уух	71	79	▲
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	44	43	▼
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	2	1	▼
- Бусад	23	18	▼


18-24 НАС			25-39 НАС			40-59 НАС			60+ НАС		
Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
280	221	▼	384	285	▼	365	287	▼	114	126	▲
210	122	▼	317	197	▼	265	173	▼	57	69	▲
154	78	▼	233	128	▼	186	114	▼	36	44	▲
9	19	▲	11	13	▲	13	16	▲	3	4	▲
33	19	▼	44	30	▼	34	19	▼	11	8	▼
14	6	▼	30	26	▼	32	24	▼	8	13	▲
70	99	▲	67	88	▲	100	114	▲	57	57	-
51	70	▲	47	61	▲	68	80	▲	34	34	-
8	14	▲	8	10	▲	12	14	▲	11	12	▲
12	15	▲	12	17	▲	20	20	-	12	11	▼
180	197	▲	223	271	▲	205	250	▲	223	215	▼
117	148	▲	137	187	▲	159	204	▲	180	182	▲
52	39	▼	59	68	▲	63	73	▲	73	73	-
34	53	▲	40	49	▲	55	62	▲	66	67	▲
11	21	▲	13	33	▲	11	30	▲	11	15	▲
22	35	▲	25	37	▲	30	39	▲	30	27	▼
57	40	▼	82	77	▼	39	36	▼	32	25	▼
55	39	▼	70	71	▲	29	27	▼	24	21	▼
0	0	-	1	1	-	2	3	▲	3	3	-
2	1	▼	11	5	▼	7	5	▼	5	1	▼
6	9	▲	4	7	▲	7	10	▲	11	8	▼
980	1,022	▲	833	884	▲	870	903	▲	1,103	1,099	▼
99	41	▼	8	1	▼	2	3	▲	1	2	▲
19	33	▲	20	33	▲	20	29	▲	31	43	▲
123	160	▲	103	129	▲	139	152	▲	264	264	-
1	9	▲	1	6	▲	1	1	-	2	3	▲
16	24	▲	8	12	▲	6	6	-	9	13	▲
10	10	-	4	7	▲	7	7	-	16	16	-
86	107	▲	77	90	▲	107	123	▲	200	195	▼
10	10	-	13	14	▲	18	15	▼	37	37	-
739	788	▲	702	721	▲	709	719	▲	807	790	▼
584	622	▲	541	560	▲	545	554	▲	632	616	▼
80	90	▲	85	85	-	87	90	▲	89	92	▲
46	43	▼	44	42	▼	44	45	▲	50	55	▲
3	1	▼	4	4	-	6	3	▼	12	5	▼
27	31	▲	28	31	▲	26	27	▲	24	23	▼

▲ Өссөн
▼ Буурсан
- Өөрчлөгдөөгүй


12-17 нас



18-24 нас







60+ нас



ДҮРСЛЭЛ 45. ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минуугаар, 2023



ЦАГ АШИГЛАЛТ ДАХЬ ХҮЙСИЙН ЯЛГАА БАГА НАСНААС ЭХЭЛДЭГ.

Насны бүлгээрх цаг ашиглалтын хүйсийн ялгаа нь хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа болон чөлөөт цагт илрэх ба энэ ялгаа бага наснаас буюу 12-17 наснаас эхэлж, 18 ба түүнээс дээш насанд илүү гүнзгийрдэг дүр зураг ажиглагдаж байна. Үндсэндээ хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд илүү цаг зарцуулах, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд их цаг зарцуулах болон чөлөөт цагт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их цаг гаргадаг хандлага аль ч насны бүлэгт илэрдэг ажээ.

12-17 насанд хөвгүүд охидоос 1.8 дахин их цагийг буюу 42 минутаар илүү цагийг хөлстэй хөдөлмөрт (хөвгүүд 1 цаг 35 минут, охид 53 минут) зарцуулдаг бол охид хөвгүүдээс 1.5 дахин их цагийг буюу 47 минутаар илүү цагийг хөлсгүй хөдөлмөрт (хөвгүүд 1 цаг 31 минут, охид 2 цаг 18 минут) зарцуулж байна. Хөвгүүд өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү оролцоотой бол охид гэр цэвэрлэх, хоол, хүнс бэлтгэх, хувцас угаах болон хүүхэд асрахад хөвгүүдээс илүү цаг зарцуулж байна.

Үүнээс гадна энэ насны охид боловсролд хөвгүүдээс долоо хоногийн нэг өдөрт дунджаар 54 минутаар илүү цаг зарцуулах ба эсрэгээрээ хөвгүүд охидоос өдөрт дунджаар 47 минутыг чөлөөт цагт илүү зарцуулж байна. Мөн хөвгүүд унтах, амрахад охидоос арай илүү цаг (өдөрт дунджаар 15 минутаар илүү) зарцуулсан бол хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахихад охид хөвгүүдээс илүү цаг (өдөрт дунджаар 6 минутаар илүү) зарцуулжээ.

Хөвгүүд, охидын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн цаг ашиглалтад илэрч буй энэ ялгаа аль ч насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цаг ашиглалтад хадгалагдсаар байдаг гэж болно. Мөн бүх насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад чөлөөт цагт бага цаг зарцуулж байна.

18-24 насны хүн ам боловсролын үйл ажиллагаанд цаг зарцуулахын хажуугаар хөлстэй хөдөлмөрт идэвхтэй оролцож эхэлдэг. Энэ насны эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт эмэгтэйчүүдээс 1.6 дахин их буюу 1 цаг 59 минутаар илүү цагийг (эрэгтэйчүүд 5 цаг 28 минут, эмэгтэйчүүд 3 цаг 29 минут) зарцуулдаг бол эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.3 дахин их буюу 2 цаг 24 минутаар илүү цагийг хөлсгүй хөдөлмөрт (эрэгтэйчүүд 1 цаг 49 минут, эмэгтэйчүүд 4 цаг 13 минут) зарцуулж, хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа гүнзгийрч байна.

Энэ насны эрэгтэйчүүд ААНБ-д ажиллахад эмэгтэйчүүдээс 1.1 дахин их цагийг, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 2.7 дахин их цаг зарцуулж байна. Харин энэ насны эмэгтэйчүүд хоол хүнс бэлтгэхэд эрэгтэйчүүдээс 2.2 дахин их цагийг, гэр цэвэрлэхэд 2.8 дахин их цагийг, хувцас угаахад 3.3 дахин их цагийг зарцуулахаас гадна хүүхэд асрахад 7.9 дахин их цагийг зарцуулжээ. Өмнөх насны бүлгээс ялгаатай нь 18-24 насанд боловсролд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс арай их цагийг (эрэгтэйчүүд өдөрт дунджаар 1 цаг 28 минут, эмэгтэйчүүд 1 цаг 20 минут) зарцуулж байна. Мөн энэ насанд эмэгтэйчүүд хувийн хэрэгцээндээ эрэгтэйчүүдээс өдөрт дунджаар 36 минутаар илүү цаг зарцуулдаг бол эрэгтэйчүүд чөлөөт цагтаа эмэгтэйчүүдээс 43 минут илүү зарцуулсан байна.

25-39 насанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн хүйсийн ялгаа хамгийн өндөр түвшиндээ хүрч, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 2.4 дахин их буюу 3 цаг 11 минутаар илүү цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулжээ. Харин эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их буюу 2 цаг 35 минутаар илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулсан байна.

40-59 насанд хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа өндөр хэвээр ч өмнөх насны бүлгээс буурч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.4 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.9 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулжээ. 60 ба түүнээс дээш насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.8 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хөлстэй, хөлсгүй шинж чанараарх хүйсийн ялгаа нь насны бүлэгт харгалзах хөдөлмөр эрхлэлтийн идэвхийг даган өөрчлөгдөж буй нь харагдаж байна. Ялангуяа хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа хөдөлмөрийн хамгийн идэвхтэй 18-39 насанд оргил үедээ хүрээд, 40 наснаас хойш буурах буюу хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага зэрэг буурч, эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэх хандлага илэрч байна.

Ийнхүү хөлстэй хөдөлмөр эрхлэлт эрэгтэйчүүдэд, хөлсгүй хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдэд хуваарилагдах байдал эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг насан туршид дагах ба насны бүлгүүдэд нэмэгдэх, буурах хэдий ч тэнцвэржихгүй хэвээр байдаг аж.

Дүрслэл 46. Цаг ашиглалт, насны бүлгээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

12-17 НАС

	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	95	53	0.28
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	28	24	0.08
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	11	12	-0.04
- Орлого олох зорилгоор МAA эрхлэх	9	5	0.29
- Ажилдаа явах, зорчих	5	5	0.00
- Бусад	4	2	0.33
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	67	29	0.40
- Өрхийн хэрэглээнд зориулж МAA эрхлэх	44	15	0.49
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	11	7	0.22
- Бусад	12	7	0.26
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	91	138	-0.21
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	64	102	-0.23
- Хоол хүнс бэлтгэх	23	45	-0.32
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	23	40	-0.27
- Хувцас, гутал угаах, арчлах	4	9	-0.38
- Бусад	14	9	0.22
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	22	32	-0.19
- Хүүхэд асрах	21	30	-0.18
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	0	1	-1.00
- Бусад	1	1	0.00
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	5	4	0.11
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,254	1,249	0.00
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	235	289	-0.10
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	18	14	0.13
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	235	188	0.11
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	6	8	-0.14
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	76	34	0.38
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	22	13	0.26
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	114	116	-0.01
- Бусад	17	17	0.00
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	766	758	0.01
- Унтах, амрах, босох	630	615	0.01
- Хооллох, цай уух	73	73	0.00
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	41	47	-0.07
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	1	2	-0.33
- Бусад	22	22	0.00

18-24 НАС			25-39 НАС			40-59 НАС			60+ НАС		
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
328	209	0.22	442	287	0.21	410	290	0.17	162	91	0.28
211	166	0.12	341	240	0.17	274	215	0.12	81	48	0.26
144	126	0.07	238	178	0.14	184	155	0.09	48	31	0.22
19	5	0.58	18	6	0.50	20	8	0.43	7	1	0.75
34	25	0.15	47	34	0.16	35	27	0.13	14	7	0.33
15	9	0.25	38	21	0.29	34	26	0.13	11	8	0.16
117	43	0.46	101	47	0.36	136	75	0.29	81	43	0.31
86	28	0.51	75	29	0.44	102	44	0.40	55	21	0.45
12	6	0.33	10	8	0.11	14	12	0.08	17	8	0.36
18	8	0.38	16	10	0.23	20	20	0.00	9	14	-0.22
109	253	-0.40	133	324	-0.42	145	279	-0.32	160	259	-0.24
88	159	-0.29	85	206	-0.42	109	224	-0.35	133	211	-0.23
30	65	-0.37	26	92	-0.56	33	94	-0.48	41	93	-0.39
20	56	-0.47	19	63	-0.54	34	76	-0.38	51	76	-0.20
6	20	-0.54	4	30	-0.76	5	26	-0.68	5	17	-0.55
32	19	0.25	36	21	0.26	37	27	0.16	37	24	0.21
12	89	-0.76	43	113	-0.45	28	47	-0.25	19	37	-0.32
11	87	-0.78	35	101	-0.49	19	38	-0.33	13	29	-0.38
0	1	-1.00	1	1	0.00	2	3	-0.20	2	4	-0.33
1	2	-0.33	7	11	-0.22	7	7	0.00	3	5	-0.25
9	5	0.29	5	5	0.00	8	8	0.00	8	11	-0.16
1,003	978	0.01	865	829	0.02	885	872	0.01	1,118	1,090	0.01
88	80	0.05	7	6	0.08	1	3	-0.50	1	2	-0.33
28	18	0.22	26	21	0.11	22	23	-0.02	31	37	-0.09
154	111	0.16	125	95	0.14	156	130	0.09	296	241	0.10
2	4	-0.33	2	3	-0.20	1	1	0.00	2	2	0.00
22	14	0.22	12	7	0.26	7	5	0.17	9	11	-0.10
13	7	0.30	4	5	-0.11	6	8	-0.14	17	15	0.06
109	76	0.18	92	69	0.14	125	99	0.12	234	176	0.14
8	10	-0.11	15	11	0.15	17	17	0.00	34	37	-0.04
733	769	-0.02	707	707	0.00	706	716	-0.01	790	810	-0.01
579	608	-0.02	534	556	-0.02	541	553	-0.01	612	638	-0.02
83	82	0.01	91	80	0.06	92	84	0.05	95	86	0.05
41	48	-0.08	44	43	0.01	42	47	-0.06	45	55	-0.10
3	2	0.20	2	5	-0.43	4	7	-0.27	10	11	-0.05
27	30	-0.05	36	23	0.22	28	25	0.06	28	21	0.14

Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

СУУРЬШЛЫН ХӨДӨӨД АЛЬ Ч НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ӨНДӨР БӨГӨӨД ХҮЙСИЙН ЯЛГАА ИЛҮҮ ГҮНЗГИЙ.

Хүн амын хөлстэй болон хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нас харгалзахгүйгээр суурьшлын хөдөөд бусад суурьшилтай харьцуулахад хамгийн өндөр.

Нийслэл хотод амьдардаг 12-17 насны хүн ам өдөрт дунджаар 2 цаг 18 минутыг хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулдаг бол хөдөөд амьдардаг 12-17 насны хүн ам үүнээс 2.7 дахин их буюу 6 цаг 15 минутыг хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулдаг. 18-24 насанд нийслэлд 7 цаг, хөдөөд 9 цаг 17 минут, 25-39 насанд нийслэлд 10 цаг 9 минут, хөдөөд 10 цаг 13 минут, 40-59 насанд нийслэлд 9 цаг 28 минут, хөдөөд 10 цаг 2 минут, 60 ба түүнээс дээш насанд нийслэлд 5 цаг 11 минут, хөдөөд 7 цаг 54 минутыг тус тус хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байна.

Хөдөлмөрийн идэвхтэй нас буюу 18-59 насанд нийслэлд амьдарч буй хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг өндөр байгааг эс тооцвол үндсэндээ төвөөс алсрах тусам хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нэмэгддэг. Энэ хандлага 12-17 болон 60 ба түүнээс дээш насны бүлэгт хамгийн их ажиглагдах бол 18-59 насны бүлэгт нийслэл хот болон хөдөөд хөдөлмөр эрхлэлт өндөр, аймгийн төв, сумын төвд хөдөлмөр эрхлэлт арай бага байна.

Хөдөөд хөдөлмөр эрхлэлт өндөр учраас өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг нийслэлтэй харьцуулахад аль ч насны бүлэгт бага байна. Мөн 12-24 болон 60 ба түүнээс дээш насны нийслэл, аймгийн төвд амьдардаг хүн ам бусад суурьшилд амьдардаг хүн амаас илүү цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зарцуулах хандлагатай бол 25-59 насны хүн амын хувьд аймгийн төв, сумын төвд амьдардаг бол илүү их цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулж байна.

Хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа нь хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэх тусам гүнзгийрнэ. Бүх насны бүлэгт, суурьшлын бүх байршилд хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулж байна. Суурьшлын хөдөөд, эсвэл сумын төвд нийслэл хоттой харьцуулахад хөлстэй, хөлсгүй аль аль хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа өндөр байна. 12-17 насны бүлэгт нийслэл хотод хөлстэй хөдөлмөрт хөвгүүд охидоос 1.1 дахин их цагийг зарцуулдаг бол аймгийн төвд 2.0 дахин, сумын төвд 2.8 дахин, хөдөөд 1.9 дахин их цагийг зарцуулж байна. 18-24 насанд нийслэл хотод эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.3 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулах ба төвөөс алсрах тусам хүйсийн ялгаа гүнзгийрч аймгийн төв болон сумын төвд 1.5 дахин, хөдөөд 1.9 дахин их цагийг зарцуулж байна. 25 ба түүнээс дээш насанд нийслэл хот дахь хөлстэй хөдөлмөрийн хүйсийн ялгаа нэмэгдэж, 25-39 насны бүлэгт нийслэл, аймгийн төв, сумын төвд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулах ба хөдөөд 1.6 дахин их цагийг зарцуулдаг. 40-59 насанд аймгийн төв, сумын төвд эрэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлт эмэгтэйчүүдийнхээс 1.3 дахин их бол нийслэл хот, хөдөөд энэ ялгаа 1.4 ба 1.5 болж тус тус нэмэгддэг. Мөн 60 ба түүнээс дээш насанд нийслэл хотод хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.7 дахин их цагийг зарцуулдаг бол аймгийн төвд 1.4, сумын төвд 1.9, хөдөөд нийслэл хотоос арай бага буюу 1.6 дахин их цагийг зарцуулж байна.

Хөлсгүй хөдөлмөрийн тухайд бүх насны бүлэгт, нийслэл хот болон аймгийн төвтэй харьцуулахад сумын төв, хөдөөд хүйсийн ялгаа өндөр буюу эмэгтэйчүүд илүү цаг зарцуулж байна. 12-17 болон 40 ба түүнээс дээш насанд байршил хоорондын энэ ялгаа илүү гүнзгийрчээ. 12-17 насанд охид хөвгүүдтэй харьцуулахад нийслэл хотод 1.3 дахин их цагийг зарцуулдаг бол төвөөс алсрах тусам энэ ялгаа гүнзгийрч, аймгийн төвд 1.4, сумын төвд 1.8, хөдөөд 2.1 дахин их цагийг зарцуулдаг. 40-59 насанд нийслэл болон аймгийн төвд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.8 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг бол сумын төв, хөдөөд 2.0 ба 2.3 дахин их цагийг тус тус хөлсгүй хөдөлмөрт зориулж байна. 60 ба түүнээс дээш насанд нийслэл, аймгийн төвд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.5-1.6 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг бол сумын төв, хөдөөд энэ ялгаа гүнзгийрч 2.0 дахин их цагийг зарцуулдаг. Харин 18-39 насанд аль ч байршилд хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн харьцаа ойролцоо түвшинд, өндөр байдаг. Энэ насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад суурьшлын байршлуудад 2.2-2.6 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт хүйсийн ялгаа хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд илэрснээс бага бөгөөд нийслэл, аймгийн төв, сумын төвд эрэгтэйчүүд бага зэрэг илүү цагийг, хөдөөд эмэгтэйчүүд бага зэрэг илүү цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулжээ.

Хүн амын цаг ашиглалтын ялгааг бүсээр авч үзвэл хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг 12-24 болон 60 ба түүнээс дээш насанд Улаанбаатар хотод хамгийн бага бусад бүсүүдэд, тэр дундаа Баруун болон Зүүн бүсэд өндөр байна.

Харин 25-59 насанд Зүүн бүс болон Улаанбаатар хотод хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг бусад бүстэй харьцуулахад өндөр. Бүсүүдийн насны бүлгээрх ялгааны энэ зүй тогтол өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт тусгалаа олж, 12-24 болон 60 ба түүнээс дээш насанд Улаанбаатар хотод амьдардаг хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг бусад бүсээс өндөр бол 25-59 насанд энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг бүсүүдэд ойролцоо байна.

Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа нь бүсүүдэд насны бүлэг бүрээр ялгаатай буюу ямар нэг нэгдсэн зүй тогтол ажиглагдахгүй байна. 12-17 насанд хөлстэй болон хөлсгүй аль аль төрлийн хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа Улаанбаатар хотод хамгийн бага, хөлстэй хөдөлмөрийн хувьд Төвийн бүсэд, хөлсгүй хөдөлмөрийн хувьд Хангайн болон Зүүн бүсэд илүү өндөр. 18-24 насанд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн ялгаа Улаанбаатар хот болон Баруун бүсэд бага, Хангайн бүсэд өндөр байна. 25-59 насанд хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цагийн хүйсийн ялгаа бүсүүдэд харьцангуй тогтворжих ба хөлсгүй хөдөлмөрийн хувьд Хангайн бүсэд арай өндөр байна. 60 ба түүнээс дээш насанд Улаанбаатар хотод хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн ялгаа хамгийн бага бол хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа Баруун, Зүүн бүс болон Улаанбаатар хотод бага байна.


Дүрслэл 47. Цаг ашиглалт, насны бүлгээр, суурьшлаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


12-17 НАС

18-24 НАС


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа






Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа














 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

25-39 НАС

40-59 НАС

60+ НАС




Дүрслэл 48. Цаг ашиглалт, насны бүлгээр, бүсээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


12-17 НАС

18-24 НАС


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа






Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа









































 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

25-39 НАС

40-59 НАС

60+ НАС



4.4.

ЦАГ АШИГЛАЛТ БА ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛ

Дэлхий нийтийн Тогтвортой хөгжлийн зорилгын тулгуур нь хүний эрхийг хангах буюу “хэнийг ч хөгжлийн ард үлдээхгүй байх” зарчимд суурилдаг. Үүнтэй уялдан аливаа хүн амын өгөгдлийг бүрдүүлэхдээ хүний эрхийн зарчимд тулгуурлан олон янзын төлөөллийг тусгасан нарийн задаргаагаар гаргах тухай онцгойлон анхаарах болсон. Энэ үүднээс цаг ашиглалтын судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг нарийвчлан судалдаг.

Судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг үнэлэхдээ үйлдлийн чадварын хүндрэлийн зэргээр тодорхойлсон. Үүнд харах, сонсох, алхах, анхаарлаа төвлөрүүлэх, бие даан өөрийгөө арчлах, ярих зэрэг үйлдэл хийхэд хэр хүндрэлтэйг 1-4 зэргээр үнэлж, хүндрэлийн зэрэг бага буюу 1 ба 2-р зэрэг бол үйлдлийн чадварын хүндрэлгүй, 3 ба 4-р зэрэг бол үйлдлийн чадварын хүндрэлтэй гэж үзсэн.

Дүрслэл 49. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




— 1 минут

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдрийн 24 цагийн дунджаар 6.4 хувийг хөлстэй хөдөлмөрт, 13.8 хувийг хөлсгүй хөдөлмөр эрхлэхэд, 19.6 хувийг боловсрол, чөлөөт цагт, 60.2 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээнд зарцуулж байна. Харин үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн ам өдрийн 24 цагийн 20.1 хувийг хөлстэй хөдөлмөрт, 14.7 хувийг хөлсгүй хөдөлмөрт, 14.8 хувийг боловсрол, чөлөөт цагт, 50.3 хувийг зайлшгүй хувийн хэрэгцээндээ зориулж байна.

Үйлдлийн чадварын хүндрэл нь хөлстэй хөдөлмөр эрхлэх цагийг хязгаарлаж буй ч хөлсгүй хөдөлмөрийн хувьд огтхон ч хязгаарлалт болдоггүй нь харагдаж байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 19 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад ердөө 13 минутаар бага байна. Харин хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 3.1 дахин бага, эсрэгээрээ чөлөөт цаг нь 1.6 дахин их байна.

Дүрслэл 50. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



| — 1 минут

Дүрслэл 51. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

3

35

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

24

24

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

255

154

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 2
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 11
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 11
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 182
- Бусад 49

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх 2
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа 13
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа 9
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах 113
- Бусад 17

3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

865

724

- Унтах, амрах, босох 683
- Хооллох, цай уух 87
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 65
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 13
- Бусад 17

- Унтах, амрах, босох 563
- Хооллох, цай уух 86
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих 44
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах 5
- Бусад 26

ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛГҮЙ ХҮН АМТАЙ АДИЛ ЦАГИЙГ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛДАГ.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэлтийн бүхий л төрөлд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад бага цаг зарцуулдаг. ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 3.5 дахин бага цагийг, өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 2.5 дахин бага цагийг зарцуулж байна.

Харин хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай ойролцоо буюу долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 19 минут зарцуулж байна. Энэ үйл ажиллагаанд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн ам 13 минутаар илүү буюу 3 цаг 32 минут зарцуулж буй юм. Хөлсгүй хөдөлмөрийн төрлөөр авч үзвэл гэр цэвэрлэхэд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн үйлдлийн чадварын хүндрэлгүй хүнээс 9 минут илүү, хоол хүнс бэлтгэхэд ижил, хувцас, гутал угаах, арчлахад 6 минутаар бага цаг зарцуулдаг.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ам хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж хомс байгаагийн адил боловсролын үйл ажиллагаанд харьцангуй бага цаг зарцуулж байна. Үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн өдөрт дунджаар 35 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж байхад үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн ердөө 3 минутыг зарцуулжээ.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх цаг хязгаарлагдмал тул өөрийгөө хөгжүүлэх, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг их. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаанд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын зарцуулах цаг өдөрт дунджаар 2 цаг 34 минут бол үйлдлийн чадварын хүндрэлтэй хүний хувьд 1 цаг 41 минут илүү буюу 4 цаг 15 минутыг зарцуулж байна. Гэхдээ үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд энэхүү чөлөөт цагаа спорт, хобби, соёлын үйл ажиллагаа гэх мэт олон янзын үйл ажиллагаанд зарцуулахаас илүү олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад түлхүү хуваарилах хандлагатай.

ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫН АЖЛЫН БОЛОН АМРАЛТЫН ӨДРИЙН ЦАГ АШИГЛАЛТ ХАРЬЦАНГУЙ ТОГТМОЛ.

Үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын ажлын болон амралтын өдөр ялгаа багатай өнгөрдөг. Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүний хөлстэй хөдөлмөр эрхлэлт амралтын өдөр ажлын өдрөөс 8.3 хувь (8 минут)-иар буурдаг бол үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амынх 20.0 хувь (1 цаг 1 минут)-иар буурч байна. Хөлсгүй хөдөлмөрийн хувьд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүний хөлсгүй хөдөлмөр эрхлэлт амралтын өдөр ажлын өдрөөс 3.5 хувь (7 минут)-иар нэмэгддэг бол үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амынх 18.8 хувь (38 минут)-иар нэмэгддэг аж.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг үйлдлийн чадварын хүндрэлтэй хүний хувьд ажлын болон амралтын өдөр мөн ялгаа багатай буюу энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг амралтын өдөр ажлын өдрөөс 0.1 хувь (1 минут)-иар нэмэгддэг бол үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амынх 2.5 хувь (25 минут)-иар нэмэгджээ.

Дүрслэл 52. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, ажлын болон амралтын өдрөөр

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ			ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛГҮЙ		
	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	96	88	▼	305	244	▼
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	62	58	▼	227	149	▼
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	43	41	▼	162	96	▼
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	4	3	▼	10	13	▲
- Ажилдаа явах, зорчих	10	5	▼	31	20	▼
- Бусад	5	9	▲	24	20	▼
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	34	30	▼	78	95	▲
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	19	19	-	53	65	▲
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	6	6	-	10	13	▲
- Бусад	9	5	▼	15	17	▲
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	198	205	▲	202	240	▲
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	149	168	▲	145	184	▲
- Хоол хүнс бэлтгэх	62	62	-	60	67	▲
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	58	63	▲	48	56	▲
- Хувцас, гутал угаах, арчлах	7	13	▲	11	27	▲
- Бусад	22	30	▲	26	34	▲
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	43	22	▼	51	48	▼
- Хүүхэд асрах	31	20	▼	42	42	-
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	5	2	▼	2	2	-
- Бусад	7	0	▼	7	4	▼
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	15	▲	6	8	▲
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,146	1,147	▲	933	956	▲
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	0	▼	41	15	▼
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	21	32	▲	22	32	▲
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	255	254	▼	148	173	▲
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	1	▼	1	5	▲
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	11	12	▲	12	17	▲
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	11	10	▼	9	10	▲
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	183	179	▼	109	124	▲
- Бусад	48	52	▲	17	17	-
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	867	860	▼	720	736	▲
- Унтах, амрах, босох	690	663	▼	559	575	▲
- Хооллох, цай уух	86	89	▲	85	88	▲
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	59	81	▲	44	43	▼
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	16	6	▼	5	3	▼
- Бусад	16	21	▲	27	27	-

▲ Өссөн ▼ Буурсан - Өөрчлөгдөөгүй

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН
ХУНДРЭЛТЭЙ



ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН
ХУНДРЭЛГҮЙ



ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ДҮРСЛЭЛ 53.
ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

Дүрслэл 54. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ		ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛГҮЙ	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	159	54	355	235
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	103	35	243	178
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	71	26	164	129
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	9	0	17	6
- Ажилдаа явах, зорчих	12	6	33	24
- Бусад	11	3	29	19
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	56	19	112	57
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	38	8	82	33
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	10	4	13	9
- Бусад	8	7	17	15
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	160	223	133	279
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	109	180	99	204
- Хоол хүнс бэлтгэх	39	75	30	88
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	42	69	29	68
- Хувцас, гутал угаах, арчлах	2	13	5	25
- Бусад	26	23	35	23
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	35	39	28	68
- Хүүхэд асрах	27	29	22	59
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	3	5	1	2
- Бусад	5	5	5	7
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	16	4	6	7
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,121	1,163	952	926
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	4	2	33	36
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	27	23	24	24
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	262	250	172	139
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	0	2	2	3
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	11	11	17	10
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	13	9	9	9
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	200	171	126	101
- Бусад	38	57	18	16
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	828	886	721	726
- Унтах, амрах, босох	660	696	555	570
- Хооллох, цай уух	91	84	90	82
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	49	73	42	45
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	11	15	4	6
- Бусад	17	18	30	23

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй
 0 - хүйсийн ялгаа байхгүй
 1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГАА ӨНДӨР.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй болон хүндрэлгүй хүн амын дундах цаг ашиглалтын хүйсийн ялгааны хандлага ерөнхийдөө ижил. Хөлстэй хөдөлмөрт үйлдлийн чадварын хүндрэлтэй болон хүндрэлгүй хүн амын аль алиных нь хувьд эрэгтэйчүүд илүү цаг зарцуулах, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хандлага хэвээр. Гэхдээ хүйсийн харьцааг харвал хэмжээний хувьд ялгаатай.



Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг ашиглалтын хувьд үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын дундах хүйсийн ялгаа нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амынхаас өндөр байна. Үүний цаана үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээсээ илүү цагийг хөлстэй хөдөлмөр эрхлэхэд зарцуулах боломжтой байдаг нь харагдаж байна. Үйлдлийн чадварын хүндрэлтэй эрэгтэйчүүд үйлдлийн чадварын хүндрэлтэй эмэгтэйчүүдээс 2.9 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд 1.5 дахин их цагийг зарцуулдаг.

Хөлсгүй хөдөлмөрийн хувьд хүйсийн ялгаа арай бага буюу үйлдлийн чадварын хүндрэлтэй эмэгтэй хүн эрэгтэй хүнээс 1.4 дахин их цагийг зарцуулдаг бол үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа өндөр буюу эмэгтэйчүүд 2.1 дахин их цагийг зарцуулж байна.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээсээ арай илүү цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт зориулж байхад үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд эсрэгээрээ байдаг.

Дүрслэл 55. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, суурьшлаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 56. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, бүсээр, хүйсээр


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

— Нийт
— Эрэгтэй
— Эмэгтэй


ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ

ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛГҮЙ


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



НИЙСЛЭЛ ХОТОД АМЬДАРДАГ ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ИЛҮҮ ХЯЗГААРЛАГДМАЛ.

Үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр эрхлэлт нь үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад хязгаарлагдмал бөгөөд суурьшлын альч байршилд энэ хандлага ажиглагдана. Гэхдээ нийслэл хотод ялгаа илүү өндөр буюу төвөөс алслагдах тусам үйлдлийн чадварын хүндрэлтэй болон үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагийн ялгаа бага багаар буурч байна. Нийслэлд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн ам үйлдлийн чадварын хүндрэлтэй хүнээс 3 цаг 30 минутаар илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол аймгийн төвд 2 цаг 48 минутыг, сумын төвд 2 цаг 36 минутыг, хөдөөд 1 цаг 55 минутыг илүү зарцуулж байна.


Дүрслэл 57. Цаг ашиглалт, үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхээр, насны бүлгээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


12-17 НАС

18-24 НАС


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГАА 25 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСАНД ҮЙЛДЛИЙН ЧАДВАРЫН ХҮНДРЭЛТЭЙ ХҮН АМЫНХААС ӨНДӨР БАЙНА.












Үйлдлийн чадварын хүндрэлтэй болон хүндрэлгүй хүн амын цаг ашиглалтын хэв маяг нь хөдөлмөрийн идэвхтэй насанд илүү их ялгаатай буюу 18-59 насанд хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагт хамгийн их ялгаа илрэх бөгөөд үүнийг дагаад өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулах цагт мөн ялгаа өндөр байна.

Насны бүлэг дэх цаг ашиглалтын хүйсийн ялгааг авч үзвэл үйлдлийн чадварын хүндрэлтэй эсэхийг харгалзахгүйгээр хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулах ба үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад 25 ба түүнээс дээш насанд энэ үйл ажиллагаан дахь хүйсийн ялгаа өндөр байна.

25-39 НАС

40-59 НАС

60+ НАС



Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

Хөлсгүй хөдөлмөрт мөн аль ч тохиолдолд эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах боловч үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд 25 ба түүнээс дээш насанд үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амтай харьцуулахад хүйсийн ялгаа буурсан байна.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт үйлдлийн чадварын хүндрэлтэй хүн амын хувьд 12-39 насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулдаг бол 40 ба түүнээс дээш насанд эсрэгээрээ байна. Үйлдлийн чадварын хүндрэлгүй хүн амын хувьд аль ч насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цагийг уг үйл ажиллагаанд зарцуулж байна.

4.5.

ЦАГ АШИГЛАЛТ БА БОЛОВСРОЛ

Хүн амын цаг ашиглалтын хэв маягт боловсролын түвшин ихээхэн нөлөөлдөг. Боловсролын түвшин өндөр байх тусам хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нэмэгдэж, хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг буурах байдлаар амьдралын хэмнэл өөрчлөгдөнө.

Гэхдээ боловсрол үргэлж хөдөлмөрийн зах зээл дэх идэвхтэй оролцооны баталгаа болдог уу? Боловсролын түвшин нь хүн амын нас, хүйс, амьдарч буй байршил зэрэг үзүүлэлтүүдтэй уялдсанаар боловсролын түвшнээс хамаарсан цаг ашиглалтын төлөвт хэр зэрэг ялгаа үүсдэг вэ?

Дүрслэл 58. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023





Хөдөлмөр эрхлэлтийн статус хөлстэй хэлбэрт шилжих нь боловсролын түвшинтэй нягт уялдаатай байна. Дээд боловсролтой хүн амтай харьцуулахад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн өдөрт дунджаар 6.2 хувиар бага цагийг, бүрэн дунд боловсролтой хүн 9.4 хувиар бага цагийг, суурь боловсролтой хүн 28.0, боловсролгүй, бага боловсролтой хүн 26.4 хувиар бага цагийг тус тус хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.

Дүрслэл 59. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, боловсролын түвшнээр


Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


















БҮРЭН ДУНД



ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН




ДЭЭД



Дүрслэл 60. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, боловсролын түвшнээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1 Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

82

83

3.2 Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

21


20

3.3 Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

167

175

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад





3.4 Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

776

747

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад








24

23

159




732





4

23

168




733




9

29

156



720



БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ӨНДӨР БАЙХ ТУСАМ ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛҮҮ ИХ ЦАГ ЗАРЦУУЛНА.

Боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж буй хандлагыг нарийвчлан авч үзье. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа нь ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлт болон өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааны бүрдэл. Үүнээс боловсролын түвшин нэмэгдэхэд ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг тэлэх бол боловсролын түвшин буурах тусам өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд оролцох оролцоо нэмэгдэж байна. Дээд боловсролтой хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан нийт цагийн 92.5 хувь нь ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд, 7.2 хувь (22 минут) нь өрхийн эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдаж байхад боловсролгүй, бага боловсролтой хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан нийт цагийн 31.0 хувь нь ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд, 69.0 хувь (2 цаг 36 минут) нь өрхийн эцсийн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагджээ.

Боловсролын түвшин өндөр бөгөөд хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг их байх нь хөлсгүй хөдөлмөрт бага цаг зарцуулах шалтгаан болдоггүй.

Суурь боловсролоос эхлээд дээд боловсролтой хүн ам боловсролын түвшин үл харгалзан хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 3 цаг гаруй хугацаа (3 цаг 14-44 минут)-г зарцуулж байна. Харин боловсролгүй, бага боловсролтой хүн арай бага буюу өдөрт дунджаар 2 цаг 48 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулжээ.

Боловсролын түвшин буурах тусам хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг буурах тул нөгөө талд хувийн хэрэгцээ болон чөлөөт цагт илүү цаг гарч байна. Эсрэгээрээ боловсролын түвшин ахих тусам хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нэмэгдсэнээр боловсролтой хүн амын хувийн хэрэгцээндээ зарцуулах цаг буурдаг. Дээд боловсролтой хүн өдөрт дунджаар 15 цаг 14 минутыг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зарцуулдаг бол техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн үүнээс 14 минутаар илүү цагийг, бүрэн дунд боловсролтой хүн 25 минутаар илүү цагийг, суурь боловсролтой хүн 1 цаг 51 минут, боловсролгүй, бага боловсролтой хүн 2 цаг 12 минутаар илүү цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зориулж байна.

Боловсролгүй, бага боловсролтой хүн дээд боловсролтой хүн амтай харьцуулахад илүү их цагийг хобби, чөлөөт цагтаа зориулдаг. Харин дээд боловсролтой хүн бага боловсролтой хүнээс арай илүү цагийг хүмүүстэй харилцах болон спортоор хичээллэхэд хуваарилж байна. Мөн боловсролын түвшин бага байх тусам боловсролд илүү цаг зарцуулах хандлагатай. Энд цаг ашиглалтын тооцоонд 12-18 насны сурагчид багтаж буйг анхаарах нь зүйтэй. Тухайлбал ЕБС-ийн 12 дугаар анги хүртэл түвшинд суралцаж буй хүүхдүүд боловсролгүй, бага, суурь боловсролтой ангилалд хамаарах бөгөөд дээрх насны хүүхдүүд бусад насны хүн амтай харьцуулахад боловсролын үйл ажиллагаанд хамгийн их цаг зарцуулдаг нь судалгааны үр дүнд нөлөөлж буй юм. Боловсролын түвшин нэмэгдэх тусам боловсролд цаг зарцуулах шаардлага буурч хөдөлмөр эрхлэлтэд илүү их цаг зарцуулж байна.

ДЭЭД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ, ЭСВЭЛ ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ НЬ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГТ ХЭР ЯЛГААТАЙ НӨЛӨӨЛӨХ ВЭ?

Боловсролын түвшин харьцангуй өндөр буюу тодорхой мэргэжил эзэмшсэн хүн ам болох дээд боловсролтой, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хооронд цаг ашиглалтын ялгаа бий эсэх нь сонирхол татаж байна.

Аль аль нь хөлстэй хөдөлмөрт бүрэн дунд боловсролтой хүн амтай харьцуулахад илүү цаг зарцуулах боловч дээд боловсролтой хүн техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амтай харьцуулахад өдөрт дунджаар 19 минут буюу 6.6 хувиар их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулжээ. Түүнчлэн техникийн болон мэргэжлийн боловсролтой бол хөлстэй хөдөлмөр дотроо өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо нь дээд хүн боловсролтой хүн амаас их байна. Техникийн болон мэргэжлийн боловсролтой хүний хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан нийт цагийн 19.1 хувь нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагддаг бол дээд боловсролтой хүний хувьд энэ үзүүлэлт 7.2 хувь байна. Техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 53 минутыг ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд зарцуулдаг бол дээд боловсролтой хүн ам энэ үйл ажиллагаанд 4 цаг 44 минутыг зарцуулдаг.

Хөлсгүй хөдөлмөрийн тухайд дээд боловсролтой хүн техникийн болон мэргэжлийн боловсролтой хүнээс ялимгүй бага цагийг зарцуулжээ. Техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 44 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байхад дээд боловсролтой хүн үүнээс 5 минутаар бага цагийг зарцуулсан байна. Эдгээр хүн амын гэрийн ажилд оролцох оролцоо ойролцоо бол хүүхэд асрахад дээд боловсролтой хүн техникийн болон мэргэжлийн боловсролтой хүнээс 50.0 хувиар илүү цаг зарцуулжээ.

Дээд боловсролтой хүн боловсролын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 9 минут зарцуулдаг бол техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн арай бага буюу 4 минутыг зарцуулж байна. Мөн хүмүүстэй харилцахад дээд боловсролтой хүн арай илүү буюу өдөрт дунджаар 29 минут зарцуулж байхад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн 23 минут зарцуулжээ.

Техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн дээд боловсролтой хүнтэй харьцуулахад чөлөөт цагтаа өдөрт дунджаар 12 минутаар илүү цагийг зориулах ба энэ нь ихэвчлэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад хуваарилагдаж байна. Дээд боловсролтой хүн спортоор хичээллэх, соёлын болон спортын арга хэмжээнд оролцоход арай илүү цаг зарцуулж байна. Унтах, амрахад техникийн болон мэргэжлийн боловсролтой, дээд боловсролтой хүн ойролцоо цаг зарцуулдаг бол хооллох, хувийн ариун цэвэр сахихад техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн арай илүү цаг зарцуулжээ.

Цаг ашиглалтын хувьд дээд боловсролтой бол техникийн болон мэргэжлийн боловсролтой хүнтэй харьцуулахад ААНБ-д ажиллах хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулж, хөлсгүй хөдөлмөр болон хувийн хэрэгцээний цагтаа арай бага цаг хуваарилах буюу боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд илүү цаг зарцуулах хандлагыг баталж байна.

Дүрслэл 61. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр, ажлын болон амралтын өдрөөр

12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

БОЛОВСРОЛГҮЙ, БАГА БОЛОВСРОЛТОЙ

СУУРЬ

	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	218	249	▲	221	219	▼
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	69	74	▲	80	68	▼
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	24	31	▲	40	22	▼
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	31	32	▲	18	30	▲
- Ажилдаа явах, зорчих	5	4	▼	8	6	▼
- Бусад	8	7	▼	14	11	▼
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	149	175	▲	141	151	▲
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	106	128	▲	103	111	▲
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	19	23	▲	17	21	▲
- Бусад	24	24	-	21	18	▼
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	165	174	▲	187	217	▲
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	132	146	▲	152	175	▲
- Хоол хүнс бэлтгэх	47	52	▲	59	63	▲
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	46	53	▲	51	50	▼
- Хувцас, гутал угаах, арчлах	10	15	▲	11	19	▲
- Бусад	30	25	▼	30	42	▲
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	27	21	▼	29	33	▲
- Хүүхэд асрах	23	19	▼	24	30	▲
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	0	▼	1	1	-
- Бусад	3	2	▼	5	1	▼
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	7	▲	6	9	▲
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,057	1,017	▼	1,032	1,004	▼
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	99	36	▼	99	37	▼
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	21	20	▼	18	23	▲
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	162	182	▲	169	194	▲
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	2	▲	3	8	▲
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	20	26	▲	21	24	▲
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	6	9	▲	8	9	▲
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	115	120	▲	125	136	▲
- Бусад	20	25	▲	12	17	▲
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	774	779	▲	746	749	▲
- Унтах, амрах, босох	612	603	▼	585	595	▲
- Хооллох, цай уух	96	103	▲	85	89	▲
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	47	51	▲	49	42	▼
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	3	2	▼	5	1	▼
- Бусад	16	20	▲	22	22	-

▲ Өссөн ▼ Буурсан - Өөрчлөгдөөгүй

БҮРЭН ДУНД			ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН			ДЭЭД		
Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
289	244	▼	300	251	▼	337	213	▼
202	145	▼	250	179	▼	317	185	▼
147	95	▼	176	131	▼	237	131	▼
8	9	▲	8	5	▼	2	2	-
26	18	▼	32	15	▼	48	31	▼
22	23	▲	34	28	▼	30	21	▼
87	99	▲	50	71	▲	21	28	▲
58	69	▲	31	46	▲	10	12	▲
12	12	-	9	14	▲	3	5	▲
17	19	▲	9	11	▲	7	11	▲
216	245	▲	216	249	▲	206	260	▲
160	192	▲	155	195	▲	135	190	▲
63	70	▲	62	67	▲	61	70	▲
57	62	▲	50	67	▲	41	55	▲
12	31	▲	11	18	▲	11	31	▲
27	30	▲	32	43	▲	21	35	▲
50	45	▼	51	46	▼	66	61	▼
42	38	▼	35	37	▲	54	54	-
2	3	▲	5	6	▲	2	1	▼
6	3	▼	11	3	▼	9	5	▼
7	8	▲	10	8	▼	6	8	▲
935	951	▲	924	940	▲	897	967	▲
30	8	▼	5	1	▼	11	4	▼
21	31	▲	22	28	▲	24	42	▲
153	175	▲	165	177	▲	149	177	▲
1	2	▲	1	2	▲	2	6	▲
9	16	▲	8	8	-	8	13	▲
9	10	▲	6	8	▲	11	12	▲
111	128	▲	134	143	▲	110	127	▲
23	19	▼	16	16	-	18	19	▲
731	736	▲	732	735	▲	712	744	▲
571	575	▲	553	565	▲	549	580	▲
83	86	▲	88	84	▼	82	84	▲
42	46	▲	53	60	▲	46	42	▼
6	3	▼	9	4	▼	7	5	▼
29	26	▼	29	22	▼	28	33	▲

ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ХҮН АМЫН ХУВЬД АЖЛЫН БОЛОН АМРАЛТЫН ӨДӨР ИЛҮҮ ЯЛГААТАЙ ӨНГӨРДӨГ.

Ажлын өдөр ба амралтын өдөр хоорондын цаг ашиглалтын ялгаа нь ихэвчлэн хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулдаг хүн амын хувьд ажиглагдах ба хүн амын боловсролын түвшин нэмэгдэх тусам ажлын өдөр хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдэж, эсрэгээрээ амралтын өдөр хөлстэй хөдөлмөрөө бууруулан хөлсгүй хөдөлмөр, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ илүү цагийг төлөвлөх хандлагатай.

Боловсролгүй, бага боловсролтой хүн амын хувьд ажлын өдөр, амралтын өдрийн ялгаа харьцангуй бага бөгөөд амралтын өдөр хөлстэй хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, хөлсгүй хөдөлмөр эрхлэлт болон өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг нь буурах байдлаар илүү түвшний боловсролтой хүнтэй харьцуулахад эсрэгээр өөрчлөгдөж байна.

Түүнчлэн хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаануудыг задалж харвал ААНБ-д ажиллах гэх мэт хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг боловсролын түвшинтэй шууд хамааралтай байхад өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах цаг урвуу хамааралтай ба энэ нь ажлын болон амралтын өдөр ялгаагүй байна.

ДҮРСЛЭЛ 62.

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны
хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

ЭРЭГТЭЙ

ЭМЭГТЭЙ

БОЛОВСРОЛГҮЙ, БАГА
БОЛОВСРОЛТОЙ



СУУРЬ



БҮРЭН
ДУНД



| — 1 минут

ТЕХНИКИЙН
БОЛОН
МЭРГЭЖЛИЙН



ДЭЭД



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН НЭМЭГДЭХ ТУСАМ ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ДЭХ ХҮЙСИЙН ЯЛГАА БУУРДАГ.

Боловсролын түвшнээс үл хамааран хөдөлмөрийн хуваарьт хөлстэй хөдөлмөрийг эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрийг эмэгтэйчүүд голчлон гүйцэтгэх хандлага хэвээр.

Гэхдээ эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэхэд тэдний хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэж, хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа арилахгүй ч буурч байна.

Боловсролгүй, бага боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 2.3 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад суурь, бүрэн дунд боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд нь эмэгтэйчүүдээс 1.6 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хувьд энэ ялгаа 1.9, дээд боловсролтой хүн амын дунд тус ялгаа 1.4 байна.

Боловсролгүй, бага боловсролтой хүн амын хувьд өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо давамгайлсан хөлстэй хөдөлмөрт харьцангуй их цаг зарцуулах ба хүйсийн ялгаа их буюу энэ үйл ажиллагаанд эрэгтэйчүүд илүү цаг гаргадаг. Гэхдээ боловсролын түвшин ахих тусам эрэгтэйчүүдийн энэ үйл ажиллагаанд зарцуулах цаг хумигдаж, үр дүнд нь хүйсийн ялгаа буурч байна. ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтэд боловсролгүй, бага боловсролтой эрэгтэйчүүд өдөрт дунджаар 1 цаг 38 минут зарцуулдаг бол ижил түвшний боловсролтой эмэгтэйчүүд үүнээс 2.5 дахин бага буюу 39 минут зарцуулж байна. Харин дээд боловсролтой хүн амын дунд эрэгтэйчүүд хөдөлмөр эрхлэлтэд 5 цаг 51 минут зарцуулж байхад эмэгтэйчүүд үүнээс 1.4 дахин бага буюу өдөрт дунджаар 4 цаг 4 минут зарцуулжээ.

Харин хөлсгүй хөдөлмөрийн тухайд боловсролын түвшин нэмэгдсэн ч эмэгтэйчүүдийн оролцоо дагаж нэмэгдэх байдлаар хүйсийн ялгаа илүү гүнзгийрч байна.

Боловсролгүй, бага боловсролтой эмэгтэйчүүд ижил түвшний боловсролтой эрэгтэйчүүдээс 1.8 дахин их цагийг, суурь боловсролтой бол 1.9 дахин их цагийг, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой бол 2.0 дахин их цагийг, дээд боловсролтой бол 2.1 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр дэх ачаалал бүх төрлийн гэрийн ажил болон хүүхэд асрах үйл ажиллагааны хувьд эрэгтэйчүүдээс илүү.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зориулах цагийн хүйсийн ялгаа нь суурь, бүрэн дунд боловсролтой хүн амын хувьд харьцангуй бага бол боловсролгүй, бага, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амын хувьд эмэгтэйчүүд давамгайлсан, дээд боловсролтой хүн амын хувьд эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа илэрч байна. Боловсролын түвшин бага байхад эмэгтэйчүүд хувийн хэрэгцээндээ их цаг зарцуулж байгаа нь тэдний хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг эрэгтэйчүүдийнхээс бага байгаатай холбоотой. Харин дээд боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь нэмэгдэхийн хажуугаар хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нь мөн нэмэгдэж, эрэгтэйчүүдтэй харьцуулахад бага цагийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зориулж байна.

Дүрслэл 63. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

БОЛОВСРОЛГҮЙ, БАГА БОЛОВСРОЛТОЙ

	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	311	134	0.40
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	98	39	0.43
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	34	17	0.33
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	46	15	0.51
- Ажилдаа явах, зорчих	7	3	0.40
- Бусад	11	5	0.38
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	213	94	0.39
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	164	54	0.50
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	22	19	0.07
- Бусад	27	22	0.10
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	220	-0.29
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	99	177	-0.28
- Хоол хүнс бэлтгэх	26	73	-0.47
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	32	66	-0.35
- Хувцас, гутал угаах, арчлах	4	19	-0.65
- Бусад	38	19	0.33
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	16	37	-0.40
- Хүүхэд асрах	11	33	-0.50
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	1	1	0.00
- Бусад	3	2	0.20
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	7	-0.08
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,009	1,086	-0.04
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	65	101	-0.22
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	17	24	-0.17
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	164	171	-0.02
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	1	0.00
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	26	17	0.21
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	7	6	0.08
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	112	122	-0.04
- Бусад	18	25	-0.16
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	763	790	-0.02
- Унтах, амрах, босох	594	627	-0.03
- Хооллох, цай уух	102	94	0.04
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	44	52	-0.08
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	1	4	-0.60
- Бусад	22	13	0.26

СУУРЬ			БҮРЭН ДУНД			ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН			ДЭЭД		
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
270	167	0.24	349	216	0.24	381	197	0.32	377	264	0.18
91	62	0.19	234	148	0.23	311	156	0.33	351	244	0.18
36	35	0.01	164	108	0.21	215	115	0.30	257	182	0.17
30	11	0.46	11	6	0.29	11	3	0.57	2	2	0.00
8	7	0.07	30	18	0.25	38	19	0.33	56	37	0.20
16	10	0.23	29	16	0.29	47	19	0.42	35	23	0.21
180	105	0.26	115	68	0.26	70	41	0.26	27	20	0.15
141	67	0.36	83	41	0.34	45	24	0.30	15	8	0.30
18	18	0.00	14	10	0.17	13	8	0.24	5	3	0.25
21	20	0.02	19	17	0.06	12	8	0.20	7	9	-0.13
138	256	-0.30	147	290	-0.33	147	299	-0.34	128	275	-0.36
113	206	-0.29	107	222	-0.35	108	220	-0.34	85	187	-0.38
32	91	-0.48	31	95	-0.51	35	91	-0.44	32	83	-0.44
32	72	-0.38	35	79	-0.39	33	76	-0.39	23	58	-0.43
4	23	-0.70	6	26	-0.63	3	22	-0.76	4	23	-0.70
45	21	0.36	34	22	0.21	37	31	0.09	26	23	0.06
17	44	-0.44	33	62	-0.31	32	68	-0.36	38	81	-0.36
14	37	-0.45	27	54	-0.33	18	53	-0.49	29	70	-0.41
1	2	-0.33	1	3	-0.50	5	5	0.00	1	2	-0.33
2	5	-0.43	5	6	-0.09	9	10	-0.05	7	9	-0.13
7	6	0.08	8	6	0.14	6	12	-0.33	5	7	-0.17
1,032	1,017	0.01	944	934	0.01	912	944	-0.02	935	901	0.02
71	95	-0.14	23	26	-0.06	5	2	0.43	11	9	0.10
21	18	0.08	23	24	-0.02	19	28	-0.19	33	26	0.12
191	158	0.09	173	146	0.08	181	156	0.07	181	141	0.12
2	6	-0.50	2	1	0.33	1	1	0.00	2	3	-0.20
28	15	0.30	13	9	0.18	10	5	0.33	11	8	0.16
10	6	0.25	9	10	-0.05	6	8	-0.14	12	10	0.09
139	116	0.09	128	104	0.10	147	126	0.08	135	101	0.14
12	15	-0.11	21	22	-0.02	17	16	0.03	21	19	0.05
748	745	0.00	725	738	-0.01	707	758	-0.03	711	725	-0.01
586	589	-0.00	558	585	-0.02	531	580	-0.04	545	564	-0.02
91	82	0.05	88	80	0.05	88	86	0.01	86	80	0.04
44	50	-0.06	42	44	-0.02	50	59	-0.08	41	47	-0.07
3	5	-0.25	4	7	-0.27	6	9	-0.20	5	7	-0.17
24	19	0.12	33	22	0.20	32	24	0.14	34	27	0.11

Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 64. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр, суурьшлаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

БОЛОВСРОЛГҮЙ, БАГА
БОЛОВСРОЛТОЙ

СУУРЬ


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа






Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа




























 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

БҮРЭН ДУНД

ТЕХНИКИЙН БОЛОН
МЭРГЭЖЛИЙН

ДЭЭД




Дүрслэл 65. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр, бүсээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

БОЛОВСРОЛГҮЙ, БАГА
БОЛОВСРОЛТОЙ

СУУРЬ


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа






Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа



Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа











 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

БҮРЭН ДУНД

ТЕХНИКИЙН БОЛОН
МЭРГЭЖЛИЙН

ДЭЭД



ТӨВӨӨС АЛСЛАГДАХ ТУСАМ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН ҮЛ ХАМААРАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ЗАРЦУУЛАХ ЦАГ НЭМЭГДДЭГ.

Аймгийн төвийг эс тооцвол төвөөс алсрах тусам хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг нэмэгдэх хандлага аль ч түвшний боловсролтой хүн амд ажиглагдаж байна. Боловсролын түвшин бага байх тусам нийслэл хоттой харьцуулахад сумын төв, хөдөөд хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг илүү буюу хөдөөд боловсролын түвшнээс үл хамаааран хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг ойролцоо болдог. Боловсролгүй, бага боловсролтой хүн нийслэл хотод өдөрт дунджаар 2 цаг 2 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад хөдөөд 5 цаг 51 минутыг зарцуулдаг буюу хөдөөд боловсролын түвшин бага байсан ч хөдөлмөр эрхлэх боломж илүү байдаг бололтой. Мөн дээд боловсролтой хүн нийслэл хотод амьдардаг бол хөлстэй хөдөлмөрт өдөрт дунджаар 5 цаг 17 минутыг зарцуулдаг бол хөдөөд 5 цаг 51 минутыг зарцуулдаг.

Харин аймгийн төвд дээд боловсролтой болон боловсролгүй, бага боловсролтой аль ч хүний хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг бусад байршилтай харьцуулахад бага байна.

Хүйсийн ялгааны хувьд боловсролын түвшин нэмэгдэх тусам суурьшлын аль ч байршилд хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа буурах буюу эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдэж байна. Нийслэлд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр байх тусам хөлстэй хөдөлмөрөөс гадна хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдэж, хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа өсдөг. Суурьшлын бусад байршлуудад хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн харьцаа мөн өндөр боловч боловсролын түвшинг дагах өөрчлөлт нь нийслэл хоттой харьцуулахад харьцангуй тогтвортой байна.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагт боловсролын түвшин болон суурьшлаас хамаарсан мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байна.

Бүсээр авч үзвэл боловсролгүй, бага, суурь боловсролтой хүн ам Улаанбаатар хотод илүү боловсролтой хүн амтай харьцуулахад хөлстэй хөдөлмөрт бага цагийг зарцуулдаг. Дээд боловсролтой бол Улаанбаатар хотод илүү их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулах боломжтой. Харин боловсролын түвшин бага хүн ам Улаанбаатар хотоос бусад бүсүүдэд хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулах боломжтой байна.

Хөлсгүй хөдөлмөрийн хувьд Баруун болон Зүүн бүсэд боловсролын түвшин хамаарахгүйгээр бусад бүстэй харьцуулахад хөлсгүй хөдөлмөрт илүү цагийг зарцуулж байна.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг суурьшил хооронд боловсролын түвшнээр төдийлөн ялгаагүй боловч боловсролгүй, бага боловсролтой хүн ам Улаанбаатар хот болон төвийн бүсэд амьдардаг бол илүү их цагийг энэ үйл ажиллагаанд зарцуулж байна.

Дүрслэл 66. Цаг ашиглалт, боловсролын түвшнээр, насны бүлгээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

12-17 НАС

	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
БОЛОВСРОЛГҮЙ, БАГА БОЛОВСРОЛТОЙ				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	63	90	39	0.40
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	108	84	130	-0.21
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,269	1,266	1,271	-0.00
СУУРЬ				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	77	102	54	0.31
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	116	83	147	-0.28
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,247	1,255	1,239	0.01
БҮРЭН ДУНД				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	65	90	36	0.43
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	130	121	141	-0.08
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,245	1,229	1,263	-0.01
ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	109	99	127	-0.12
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	73	107	10	0.83
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,258	1,234	1,303	-0.03
ДЭЭД				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	273	36	391	-0.83
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	134	106	147	-0.16
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,033	1,298	902	0.18

12 ба түүнээс дээш насны нийт хүн амын хувьд боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдэх хандлага илэрч байсан нь насны бүлэг бүрт ерөнхийдөө давтагдах боловч зарим онцлог ялгаа ажиглагдаж байна. 12-17 насанд дээд боловсрол эзэмшсэн, 18-24 болон 25-39 насанд техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн, 40 ба түүнээс дээш насанд боловсролгүй, бага боловсролтой хүн ам тухайн насны бусад түвшний боловсролтой хүн амаас тус тус илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Мөн 18-59 насанд боловсролгүй, бага боловсролтой хүн ам хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд харьцангуй их цаг зарцуулж байгаа нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тэр дундаа өрхийн хэрэглээнд зориулж мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд энэ түвшний боловсролтой хүн ам илүү их цаг зарцуулдагтай холбоотой.

18-24 насанд боловсролын түвшин нэмэгдэх тусам хөлстэй хөдөлмөр дэх эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа эрс буурч байна. Мөн 25 ба түүнээс дээш насанд дээд боловсролтой хүн амын дунд хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа боловсролгүй, бага боловсролтой, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амтай харьцуулахад хамгийн бага байна.

Нийт	18-24 НАС			25-39 НАС				40-59 НАС				60+ НАС			
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
258	327	79	0.61	362	429	247	0.27	371	431	264	0.24	136	223	92	0.42
173	63	459	-0.76	223	143	361	-0.43	191	130	299	-0.39	169	133	188	-0.17
1,009	1,050	902	0.08	855	868	832	0.02	878	879	877	0.00	1,135	1,084	1,160	-0.03
215	281	61	0.64	322	375	261	0.18	344	394	279	0.17	145	172	123	0.17
195	130	347	-0.45	256	170	353	-0.35	221	156	306	-0.32	224	161	274	-0.26
1,030	1,029	1,032	-0.00	862	895	826	0.04	875	890	855	0.02	1,071	1,107	1,043	0.03
260	324	203	0.23	347	432	257	0.25	333	401	275	0.19	104	144	77	0.30
185	113	249	-0.38	244	143	351	-0.42	225	153	286	-0.30	235	175	276	-0.22
995	1,003	988	0.01	849	865	832	0.02	882	886	879	0.00	1,101	1,121	1,087	0.02
349	401	289	0.16	384	487	266	0.29	354	448	248	0.29	107	148	79	0.30
176	112	248	-0.38	235	128	357	-0.47	213	145	291	-0.33	246	184	289	-0.22
915	927	903	0.01	821	825	817	0.00	873	847	901	-0.03	1,087	1,108	1,072	0.02
271	341	231	0.19	367	456	308	0.19	353	406	322	0.12	115	156	92	0.26
185	94	237	-0.43	229	120	302	-0.43	211	132	257	-0.32	220	149	259	-0.27
984	1,005	972	0.02	844	864	830	0.02	876	902	861	0.02	1,105	1,135	1,089	0.02

Хүйсийн харьцаа: -1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй
0 - хүйсийн ялгаа байхгүй
1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааны хувьд аль ч насны бүлэгт боловсролгүй, бага боловсролтой хүн ам дээд боловсролтой хүн амтай харьцуулахад бага цаг зарцуулжээ. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг 18-аас дээш насанд нэмэгдэж эхлэх ба 25 ба түүнээс дээш насанд харьцангуй өндөр түвшиндээ хадгалагдана. 25 ба түүнээс дээш насанд дээд боловсролтой хүн ам суурь, бүрэн дунд, техникийн болон мэргэжлийн боловсролтой хүн амтай харьцуулахад өдөрт дунджаар 6-27 минутаар бага цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.

Боловсролгүй, бага боловсролтой хүн амын дунд хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа өндөр байх хандлага 18-59 насанд илүү тод ажиглагдах ба 60 ба түүнээс насанд эсрэгээрээ дээд боловсролтой хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа өндөр байна.

4.6.

ЦАГ АШИГЛАЛТ БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хүн амыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь хөдөлмөр эрхэлдэг болон хөдөлмөр эрхэлдэггүй гэж хоёр ангилах боломжтой. Хөдөлмөр эрхэлдэг гэдэг нь цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн үг.¹⁰ Хөдөлмөр эрхлэлтийн статустай уялдсан цаг ашиглалтыг хэмжихдээ хөдөлмөрийн насны хүн ам буюу 15 ба түүнээс дээш насны хүн амын¹¹ хувьд тооцсон.

Хүн ам цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхээс гадна багагүй цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байдаг. Үүнтэй уялдан хөлсгүй хөдөлмөрийг хөлстэй хөдөлмөрт шилжүүлэх, хүн амын хөдөлмөрийн үнэлэмж, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэх тухай асуудлууд хөндөгдөн гардаг.

¹⁰ Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, YCX, 2019

¹¹ Заалт 15, 65, Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлын тогтоол-I

Дүрслэл 67. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Хөдөлмөр эрхэлдэг болон хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын цаг ашиглалтын ялгаа нь хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хамгийн тод илэрнэ. Хөдөлмөр эрхэлдэг хүн долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 42 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн өдөрт дунджаар 1 цаг 47 минутыг хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулж байна. Хөдөлмөр эрхэлдэггүй ч хөлстэй хөдөлмөрт цаг зарцуулж буй нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд

оролцох, богино хугацааны түр ажил хийх, ажил хайх зэрэгт цаг зарцуулсныг илэрхийлнэ.

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн хөлсгүй хөдөлмөрт илүү цаг зарцуулах буюу хөдөлмөр эрхэлдэг хүн өдөрт дунджаар 2 цаг 46 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн 4 цаг 30 минутыг зарцуулжээ. Түүнчлэн хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам боловсролын үйл ажиллагаанд болон чөлөөт цаг, хувийн хэрэгцээндээ хөдөлмөр эрхэлдэг хүн амаас илүү цаг зарцуулдаг.

Дүрслэл 68. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 69. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ БАЙХ НЬ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ДЭХ ОРОЛЦООГ ЗОГСООХГҮЙ.

Хөдөлмөр эрхэлдэг статустай 15 ба түүнээс дээш насны хүн ам хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөрт өдөрт дунджаар 10 цаг 28 минут буюу өдрийн сэрүүн байх цагийнхаа 68.1 хувийг зарцуулдаг бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам 46.0 хувь буюу 6 цаг 17 минутыг зарцуулдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүн хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулахаас гадна хөлсгүй хөдөлмөрт оролцсон хэвээр байна. Хөдөлмөр эрхэлдэг хүн хөдөлмөр эрхэлдэггүй хүн амаас 38.5 хувиар бага цагийг хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах хэдий ч хөлстэй хөдөлмөр эрхэлсэн цагийнхаа 35.9 хувьтай тэнцэхүйц цагийг хөлсгүй хөдөлмөрт зориулж буй нь бага биш хугацаа юм. Хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй хүн амын аль аль нь хөлсгүй хөдөлмөрийн бүхий л төрлийн үйл ажиллагаанд оролцдог.

Хөдөлмөр эрхэлдэг хүн хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд их цаг зарцуулах тул хөдөлмөр эрхэлдэггүй хүн амтай харьцуулахад чөлөөт цаг хомс. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн чөлөөт цагтаа өдөрт дунджаар 3 цаг 32 минутыг зарцуулж буй бол хөдөлмөр эрхэлдэг хүн үүнээс 2.0 дахин бага буюу 1 цаг 47 минутыг зарцуулж байна.

Хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд бага цаг зарцуулах тусам унтах, амрахад их цаг зарцуулах хандлагатай. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн хөдөлмөр эрхэлдэг хүнээс өдөрт дунджаар 1 цаг 43 минутаар илүү цагийг унтах, амрахад зарцуулсан байна. Үүнд хөдөлмөр эрхэлдэггүй статуст бүртгэгдсэн 15 ба түүнээс дээш насны хүн амын ихэнх нь амрахад илүү цаг зарцуулах хандлагатай залуу хүмүүс, эсвэл ахмад настан байх боломжтой гэдгийг сануулах нь зүйтэй. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн ам боловсролын үйл ажиллагаанд хөдөлмөр эрхэлдэг хүн амаас илүү цагийг зарцуулахаас гадна хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцоход илүү цаг зарцуулж байна.

ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ИХ ЦАГ ЗАРЦУУЛАХ ТУСАМ АЖЛЫН, АМРАЛТЫН ӨДРИЙН ЦАГ АШИГЛАЛТЫГ ЯЛГААТАЙ ТӨЛӨВЛӨДӨГ.

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амтай харьцуулахад хөдөлмөр эрхэлдэг хүн амын ажлын болон амралтын өдрийн цаг ашиглалт илүү ялгаатай. Хөдөлмөр эрхэлдэг хүн амралтын өдөр хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагаа бууруулж, хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг болон чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цагаа нэмэгдүүлэх бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн эсрэгээрээ чөлөөт цагаа бага зэрэг бууруулж, хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагаа нэмдэг. Хөдөлмөр эрхэлдэг хүн ам хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагаа амралтын өдөр ажлын өдрөөс 27.1 хувь (2 цаг 14 минут)-иар бууруулсан бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд эсрэгээрээ 13.5 хувь (14 минут)-иар нэмжээ. Харин хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагаа хөдөлмөр эрхэлдэг хүн амралтын өдөр ажлын өдрөөс 40.7 хувь (1 цаг 1 минут)-иар нэмэгдүүлсэн бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд бараг өөрчлөлтгүй буюу 1.1 хувь (4 минут)-иар нэмсэн байна.

Хөдөлмөр эрхэлдэг хүний өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг амралтын өдөр 9.0 хувь (1 цаг 12 минут)-иар нэмэгддэг бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд 1.6 хувь (17 минут)-иар буурдаг. Хөдөлмөр эрхэлдэг хүн амралтын өдөр төлөвлөсөн илүү цагаа унтах, амрах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах, спортоор хичээллэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулах байдлаар чөлөөт цагаа өнгөрүүлдэг.


Дүрслэл 70. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, ажлын болон амралтын өдрөөр

15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


	ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ			ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ		
	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	495	361	▼	104	118	▲
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	416	267	▼	29	29	-
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	308	184	▼	8	8	-
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	11	12	▲	9	13	▲
- Ажилдаа явах, зорчих	55	36	▼	6	3	▼
- Бусад	42	34	▼	6	6	-
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	79	95	▲	75	88	▲
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	57	68	▲	47	57	▲
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	9	11	▲	12	14	▲
- Бусад	13	15	▲	17	18	▲
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	150	211	▲	271	274	▲
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	113	172	▲	191	203	▲
- Хоол хүнс бэлтгэх	47	61	▲	78	76	▼
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	30	45	▲	72	70	▼
- Хувцас, гутал угаах, арчлах	8	27	▲	15	27	▲
- Бусад	28	39	▲	26	30	▲
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	33	33	-	71	60	▼
- Хүүхэд асрах	26	28	▲	59	53	▼
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	1	1	-	3	4	▲
- Бусад	6	4	▼	9	3	▼
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	4	6	▲	10	11	▲
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	796	868	▲	1,065	1,048	▼
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	5	3	▼	41	14	▼
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	17	29	▲	28	38	▲
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	100	131	▲	210	215	▲
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	5	▲	2	3	▲
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	7	10	▲	12	15	▲
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	5	7	▲	13	12	▼
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	76	97	▲	156	159	▲
- Бусад	11	13	▲	27	26	▼
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	674	705	▲	787	781	▼
- Унтах, амрах, босох	512	541	▲	621	616	▼
- Хооллох, цай уух	86	87	▲	85	90	▲
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	47	46	▼	44	46	▲
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	3	2	▼	9	5	▼
- Бусад	26	29	▲	27	25	▼

▲ Өссөн ▼ Буурсан - Өөрчлөгдөөгүй

Хөлстэй хөдөлмөр



Хөлсгүй хөдөлмөр




ХӨДӨЛМӨР
ЭРХЭЛДЭГ


ДҮРСЛЭЛ 71.
ХӨЛСТЭЙ БОЛОН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж
цаг ашиглалт, минутаар, 2023

Хөлстэй хөдөлмөр



Хөлсгүй хөдөлмөр



ХӨДӨЛМӨР
ЭРХЭЛДЭГГҮЙ

Дүрслэл 72. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ		ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	494	425	164	76
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	392	363	40	24
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	279	275	9	8
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	16	5	17	6
- Ажилдаа явах, зорчих	53	48	6	5
- Бусад	44	35	8	5
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	102	62	124	52
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	79	39	86	27
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	10	9	17	10
- Бусад	13	14	21	15
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	115	219	173	331
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	85	174	128	232
- Хоол хүнс бэлтгэх	24	79	43	98
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	19	49	48	85
- Хувцас, гутал угаах, арчлах	3	23	6	25
- Бусад	39	23	31	24
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	25	41	35	89
- Хүүхэд асрах	20	34	26	77
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	0	1	3	4
- Бусад	5	6	6	8
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	5	4	10	10
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	831	796	1,103	1,033
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	3	6	43	29
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	22	18	30	31
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	122	93	247	188
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	2	3	2	2
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	9	6	16	10
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	5	6	14	11
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	93	68	188	138
- Бусад	13	10	27	27
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	684	679	783	785
- Унтах, амрах, босох	515	523	615	621
- Хооллох, цай уух	92	81	91	83
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	45	49	40	47
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	2	4	7	9
- Бусад	30	22	30	25

Цаг ашиглалтын хүйсийн харьцаа



-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 - хүйсийн ялгаа байхгүй

1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ЭМЭГТЭЙЧҮҮД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХИЙН ХАЖУУГААР ЭРЭГТЭЙЧҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 1.9 ДАХИН ИХ ЦАГИЙГ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хөдөлмөр эрхэлдэг, эсвэл хөдөлмөр эрхэлдэггүй гэх ижил статустай байхад хөлстэй, хөлсгүй хөдөлмөр дэх оролцоо нь хэр ялгаатай байна вэ?

Хөдөлмөр эрхэлдэг статустай эрэгтэй, эмэгтэй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд илүү цаг зарцуулах, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах төлөв ажиглагдсан хэвээр байна. Хөдөлмөр эрхэлдэг 15 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 5 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд үүнээс 1.2 дахин их (1 цаг 9 минутаар их) буюу 8 цаг 14 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Харин хөлсгүй хөдөлмөрийн хувьд хөдөлмөр эрхэлдэг эрэгтэй хүн хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 1 цаг 55 минутыг зарцуулж байхад эмэгтэй хүн үүнээс 1.9 дахин их (1 цаг 44 минутаар их) буюу 3 цаг 39 минутыг зарцуулжээ.

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд авч үзвэл хөдөлмөр эрхэлдэггүй эрэгтэйчүүд өдөрт дунджаар 2 цаг 44 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүд 2.2 дахин бага (1 цаг 28 минутаар бага) цагийг буюу 1 цаг 16 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Хөлсгүй хөдөлмөрт хөдөлмөр эрхэлдэггүй эрэгтэй хүн 2 цаг 53 минутыг зарцуулж байхад хөдөлмөр эрхэлдэггүй эмэгтэйчүүд үүнээс 1.9 дахин их (2 цаг 38 минутаар их) буюу 5 цаг 31 минутыг зарцуулжээ. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа илүү гүнзгийрч байна. Өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхэлдэггүй байсан ч эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулах буюу өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох, богино хугацааны түр ажил хийх зэрэг боломж эрэгтэйчүүдэд илүү нээлттэй байдаг бололтой.

Эрэгтэйчүүд хөдөлмөр эрхэлдэг, хөдөлмөр эрхэлдэггүй аль ч статуст байсан эмэгтэйчүүдээс илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол эмэгтэйчүүд эсрэгээрээ хөдөлмөр эрхлэлтийн ямар ч статуст байсан хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүдээс илүү цаг зарцуулна.

Хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийн хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан нийт цагийн 81.1 хувь нь хөлстэй хөдөлмөрт зарцуулагдсан бол эмэгтэйчүүдийн хувьд нийт хөдөлмөр эрхэлсэн цагийнх нь 66.0 хувь нь хөлстэй байжээ. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд эрэгтэйчүүдийн хөдөлмөрт зарцуулсан нийт цагийн 48.7 хувь нь хөлстэй, эмэгтэйчүүдийн хувьд 18.7 хувь нь хөлстэй байна.

Хөлсгүй хөдөлмөрийг хөлстэй болгох, түүнийг орлох төлбөртэй үйлчилгээ бий болгох зэрэг нь чухал боловч хөлсгүй хөдөлмөр зарим тохиолдолд орлуулах боломжгүй, түүнчлэн орлуулахгүй байх тусам гэр бүлийн харилцаа, хүн амын сэтгэл ханамжид эерэгээр нөлөө үзүүлэх тохиолдол бий. Гэхдээ хөлсгүй хөдөлмөрийг өрхийн эрэгтэй, эмэгтэй гишүүд аль болох тэнцүү хуваалцах, хөдөлмөрийн үнэлэмж дэх хүйсийн ялгааг бууруулах тухай асуудлыг орхиж болохгүй. Өрхийн хөлсгүй хөдөлмөрийн тэгш бус хуваарилалт нь эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөрт зарцуулах цагийг бууруулах буюу хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш оролцох цаг хугацааны боломжийг хязгаарлаж байна.

Хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа нь энэ төрлийн хөдөлмөрийн бүхий л төрөлд илэрнэ. Хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд хувцас угаах, хоол, хүнс бэлтгэх, гэр цэвэрлэхэд хүйсийн ялгаа илүү ажиглагдах ба хүүхэд асрахад эдгээр үйл ажиллагаатай харьцуулахад арай бага ялгаа илрэх бол хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хүүхэд асрах, хувцас угаах, хоол, хүнс бэлтгэх үйл ажиллагаанд хүйсийн ялгаа илүү их ажиглагдаж байна.

Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд их цаг зарцуулах нь өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагийг хумьдаг. Хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ зориулах нийт цагт илрэх хүйсийн ялгаа хөлстэй, хөлсгүй хөдөлмөрт илэрсэн хүйсийн ялгаатай харьцуулахад харьцангуй бага, гэхдээ аль ч тохиолдолд эрэгтэйчүүд энэ үйл ажиллагаанд эмэгтэйчүүдээс илүү цаг гаргах хандлагатай. Энэ нь эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн ачаалал эмэгтэйчүүдээс бага байгаатай холбоотой.

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагийг үйл ажиллагаагаар задалж харвал боловсролын үйл ажиллагаанд хөдөлмөр эрхэлдэг хүн ам цаг зарцуулах нь бага хэдий ч хүйсийн хувьд эмэгтэйчүүд арай илүү цаг зарцуулдаг. Хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд боловсролын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 3 минут зарцуулдаг бол эмэгтэйчүүд 6 минут зарцуулжээ. Харин хөдөлмөр эрхэлдэггүй тохиолдолд хүйсийн харьцаа эсрэгээрээ эргэж, эрэгтэйчүүд өдөрт дунджаар 43 минутыг боловсролд зарцуулж байхад эмэгтэйчүүд 29 минутыг боловсролын үйл ажиллагаанд зарцуулж байна. Улсын дунджаар эмэгтэйчүүд боловсролын үйл ажиллагаанд эрэгтэйчүүдээс арай илүү цаг зарцуулах, ялангуяа хөдөөд илүү цаг зарцуулах төлөв ажиглагдаж байсан бол хөдөлмөр эрхэлдэггүй статустай хүн амын хувьд эмэгтэйчүүдийн боловсролд зарцуулах цаг эрэгтэйчүүдээс бага болж байгаа нь энэ бүлгийн хүн амын хөлсгүй хөдөлмөр дэх ялгаатай оролцоотой холбоотой гэж үзэж байна.

Чөлөөт цагийн хүйсийн харьцаа хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй аль ч тохиолдолд ойролцоо, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг гаргадаг. Хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд өдөрт дунджаар 2 цаг 2 минутыг чөлөөт цагтаа зарцуулдаг бол эмэгтэйчүүд 1 цаг 33 минутыг чөлөөт цагтаа зарцуулдаг. Хөдөлмөр эрхэлдэггүй эрэгтэйчүүд 4 цаг 7 минутыг чөлөөт цагтаа гаргадаг бол эмэгтэйчүүд 3 цаг 8 минутыг чөлөөт цагтаа зарцуулдаг. Илүү ойлгомжтойгоор харьцуулбал хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүдийн өдрийн 24 цагийн 8.5 хувь нь чөлөөт цаг бол эмэгтэйчүүдийн хувьд 6.5 хувь нь чөлөөт цаг. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд энэ хувь нэмэгдэж, эрэгтэйчүүдийн хувьд өдрийн 24 цагийн 17.2 хувь нь чөлөөт цаг байхад эмэгтэйчүүдийн хувьд 13.1 хувь байна. Эмэгтэйчүүд хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй аль ч статуст байсан хөлсгүй хөдөлмөрийн ачаалал эрэгтэйчүүдтэй харьцуулахад өндөр тул чөлөөт цаг нь эрэгтэйчүүдийнхээс хязгаарлагдмал байна.

Хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй аль ч тохиолдолд унтах, амрах, хувийн ариун цэвэр сахихад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс арай илүү цаг (өдөрт дунджаар 4-7 минут илүү) зарцуулдаг бол хооллоход эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг (өдөрт дунджаар 8-11 минут илүү) зарцуулна.

Дүрслэл 73. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



▬ Нийт
▬ Эрэгтэй
▬ Эмэгтэй

ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ (ААНБ ХЭЛБЭРЭЭР) ЭМЭГТЭЙЧҮҮД ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨРТ ХАМГИЙН ИХ ЦАГ ЗАРЦУУЛДАГ.

ААНБ хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ААНБ-ын ажил олгогчид болон бүтэн эсвэл хагас цагаар тогтмол хөдөлмөр эрхэлдэг цалин хөлстэй байнгын ажиллагчид хөлстэй хөдөлмөрт хамгийн их цагийг буюу долоо хоногийн нэг өдөрт дунджаар 8 цаг 13-31 минутыг зарцуулдаг. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй буюу ердийн ажлын нэг өдөр найман цагаас хэтрэхгүй байх тухай заасантай харьцуулахад эдгээр төрлийн статустай ажиллагчид илүү цагаар хөлстэй хөдөлмөр эрхэлдэг ажээ.

Хөдөлмөр эрхлэлтийн ихэнх статуст хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хандлага хэвээр боловч ААНБ хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэгч болон гүйцэтгэх гэрээлэгч статустай эмэгтэйчүүд ижил статустай эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Тодруулбал, ААНБ хэлбэрээр хувиараа хөдөлмөр эрхлэгч эрэгтэйчүүд өдөрт дунджаар 8 цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулсан бол ийм статустай эмэгтэйчүүд 9 цаг 13 минутыг зарцуулж байна.




Гүйцэтгэх гэрээлэгч, дагалдан статустай хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт эрэгтэйчүүд илүү цаг зарцуулдаг бол хөдөлмөр эрхлэлтийн бусад статуст эмэгтэйчүүд хөлсгүй хөдөлмөрт илүү цаг зарцуулах хандлага хэвээр. Тэр дундаа цалин хөлстэй түр ажиллагч, хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн, цалин хөлстэй түр ажиллагч статустай хүн амын дунд хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа хамгийн өндөр байна.

Цалин хөлстэй дагалдан, ААНБ-ын ажил олгогч, гүйцэтгэх гэрээлэгч статустай хүн амын дунд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээндээ эмэгтэйчүүд илүү цаг зарцуулдаг бол бусад тохиолдолд эрэгтэйчүүд энэ үйл ажиллагаанд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулж байна.

Дүрслэл 74. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, суурьшлаар, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




Нийт
Эрэгтэй
Эмэгтэй



Дүрслэл 75. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, бүсээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

— Нийт
— Эрэгтэй
— Эмэгтэй



ХӨДӨӨ АМЬДАРДАГ ХҮН АМ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙГЭЭС ҮЛ ХАМААРАН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨРТ ОЙРОЛЦОО ЦАГ ЗАРЦУУЛЖ БАЙНА.

Улсын дүнгээр хөдөлмөр эрхэлдэг болон эрхэлдэггүй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулсан цаг эрс ялгаатай байдаг ч хөдөөд хөдөлмөр эрхэлдэггүй хүний өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо өндөр тул ийм ялгаа ажиглагдахгүй байна. Ерөнхийдөө хөдөөд хөдөлмөр эрхэлдэг, эрхэлдэггүй хүн амын цаг ашиглалтад төдийлөн мэдэгдэхүйц ялгаа байхгүй гэж болно. Харин суурьшлын бусад байршлуудад хөдөлмөр эрхэлдэг хүн хөдөлмөр эрхэлдэггүй хүн амтай харьцуулахад хөлстэй хөдөлмөрт илүү цаг, хөлсгүй хөдөлмөр, өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд бага цаг зарцуулах хандлага тод илэрч байна.

Дүрслэл 76. Цаг ашиглалт, хөдөлмөр эрхэлдэг эсэхээр, насны бүлгээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	15-17 НАС			
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГ				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	400	435	347	0.11
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	88	64	125	-0.32
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	952	942	968	-0.01
ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	71	89	53	0.25
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	125	96	153	-0.23
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,244	1,254	1,234	0.01

ХӨДӨЛМӨР ЭРХЭЛДЭГГҮЙ СТАТУСТАЙ БОЛ АЛЬ Ч НАСАНД ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ИЛҮҮ ЦАГ ЗАРЦУУЛНА.

Хөдөлмөр эрхэлдэг хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцдог 18-59 насанд бусад насны бүлгээс илүү өндөр буюу эдгээр насны хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 7 цаг 38-46 минут зарцуулж байна. Харин 15-17 насанд 6 цаг 40 минут, 60 ба түүнээс дээш насанд 7 цаг 17 минут зарцуулжээ. Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь хөдөлмөр эрхэлдэг хүн амаас эрс бага бөгөөд ийм статустай 25-59 насныхан илүү идэвхтэй буюу өдөрт дунджаар 2 цаг 18-36 минут хөлстэй хөдөлмөр эрхэлжээ.

Хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг хөдөлмөр эрхэлдэг хүний хувьд 25-39 насны бүлэг хүртэл өсөж, 40 ба түүнээс дээш насанд харьцангуй тогтворждог. Хөдөлмөр эрхэлдэггүй бол аль ч насанд хөлсгүй хөдөлмөрт илүү цаг зарцуулах ба тэр дундаа хөдөлмөр эрхэлдэггүй 25-39 насны хүн ам хөдөлмөр эрхэлдэг ижил насны хүн амаас 2.3 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байгаа нь хамгийн их ялгаа юм.

Хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд аль ч насны бүлэгт хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдээс илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулах ба цагийн ялгаа нь 47 минутаас 1 цаг 28 минут хүртэл байна. Нөгөө талд хөдөлмөр эрхэлдэг статустай хүн амын дунд хөлсгүй хөдөлмөрийн ачаалал аль ч насны бүлэгт эмэгтэйчүүдэд илүү байх ба цагийн зөрүү нь 1 цаг 1 минутаас 1 цаг 56 минут хүртэл байна. Хөлстэй, хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн эдгээр ялгаа нь 25-39 насанд хамгийн өндөр түвшинд хүрдэг.

Нийт	18-24 НАС			25-39 НАС			40-59 НАС			60+ НАС					
	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
458	479	432	0.05	463	497	424	0.08	466	499	431	0.07	437	474	398	0.09
131	100	167	-0.25	168	113	229	-0.34	168	120	218	-0.29	159	121	201	-0.25
852	861	841	0.01	810	830	787	0.03	807	821	791	0.02	844	846	841	0.00
111	171	69	0.43	138	254	80	0.52	156	227	109	0.35	57	75	46	0.24
228	117	308	-0.45	379	204	466	-0.39	292	195	356	-0.29	233	171	267	-0.22
1,101	1,153	1,064	0.04	923	983	894	0.05	992	1,018	974	0.02	1,151	1,194	1,126	0.03

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрийн хүйсийн ялгаа эрс нэмэгдэх буюу хөдөлмөр эрхэлдэггүй ч эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөрт эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулж байна. Харин хөлсгүй хөдөлмөрийн хүйсийн ялгаа энэ статусын хүн амын хувьд 18-39 насанд эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах байдлаар улам гүнзгийрч байна.

Хөдөлмөр эрхэлдэг хүн амын хувьд өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулах цаг насны бүлгээр ойролцоо байхад хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын хувьд бага болон ахмад насанд буюу 15-17 болон 60 ба түүнээс дээш насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад энэ үйл ажиллагаанд илүү цаг зарцуулах хандлага ажиглагдаж байна.

4.7.


ЦАГ АШИГЛАЛТ БА ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Хүн амын амьдралын хэв маяг наснаас хамааран хувьсан өөрчлөгддөг. Харин насыг даган хувьсаж, цаг ашиглалтын төлөвт нөлөөлж байдаг томоохон хүчин зүйлсийн нэг нь гэрлэлтийн байдал юм. Гэрлэлтийн байдал, хүүхэдтэй эсэх зэрэг нь хүн амын хэрэгцээ, сонголт, үүрэг хариуцлага гээд олон хүчин зүйлсийг өөрчлөх замаар цаг ашиглалтад нөлөөлдөг.

Түүнчлэн өрхийн бүтэц буюу өрхийн ам бүлийн тоо, хүүхдийн тооноос хамааран хүн амын цаг ашиглалт ялгаатай. Цаашлаад өрхийн тэргүүлэгч, эхнэр, нөхөр, хүүхэд гэх мэт гэр бүлийн ямар гишүүн байхаас хамааран хүн амын цаг ашиглалтад онцлог ялгаа ажиглагдаж байна.

Дүрслэл 77. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Тусгаарласан/цуцалсан/бэлэвсэн

Гэрлэсэн - Батлуулаагүй

Гэрлэсэн - Батлуулсан

Огт гэрлээгүй

Монгол Улсад насанд хүрсэн буюу 18 насанд хүрсэн хүн гэр бүл болох боломжтой¹² тул хүн амын гэрлэлтийн байдлаар цаг ашиглалтыг хэмжихдээ 18 ба түүнээс дээш насны хүн амын хувьд тооцов.

Гэрлэлт нь хүн амын хөлсгүй хөдөлмөр эрхлэлтийн ачааллыг нэмэгдүүлдэг болох нь дүрслэлээс харагдаж байна. Харин хөлстэй хөдөлмөрийн тухайд гэрлэлтийг даган хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг их боловч гэрлээгүй хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх идэвх өндөр тул гэрлэлтээс хамаарсан ялгаа бага илэрч байна.

¹² Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль, 1999.06.11

Дүрслэл 78. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, гэрлэлтийн байдлаар







Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛААГҮЙ




ТУСГААРЛАСАН/
ЦУЦАЛСАН/
БЭЛЭВСЭН



Дүрслэл 79. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, гэрлэлтийн байдлаар

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

49

3

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

25



24

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

151

147

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад





3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

738

722

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад





4



3

20

34



129

206



705

774



Дүрслэл 80. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, насны бүлгээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




18-24 НАСАНД ГЭРЛЭЛТ ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛАХ ЦАГИЙГ БУУРУУЛАХ, ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛАХ ЦАГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НӨЛӨӨ ИЛҮҮ АЖИГЛАГДДАГ.

Хүн амын хөдөлмөр эрхлэх идэвх нь гэрлэлтийн байдлаар зарим ялгаатай. Ерөнхийдөө гэрлэсэн хүн амын хөлстэй, хөлсгүй нийт хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цаг огт гэрлээгүй хүн амынхаас өндөр буюу гэрлэлт нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болохоор байна.

Тодруулбал, гэрлэлтийг даган хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх ачаалал хөлсгүй хөдөлмөрт мэдэгдэхүйц илэрч байна. Огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэр бүлээ батлуулсан хүн амын хөлсгүй хөдөлмөрт зарцуулсан цаг 42.1 хувиар илүү, гэр бүлээ батлуулаагүй хүн амынх 56.6 хувиар илүү, тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүнийх 45.3 хувиар илүү ачаалалтай байна. Гэрлэлтийн төлөв ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлыг насны бүлгээр нарийвчилж үзвэл аль ч насанд гэрлэлт нь хөлсгүй хөдөлмөрийн ачааллыг нэмэгдүүлэх ба 18-39 насанд буюу залуу гэр бүлийн хувьд хөлсгүй хөдөлмөрийн ачаалал хамгийн их нэмэгдэж байна. Энэ насанд хүн амын төрөлтийн түвшин өндөр¹³, хүүхэд асрахад зарцуулах цаг их байгаатай холбоотой. Ялангуяа 18-24 насанд огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэрлэлтийн бусад төлөвт байгаа хүн амын хөлсгүй хөдөлмөр, тэр дундаа хүүхэд асрахад зарцуулсан цаг хамгийн өндөр байна.

¹³ 2022 онд төрсөн хүүхдийн 91.2 хувь нь 20-39 насны ээжүүдээс мэндэлсэн, УСХ



Харин хөлстэй хөдөлмөр, тэр дундаа ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэлтийн хувьд огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэр бүлээ батлуулсан хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цаг 10.2 хувиар бага байхад гэр бүлээ батлуулаагүй бол хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цаг 10.6 хувь илүү байна. Гэр бүлээ батлуулсан хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг огт гэрлээгүй хүн амынхаас бага байгаа нь аль ч насны бүлэгт ажиглагдаж байна. Онцолвол 18-24 насанд батлуулсан гэрлэлтийг даган хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад 18.0 хувиар бага байгаа нь бусад насны бүлэгтэй харьцуулахад хамгийн их ялгаа юм. Гэр бүлээ батлуулаагүй хүн амын хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг 18-39 насанд огт гэрлээгүй хүн амынхаас илүү бол 40-59 насанд бага байна.

Огт гэрлээгүй болон тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүн амтай харьцуулахад батлуулсан, эсвэл гэр бүлээ батлуулаагүй хүн амын өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг 7.0-11.0 хувиар хумигдмал. Гэр бүлээ батлуулаагүй хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг өндөр тул чөлөөт цаг болон хувийн хэрэгцээний цаг нь хамгийн бага. Харин тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүн амын хувьд чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цагтаа хамгийн их цаг зарцуулдаг. Боловсролын үйл ажиллагаанд огт гэрлээгүй хүн ам гэрлэлтийн бусад төлөвт буй хүн амаас их цаг зарцуулж байна.

Дүрслэл 81. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, ажлын болон амралтын өдрөөр

18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

ОГТ ГЭРЛЭЭГҮЙ

	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	336	262	▼
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	272	164	▼
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	197	105	▼
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	12	15	▲
- Ажилдаа явах, зорчих	40	22	▼
- Бусад	23	22	▼
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	64	98	▲
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	45	71	▲
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	9	12	▲
- Бусад	9	15	▲
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	148	191	▲
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	114	160	▲
- Хоол хүнс бэлтгэх	47	45	▼
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	33	48	▲
- Хувцас, гутал угаах, арчлах	9	29	▲
- Бусад	26	38	▲
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	29	22	▼
- Хүүхэд асрах	24	19	▼
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	2	-
- Бусад	3	1	▼
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	5	9	▲
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	956	987	▲
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	59	20	▼
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	23	31	▲
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	143	176	▲
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	5	▲
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	17	24	▲
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	10	13	▲
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	102	121	▲
- Бусад	13	15	▲
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	731	759	▲
- Унтах, амрах, босох	570	603	▲
- Хооллох, цай уух	83	84	▲
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	46	43	▼
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	4	2	▼
- Бусад	28	28	-

▲ Өссөн ▼ Буурсан - Өөрчлөгдөөгүй

ГЭРЛЭСЭН - БАТЛУУЛСАН

ГЭРЛЭСЭН - БАТЛУУЛААГҮЙ

ТУСГААРЛАСАН/ЦУЦАЛСАН/
БЭЛЭВСЭН

Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
335	268	▼	353	270	▼	202	165	▼
240	161	▼	292	200	▼	159	112	▼
169	102	▼	219	145	▼	116	74	▼
13	17	▲	2	3	▲	3	5	▲
33	20	▼	41	31	▼	22	14	▼
26	21	▼	31	21	▼	19	19	-
95	107	▲	61	70	▲	42	54	▲
66	74	▲	44	52	▲	20	31	▲
12	14	▲	7	10	▲	9	11	▲
18	20	▲	10	9	▼	14	12	▼
218	251	▲	244	266	▲	224	253	▲
155	191	▲	158	195	▲	175	202	▲
61	70	▲	68	73	▲	76	79	▲
51	57	▲	51	54	▲	64	71	▲
12	27	▲	13	30	▲	13	26	▲
30	38	▲	27	38	▲	22	25	▲
56	52	▼	83	63	▼	40	41	▲
46	46	-	68	57	▼	31	34	▲
2	2	-	4	2	▼	2	4	▲
8	4	▼	11	4	▼	7	4	▼
7	8	▲	3	7	▲	9	9	-
887	922	▲	843	904	▲	1,015	1,022	▲
3	2	▼	5	2	▼	3	4	▲
21	32	▲	18	25	▲	30	44	▲
142	161	▲	121	157	▲	210	196	▼
1	4	▲	2	3	▲	1	4	▲
6	7	▲	6	18	▲	10	9	▼
8	8	-	5	8	▲	11	9	▼
109	124	▲	92	114	▲	158	145	▼
18	18	-	16	14	▼	30	29	▼
721	726	▲	700	721	▲	772	779	▲
554	556	▲	550	574	▲	603	611	▲
89	91	▲	80	85	▲	83	87	▲
45	45	-	41	40	▼	50	54	▲
6	4	▼	7	3	▼	11	4	▼
27	30	▲	22	20	▼	25	22	▼

ДҮРСЛЭЛ 82.


ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА,
ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын
дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

ОГТ
ГЭРЛЭЭГҮЙ



ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛСАН



148 минут
Эрэгтэй

332 минут
Эмэгтэй

ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛААГҮЙ

178 минут
Эрэгтэй

247 минут
Эмэгтэй

ТУСГААРЛАСАН/
ЦУЦАЛСАН/
БЭЛЭВСЭН

Дүрслэл 83. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

ОГТ ГЭРЛЭЭГҮЙ

	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	350	281	0.11
1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	244	247	-0.01
- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах	172	177	-0.01
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх	18	7	0.44
- Ажилдаа явах, зорчих	34	37	-0.04
- Бусад	20	25	-0.11
1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	106	34	0.51
- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх	79	20	0.60
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх	13	6	0.37
- Бусад	14	7	0.33
2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	120	204	-0.26
2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	103	151	-0.19
- Хоол хүнс бэлтгэх	35	60	-0.26
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх	27	48	-0.28
- Хувцас, гутал угаах, арчлах	7	21	-0.50
- Бусад	35	22	0.23
2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	9	49	-0.69
- Хүүхэд асрах	6	43	-0.76
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах	2	2	0.00
- Бусад	1	4	-0.60
2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	7	5	0.17
3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	970	955	0.01
3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	50	48	0.02
3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох	28	22	0.12
3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	169	132	0.12
- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх	1	2	-0.33
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа	23	14	0.24
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа	10	11	-0.05
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах	121	91	0.14
- Бусад	14	12	0.08
3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	724	754	-0.02
- Унтах, амрах, босох	567	589	-0.02
- Хооллох, цай уух	87	78	0.05
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих	42	50	-0.09
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах	2	6	-0.50
- Бусад	26	30	-0.07

ГЭРЛЭСЭН - БАТЛУУЛСАН			ГЭРЛЭСЭН - БАТЛУУЛААГҮЙ			ТУСГААРЛАСАН/ЦУЦАЛСАН/ БЭЛЭВСЭН		
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
382	254	0.20	432	252	0.26	248	176	0.17
260	181	0.18	341	212	0.23	168	140	0.09
173	131	0.14	252	159	0.23	116	101	0.07
20	8	0.43	4	1	0.60	6	3	0.33
36	23	0.22	46	32	0.18	19	20	-0.03
31	18	0.27	39	20	0.32	27	17	0.23
122	74	0.24	91	40	0.39	79	35	0.39
91	44	0.35	69	27	0.44	51	15	0.55
13	11	0.08	9	6	0.20	14	8	0.27
18	18	0.00	13	7	0.30	14	13	0.04
140	313	-0.38	148	332	-0.38	178	247	-0.16
98	229	-0.40	102	221	-0.37	148	192	-0.13
28	99	-0.56	33	100	-0.50	55	83	-0.20
29	76	-0.45	29	70	-0.41	56	68	-0.10
3	28	-0.81	4	27	-0.74	10	19	-0.31
38	26	0.19	37	23	0.23	26	22	0.08
35	76	-0.37	43	107	-0.43	21	46	-0.37
27	66	-0.42	31	95	-0.51	16	36	-0.38
1	2	-0.33	4	3	0.14	1	3	-0.50
7	8	-0.07	9	10	-0.05	4	7	-0.27
7	8	-0.07	3	4	-0.14	9	9	0.00
918	873	0.03	860	855	0.00	1,015	1,017	-0.00
2	4	-0.33	3	5	-0.25	1	3	-0.50
24	24	0.00	25	15	0.25	34	33	0.01
168	125	0.15	147	114	0.13	222	202	0.05
1	2	-0.33	1	3	-0.50	1	2	-0.33
7	5	0.17	13	5	0.44	7	11	-0.22
8	8	0.00	4	7	-0.27	9	11	-0.10
132	94	0.17	109	86	0.12	181	147	0.10
20	17	0.08	18	13	0.16	22	32	-0.19
725	720	0.00	685	721	-0.03	758	778	-0.01
549	561	-0.01	527	580	-0.05	596	608	-0.01
94	85	0.05	86	77	0.06	89	83	0.03
44	46	-0.02	40	41	-0.01	42	54	-0.13
5	6	-0.09	5	6	-0.09	6	9	-0.20
33	23	0.18	27	17	0.23	25	24	0.02

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 84. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, насны бүлгээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	18-24 НАС			Хүйсийн харьцаа
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	
Огт гэрлээгүй				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	268	304	226	0.15
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	146	107	191	-0.28
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	1,027	1,030	1,023	0.00
Гэрлэсэн - Батлуулсан				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	244	456	151	0.50
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	300	112	383	-0.55
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	896	872	906	-0.02
Гэрлэсэн - Батлуулаагүй				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	265	485	193	0.43
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	282	63	355	-0.70
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	893	893	892	0.00
Тусгаарласан/ цуцалсан/ бэлэвсэн				
Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	290	379	244	0.22
Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа	350	349	351	-0.00
Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	800	712	845	-0.09

ГЭРЛЭСЭН ХҮН АМЫН ДУНД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХҮЙСИЙН ЯЛГАА ИЛҮҮ ГҮНЗГИЙ ИЛЭРДЭГ.

Хөдөлмөр эрхлэлт дэх хүйсийн ялгаа гэрлэлтийн байдлаар ялгаатай илрэх боловч гэрлэлтийн аль ч төлөвт хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хандлага ажиглагдана.

Гэрлэлт нь цаг ашиглалтын хувьд эрэгтэйчүүдэд хөлстэй хөдөлмөр эрхлэх хариуцлага, эмэгтэйчүүдэд хөлсгүй хөдөлмөр эрхлэх үүргийг авчирдаг гэж болно. Огт гэрлээгүй эрэгтэй огт гэрлээгүй эмэгтэйгээс 1.2 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг бол гэрлэсэн эрэгтэй гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүйгээс хамааран гэрлэсэн эмэгтэйгээс 1.5-1.7 дахин их цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүн амын хувьд энэ харьцаа 1.4 байна. Хөлсгүй хөдөлмөрийн хувьд хүйсийн ялгаа илүү гүнзгийрч, огт гэрлээгүй эмэгтэй огт гэрлээгүй эрэгтэйгээс 1.7 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байхад гэрлэсэн эмэгтэй гэрлэсэн эрэгтэйгээс гэрлэлтээ батлуулсан, батлуулаагүйгээс үл хамааран 2.2 дахин их цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн хүн амын хувьд энэ харьцаа хамгийн бага буюу 1.4 байна.

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй



25-39 НАС				40-59 НАС				60+ НАС			
Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
386	413	352	0.08	328	352	303	0.07	117	125	111	0.06
151	109	202	-0.30	202	167	237	-0.17	169	146	184	-0.12
903	918	886	0.02	910	921	900	0.01	1,155	1,168	1,145	0.01
355	447	272	0.24	359	420	296	0.17	148	179	110	0.24
247	135	346	-0.44	209	138	283	-0.34	223	153	309	-0.34
838	857	822	0.02	872	882	861	0.01	1,069	1,108	1,021	0.04
368	468	285	0.24	331	411	255	0.23	167	259	72	0.56
249	141	339	-0.41	244	164	320	-0.32	236	175	299	-0.26
823	831	816	0.01	865	865	865	0.00	1,037	1,006	1,070	-0.03
323	350	315	0.05	307	367	284	0.13	81	90	79	0.07
264	199	284	-0.18	235	164	263	-0.23	221	183	229	-0.11
853	891	842	0.03	898	909	894	0.01	1,139	1,167	1,132	0.02




Гэрлэсэн (батлуулсан болон батлуулаагүй) эмэгтэй гэрлэлтийн ижил төлөвт буй эрэгтэйтэй харьцуулахад 2.4-3.1 дахин их цагийг хүүхэд асрахад зарцуулдаг буюу хүүхэд асрах ажил эмэгтэйчүүдэд илүү хуваарилагддаг. Үүн дээр нэмээд гэрлэсэн эмэгтэйчүүд гэрийн ажилд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2.2-2.3 дахин их цагийг зарцуулж байна.

Гэр бүл төлөвлөлт дэх хөдөлмөр эрхлэлтийн хүйсийн ялгааг насны бүлгээр тодруулж харвал гэрлэлтийн эхэн үед буюу 18-24 насанд огт гэрлээгүй хүн амтай харьцуулахад гэр бүлээ батлуулсан болон батлуулаагүй хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа хамгийн өндөр түвшинд байх ба нас нэмэгдэх тусам аажим буурах ч хүйсийн ялгаа арилахгүй. Залуу гэр бүлийн хувьд гэрлэлтийн харилцаанд анх орохоос л эмэгтэйчүүд гэрийн ажил, хүүхэд асрах ажлаа хийж, эрэгтэйчүүд хөлстэй хөдөлмөр эрхлэлтээ нэмэгдүүлж буй нь гэр бүл доторх хөдөлмөрийн хуваарилалтын хүйсийн ялгаатай байдал уламжлалт хандлагад илрэхээс гадна орчин үеийн залуусын дунд ч түгээмэл хэвээр байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр гэрийн ажил хийх, хүүхэд асрах чанартай, боломжийн үйлчилгээ хомс, залуу гэр бүлийн хувьд ийм үйлчилгээ авахаас илүү хөлсгүй хөдөлмөрийг өөрсдөө буюу гэр бүлийн эмэгтэй гишүүн хийх сонголт эсвэл шаардлагатай нүүр тулж байна.

Дүрслэл 85. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, суурьшлаар, хүйсээр








Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛААГҮЙ

ТУСГААРЛАСАН/
ЦУЦАЛСАН/ БЭЛЭВСЭН



Хөдөөд хөдөлмөр эрхлэлт өндөр байх хандлага гэрлэлтийн аль ч төлөвт ялгаагүй ажиглагдаж байна. Суурьшлын хөдөөд болон нийслэлд бусад байршилтай харьцуулахад хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг гэрлэлтийн бүх төлөвт өндөр. Хөлсгүй хөдөлмөрийн тухайд огт гэрлээгүй хүн амын хувьд төвөөс алсрах тусам хөлсгүй хөдөлмөр эрхлэх цаг нэмэгдэх бол гэрлэлтийн бусад төлөвт хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг суурьшлаар төдийлөн ялгаагүй байна. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цаг гэрлэлтийн байдал үл харгалзан хөдөөд суурьшлын бусад байршилтай харьцуулахад бага байна.


Дүрслэл 86. Цаг ашиглалт, гэрлэлтийн байдлаар, бүсээр, хүйсээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023


ОГТ
ГЭРЛЭЭГҮЙ

ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛСАН


Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа






Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа




Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа





 Нийт
 Эрэгтэй
 Эмэгтэй

ГЭРЛЭСЭН -
БАТЛУУЛААГҮЙ

ТУСГААРЛАСАН/
ЦУЦАЛСАН/
БЭЛЭВСЭН



Бүсээр цаг ашиглалтын ялгаа гэрлэлтийн төлөв бүрт адилхан илрэхгүй байгаа ч гэр бүлээ батлуулсан болон батлуулаагүй хүн амын хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг Баруун бүсэд бусад бүстэй харьцуулахад бага байна. Мөн гэрлэлтийн бүх төлөвт хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг Баруун болон Зүүн бүсэд бусад бүстэй харьцуулахад өндөр байна.



ХҮҮХДИЙН ТОО НЭМЭГДЭХ ТУСАМ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ЗАРЦУУЛАХ ЦАГ НЭМЭГДЭНЭ.

Хүүхэдтэй эсэх болон хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тооноос хамааран цаг ашиглалтын төлөв өөрчлөгдөнө. Цаг ашиглалтын судалгааны үр дүнгээс харахад хамт амьдарч буй 18 хүртэлх насны хүүхдийн тоо нэмэгдэх тусам хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг нэмэгдэж байна.

Хүүхэдгүй 18 ба түүнээс дээш насны хүн ам хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 2 цаг 35 минутыг зарцуулж байхад хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны 1-2 хүүхэдтэй хүн үүнээс 1.5 дахин илүү буюу 3 цаг 45 минутыг, хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй хүн хүүхэдгүй хүнээс 1.8 дахин илүү илүү буюу 4 цаг 35 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна.

Хамт амьдардаг хүүхэдтэй хүн хүүхэдгүй хүнтэй харьцуулахад хөлсгүй хөдөлмөрт их цаг зарцуулахаас гадна хөлстэй хөдөлмөрт ч илүү цаг зарцуулж байна. Хүүхэдгүй хүн долоо хоногийн нэг өдөрт дунджаар 4 цаг 42 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны 1-2 хүүхэдтэй хүн хүүхэдгүй хүнээс 29.1 хувиар илүү буюу 6 цаг 4 минутыг, хамт амьдарч байгаа 18 хүртэлх насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй хүн хүүхэдгүй хүнээс 17.4 хувиар илүү буюу 5 цаг 31 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна.

Хүүхэдтэй хүмүүс хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хүүхэдгүй хүнээс илүү цаг зарцуулж буй учраас тэдний боловсрол, чөлөөт цаг, хувийн хэрэгцээний цаг хүүхэдгүй хүнтэй харьцуулахад хязгаарлагдмал.

Хүүхэдтэй боловч хүүхэдтэйгээ хамт амьдардаггүй хүн амын хувьд цаг ашиглалтын хандлага хүүхэдтэйгээ хамт амьдардаг хүн амтай харьцуулахад арай өөр. Тэд хүүхэдгүй хүнтэй харьцуулахад хөлсгүй хөдөлмөрт их цаг зарцуулах боловч хөлстэй хөдөлмөрт бага цаг зарцуулах байдлаар чөлөөт цаг, хувийн хэрэгцээндээ хүүхэдгүй хүнээс их цагийг хуваарилдаг.

Хөлстэй хөдөлмөр

Хөлсгүй хөдөлмөр

Боловсрол


Чөлөөт цаг
(чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа; хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох)

Унтах

Хувийн хэрэгцээ
(хооллох, хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих)

Дүрслэл 87. Цаг ашиглалт, хүүхэдтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023




|— 1 минут

Дүрслэл 88. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хүүхэдтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

ХҮҮХЭДГҮЙ




1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

202

- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах
- Орлого олох зорилгоор МAA эрхлэх
- Ажилдаа явах, зорчих
- Бусад



1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

81

- Өрхийн хэрэглээнд зориулж МAA эрхлэх
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх
- Бусад




2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

155

2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

130


- Хоол хүнс бэлтгэх
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх
- Хувцас, гутал угаах, арчлах
- Бусад



2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

18

- Хүүхэд асрах
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах
- Бусад



2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

7


ХҮҮХЭДТЭЙ (ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО)



Дүрслэл 89. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, хүүхэдтэй эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

ХҮҮХЭДГҮЙ



3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

38


3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

25

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

179


- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад



3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

761

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад



ХҮҮХЭДТЭЙ (ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО)



| — 1 минут

Дүрслэл 90. Цаг ашиглалт, хүүхэдтэй эсэхээр, ажлын болон амралтын өдрөөр

18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

Хамт амьдардаг хүүхэдтэй хүн хүүхэдгүй хүнтэй харьцуулахад хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагаа амралтын өдөр илүү бууруулдаг. Эсрэгээрээ хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагаа нэмэгдүүлэх боловч хүүхэдгүй хүн амтай харьцуулахад бага цагаар нэмэгдүүлж байна.

Хүүхэдгүй хүний хувьд амралтын өдөр хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагаа нэмэгдүүлснээр өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд зарцуулах цаг нь амралтын өдөр ажлын өдөртэй харьцуулахад хумигддаг. Харин хүүхэдтэй хүний хувьд хөлстэй хөдөлмөрөөс бууруулсан цагийн тодорхой хэсгийг өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагтаа хуваарилж байна.

1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх
- Ажилдаа явах, зорчих
- Бусад

1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх
- Бусад

2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

- Хоол хүнс бэлтгэх
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх
- Хувцас, гутал угаах, арчлах
- Бусад

2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

- Хүүхэд асрах
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах
- Бусад

2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад

3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа


- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад

ХҮҮХЭДГҮЙ

ХҮҮХЭДТЭЙ (ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО)

			0			1-2			3+		
Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт	Ажлын нэг өдөр	Амралтын нэг өдөр	Өөрчлөлт
294	247	▼	225	196	▼	391	280	▼	348	283	▼
221	142	▼	148	114	▼	315	195	▼	257	171	▼
159	90	▼	98	76	▼	232	130	▼	183	104	▼
12	16	▲	7	9	▲	12	13	▲	11	19	▲
33	22	▼	21	12	▼	42	27	▼	33	22	▼
17	15	▼	22	17	▼	29	25	▼	30	25	▼
73	105	▲	78	82	▲	76	85	▲	91	112	▲
52	79	▲	49	53	▲	52	57	▲	64	81	▲
10	11	▲	12	12	-	9	11	▲	10	16	▲
10	15	▲	16	17	▲	15	17	▲	18	16	▼
142	194	▲	217	229	▲	214	263	▲	270	289	▲
120	160	▲	177	193	▲	142	194	▲	161	200	▲
51	49	▼	71	73	▲	59	72	▲	66	72	▲
35	58	▲	65	65	-	44	53	▲	52	56	▲
9	20	▲	11	21	▲	13	33	▲	13	36	▲
25	34	▲	30	34	▲	26	37	▲	30	36	▲
16	24	▲	30	24	▼	68	63	▼	103	82	▼
12	22	▲	22	19	▼	56	57	▲	88	70	▼
2	2	-	3	4	▲	2	1	▼	1	2	▲
2	1	▼	5	1	▼	10	5	▼	14	10	▼
6	10	▲	10	11	▲	4	5	▲	5	7	▲
1,004	999	▼	998	1,015	▲	836	898	▲	823	868	▲
45	18	▼	2	3	▲	5	2	▼	3	2	▼
21	38	▲	28	36	▲	20	28	▲	18	35	▲
178	180	▲	207	219	▲	113	140	▲	100	119	▲
1	4	▲	1	2	▲	1	5	▲	1	5	▲
14	20	▲	9	8	▼	5	9	▲	6	8	▲
11	10	▼	12	13	▲	6	5	▼	4	6	▲
123	125	▲	161	168	▲	87	105	▲	76	88	▲
29	21	▼	24	27	▲	14	15	▲	13	12	▼
760	763	▲	761	757	▼	699	728	▲	701	711	▲
594	604	▲	589	587	▼	540	562	▲	539	546	▲
85	86	▲	88	92	▲	85	86	▲	88	88	-
47	43	▼	48	50	▲	44	45	▲	41	43	▲
8	2	▼	10	4	▼	4	3	▼	4	5	▲
26	28	▲	26	23	▼	25	31	▲	29	30	▲


ХҮҮХЭДГҮЙ



ДҮРСЛЭЛ 91.
ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЭЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ХҮҮХЭДТЭЙ ЭСЭХЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023

ХҮҮХЭДТЭЙ



Дүрслэл 92. Цаг ашиглалт, хүүхэдтэй эсэхээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 18, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

ХҮҮХДИЙН ТОО НЭМЭГДЭХ ТУСАМ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ АЧААЛАЛ НЭМЭГДДЭГ.

Хүүхэдтэй, тэр дундаа хамт амьдардаг хүүхэдтэй байх нь эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүн амын амьдралын хэв маягт өөрчлөлт авчирдаг. Цаг ашиглалтын судалгаанаас эрэгтэйчүүдийн хувьд хүүхэдтэй байх нь хөлстэй хөдөлмөр эрхлэх цагаа нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн хувьд хөлсгүй хөдөлмөр эрхлэх цагаа нэмэгдүүлэх сонголт хийхэд хүргэдэг гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ энэ нь хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд илүү нөлөөлөх тул хөлсгүй хөдөлмөрт их цаг зарцуулдаг эмэгтэйчүүдийн хувьд ачаалал илүү нэмэгдэж байна.

Хүүхэдгүй, 18 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд өдөрт дунджаар 5 цаг 30 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулдаг ба хамт амьдардаг 1-2 хүүхэдтэй бол энэ цаг 31.2 хувиар нэмэгдэж, 7 цаг 13 минут, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 33.6 хувиар нэмэгдэж, 7 цаг 21 минут болж байна. Эмэгтэйчүүдийн хувьд ч хөлстэй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулах цаг хүүхдийн тоог даган нэмэгдэх ба 1-2 хүүхэдтэй бол хүүхэдгүй хүнээс 39.4 хувиар нэмэгдэж, 5 цаг 8 минут, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 7.7 хувиар нэмэгдэж, 3 цаг 58 минут болж байна. Хүүхэдгүй эмэгтэй долоо хоногийн нэг өдөрт дунджаар 3 цаг 41 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж буй юм.

Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг хүүхэдгүй эрэгтэйн хувьд долоо хоногийн нэг өдөрт дунджаар 2 цаг 1 минут, хүүхэдгүй эмэгтэйн хувьд 3 цаг 18 минут байна. Хамт амьдардаг хүүхдийн тоо 1-2 болоход эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг 14.0 хувиар нэмэгдэж, 2 цаг 18 минут болох бол эмэгтэйчүүдийнх 49.5 хувиар нэмэгдэж, 4 цаг 56 минут болж байна. Харин хүүхдийн тоо 3 ба түүнээс дээш болоход эрэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг хүүхэдгүй эрэгтэйтэй харьцуулахад 26.4 хувиар нэмэгдэж, 2 цаг 33 минут болох бол эмэгтэйчүүдийн хувьд 90.4 хувиар нэмэгдэж, 6 цаг 17 минут болж байна.

1. Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

1.1. Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа

- Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах
- Орлого олох зорилгоор МАА эрхлэх
- Ажилдаа явах, зорчих
- Бусад

1.2. Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх

- Өрхийн хэрэглээнд зориулж МАА эрхлэх
- Усанд явж, түлээ түлш бэлтгэх
- Бусад

2. Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

2.1. Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх

- Хоол хүнс бэлтгэх
- Гэр, сууц, хашаагаа цэвэрлэх
- Хувцас, гутал угаах, арчлах
- Бусад

2.2. Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах

- Хүүхэд асрах
- Өрхийн өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн асрах
- Бусад

2.3. Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад

3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад

ХҮҮХЭДГҮЙ

ХҮҮХЭДТЭЙ (ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО)

ХҮҮХЭДГҮЙ			ХҮҮХЭДТЭЙ (ХАМТ АМЬДАРЧ БАЙГАА 18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО)								
Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	0			1-2			3+		
			Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
330	221	0.20	283	174	0.24	433	308	0.17	441	238	0.30
217	182	0.09	175	115	0.21	327	252	0.13	306	174	0.28
152	129	0.08	112	80	0.17	227	191	0.09	208	123	0.26
17	8	0.36	13	3	0.63	18	7	0.44	21	6	0.56
32	28	0.07	24	16	0.20	45	33	0.15	38	24	0.23
15	17	-0.06	27	17	0.23	37	21	0.28	39	20	0.32
113	39	0.49	108	59	0.29	106	56	0.31	134	64	0.35
85	25	0.55	78	32	0.42	78	33	0.41	101	40	0.43
13	7	0.30	15	10	0.20	10	9	0.05	13	10	0.13
15	8	0.30	15	18	-0.09	17	14	0.10	20	14	0.18
121	198	-0.24	151	266	-0.28	138	296	-0.36	153	377	-0.42
107	159	-0.20	122	221	-0.29	92	205	-0.38	93	238	-0.44
36	68	-0.31	37	95	-0.44	27	90	-0.54	26	103	-0.60
31	53	-0.26	44	79	-0.28	24	64	-0.45	23	78	-0.54
6	19	-0.52	5	20	-0.60	4	29	-0.76	2	34	-0.89
34	19	0.28	35	28	0.11	37	22	0.25	41	23	0.28
7	33	-0.65	19	34	-0.28	42	86	-0.34	55	134	-0.42
5	27	-0.69	13	27	-0.35	33	75	-0.39	41	119	-0.49
1	3	-0.50	2	4	-0.33	1	2	-0.33	2	1	0.33
1	2	-0.33	4	4	0.00	8	10	-0.11	12	14	-0.08
7	7	0.00	10	10	0.00	4	5	-0.11	6	6	0.00
989	1,021	-0.02	1,006	1,000	0.00	869	836	0.02	846	825	0.01
37	40	-0.04	3	2	0.20	2	6	-0.50	1	5	-0.67
26	24	0.04	28	32	-0.07	25	19	0.14	21	24	-0.07
185	171	0.04	228	198	0.07	139	103	0.15	120	93	0.13
1	3	-0.50	1	2	-0.33	2	2	0.00	1	3	-0.50
18	12	0.20	7	10	-0.18	8	5	0.23	8	5	0.23
10	13	-0.13	12	12	0.00	5	6	-0.09	5	5	0.00
131	113	0.07	183	150	0.10	110	76	0.18	91	68	0.14
25	30	-0.09	24	25	-0.02	14	14	0.00	15	11	0.15
740	786	-0.03	747	768	-0.01	703	708	-0.00	705	703	0.00
579	619	-0.03	574	598	-0.02	535	554	-0.02	528	551	-0.02
90	79	0.07	95	85	0.06	89	82	0.04	94	83	0.06
42	51	-0.10	45	52	-0.07	43	46	-0.03	41	42	-0.01
3	10	-0.54	7	9	-0.13	3	4	-0.14	3	6	-0.33
25	28	-0.06	27	24	0.06	33	22	0.20	38	22	0.27

Дүрслэл 93. Цаг ашиглалт, өрхийн ам бүлийн тоогоор, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

Өрхийн ам бүлийн тоо	ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОН ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
1			
Эрэгтэй	337	150	953
Эмэгтэй	156	231	1,053
Хүйсийн харьцаа	0.37	-0.21	-0.05
2			
Эрэгтэй	281	145	1,014
Эмэгтэй	203	264	973
Хүйсийн харьцаа	0.16	-0.29	0.02
3			
Эрэгтэй	352	127	961
Эмэгтэй	248	270	922
Хүйсийн харьцаа	0.17	-0.36	0.02
4			
Эрэгтэй	372	133	935
Эмэгтэй	260	280	900
Хүйсийн харьцаа	0.18	-0.36	0.02
5			
Эрэгтэй	351	136	953
Эмэгтэй	226	300	914
Хүйсийн харьцаа	0.22	-0.38	0.02
6			
Эрэгтэй	359	130	951
Эмэгтэй	206	310	924
Хүйсийн харьцаа	0.27	-0.41	0.01
7+			
Эрэгтэй	365	121	954
Эмэгтэй	218	274	948
Хүйсийн харьцаа	0.25	-0.39	0.00

Өрхийн ам бүлийн тоо хэд байхаас үл хамааран хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд эсрэг хүйсээсээ илүү цаг зарцуулах хандлага хэвээр. Гэхдээ өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам энэ хандлага улам гүнзгийрч байна.

Дүрслэл 94. Цаг ашиглалт, өрхийн тэргүүлэгчийн хамаарлаар, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

Өрхийн тэргүүлэгчийн хамаарал	ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОН ХУВИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА
Өрхийн тэргүүлэгч			
Эрэгтэй	376	143	921
Эмэгтэй	211	262	967
Хүйсийн харьцаа	0.28	-0.29	-0.02
Эхнэр/нөхөр			
Эрэгтэй	336	198	906
Эмэгтэй	261	316	863
Хүйсийн харьцаа	0.13	-0.23	0.02
Хүү/Охин			
Эрэгтэй	217	105	1,118
Эмэгтэй	144	186	1,110
Хүйсийн харьцаа	0.20	-0.28	0.00
Эцэг/Эх			
Эрэгтэй	151	162	1,127
Эмэгтэй	87	271	1,082
Хүйсийн харьцаа	0.27	-0.25	0.02
Бусад			
Эрэгтэй	245	117	1,078
Эмэгтэй	162	202	1,076
Хүйсийн харьцаа	0.20	-0.27	0.00

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Өрхийн тэргүүлэгч, өрхийн тэргүүлэгчийн эхнэр/нөхөр, эцэг/эх, хүүхэд аль нь ч байсан хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд, хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа мөн л ажиглагдана. Өрхийн тэргүүлэгч эрэгтэй, эсвэл өрхийн тэргүүлэгчийн эцэг байх тохиолдолд хөлстэй хөдөлмөрийн ачаалал нэмэгддэг бол өрхийн тэргүүлэгч эмэгтэй, эсвэл өрхийн тэргүүлэгчийн охин байвал хөлсгүй хөдөлмөрийн ачаалал эсрэг хүйсээс илүү өндөр байна.

4.8.

ЦАГ АШИГЛАЛТ БА ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШИН

Хүн амын цаг ашиглалтын төлөв буюу амьдралын хэв маяг өрхийн аж байдлын түвшнээс хэр хамааралтай байдаг вэ?

Цаг ашиглалтын судалгааны хүрээнд өрхийн эзэмшлийн хөрөнгө болон өрхийн эзэмшлийн хөрөнгийн шинж байдлын үзүүлэлтүүд (сууцны төрөл, сууцны эзэмшил, дэд бүтцэд холбогдсон байдал, удаан эдэлгээт хөрөнгийн эзэмшил, малын тоо гэх мэт)-ийг ашиглан баялгийн индекс тооцох замаар өрхийн аж байдлын түвшинг доогуур, дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр, дээгүүр гэсэн таван түвшинд үнэлж, цаг ашиглалтыг хэмжсэн.

Дүрслэл 95. Цаг ашиглалт, өрхийн аж байдлын түвшнээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр, дээгүүр аж байдлын түвшинтэй хүн амын хувьд аж байдлын түвшин нь хөдөлмөр эрхлэлттэй шууд хамааралтай буюу хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг их байх тусам аж байдлын түвшин өндөр байх ерөнхий хандлага ажиглагдаж байна. Хүн амын аж байдлын түвшин өндөр байхын хэрээр хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг болон унтах, амрахад зарцуулах цаг хумигдаж, эсрэгээрээ хөлстэй хөдөлмөр болон чөлөөт цаг, боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгддэг. Харин аж байдлын түвшин доогуур хүн амын хувьд энэ хандлага биелэхгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Дүрслэл 96. Хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлсэн үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, өрхийн аж байдлын түвшнээр


Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



ДУНДАЖ

ДУНДЖААС ДЭЭГҮҮР




ДЭЭГҮҮР



221

259





289



26

17




5



169

159

125



57

56

60



8


7

6

Дүрслэл 97. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулсан хугацаа, өрхийн аж байдлын түвшнээр

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

3. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа



3.1. Боловсрол, сургалтын үйл ажиллагаа

5

20

3.2. Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээнд оролцох

21



26

3.3. Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа

111

165

- Соёлын болон спортын арга хэмжээнд оролцох, үзэх
- Хобби, тоглоом, бусад чөлөөт цагийн үйл ажиллагаа
- Спортоор хичээллэх, тоглох, дасгал хийх, түүнтэй холбоотой үйл ажиллагаа
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах
- Бусад






3.4. Хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

720

760

- Унтах, амрах, босох
- Хооллох, цай уух
- Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих
- Бусдаас хувийн болон эрүүл мэндтэй холбогдох тусламж, үйлчилгээ авах
- Бусад








20

24

161




754





20

24

170




728




28

29

181



717



ХӨЛСТЭЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ЦАГ ИХ БАЙХ ТУСАМ ХҮН АМЫН АЖ БАЙДЛЫН ТҮВШИН ӨНДӨР БАЙНА.

Аж байдлын ялгаатай түвшинд харгалзах цаг ашиглалтын төлөвийг харьцуулбал аж байдал доогуур ангиллаас бусад тохиолдолд хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цаг нэмэгдэх тусам аж байдлын түвшин сайжирч буй нь харагдаж байна. Дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн ам өдөрт 3 цаг 43 минут, дундаж аж байдалтай хүн ам 4 цаг 7 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байхад дунджаас дээгүүр, дээгүүр түвшний аж байдалтай хүн ам өдөрт 4 цаг 36-54 минутыг хөлстэй хөдөлмөрт зарцуулж байна. Түүнчлэн дунджаас дээгүүр болон дээгүүр түвшний аж байдалтай хүн ам ААНБ-д ажиллах зонхилсон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд илүү цаг зарцуулах ба өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оролцох оролцоо багатай байна. Дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн амын хөлстэй хөдөлмөр эрхэлсэн нийт цагийн 26.9 хувь нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдсан бол дундаж түвшний аж байдалтай хүн амын хувьд энэ нь 10.5 хувь, дунджаас дээгүүр аж байдлын түвшинтэй хүн амын хувьд 6.2 хувь, дээгүүр аж байдлын түвшинтэй хүн амын хувьд 1.7 хувь болж буурч байна. Гэтэл аж байдлын түвшин хамгийн бага буюу доогуур ангилалд багтах хүн амын хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулсан цаг бусад бүлгүүдээс хамгийн өндөр хэдий ч үүний 80.4 хувь нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулагдсан байна. Энэ нь аж байдлын түвшин доогуур хүн ам хөдөлмөр эрхлэлтэд их цаг зарцуулдаг ч ихэвчлэн өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд цаг зарцуулдаг буюу хөдөлмөрийн үнэлэмжийн хувьд бага байх магадлалтай үйл ажиллагаанд их цаг зарцуулдаг болохыг харуулж байна.

Дундаж болон дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн ам өдөрт дунджаар 3 цаг 54 минутаас 4 цаг 6 минутыг хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг. Харин аж байдлын түвшин сайжрах тусам энэ цаг буурч байна. Гэхдээ дунджаас дээгүүр болон дээгүүр түвшний аж байдалтай хүн ам хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагаа зогсоодог гэсэн үг биш. Тэд хөлсгүй хөдөлмөрт өдөрт дунджаар 3 цаг 11-42 минутыг зарцуулж байна.

Аж байдлын түвшин сайжрахад гэрийн ажилд зарцуулах цаг буурах бол хүүхэд асрахад зарцуулах цаг буурдаггүй.

Хоол хүнс бэлтгэх, гэр цэвэрлэх гэх мэт гэрийн ажилд дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн өдөрт дунджаар 3 цаг 2 минутыг зарцуулдаг бол аж байдлын түвшин дээгүүр хүн ам үүнээс 31.3 хувиар бага буюу 2 цаг 5 минутыг зарцуулдаг. Харин хүүхэд асрахад аж байдлын түвшин доогуур хүн ам хамгийн бага буюу өдөрт дунджаар 21 минут зарцуулсан бол аж байдлын бусад ангиллын хүн ам өдөрт дунджаар 45-49 минут зарцуулах ба аж байдлын түвшин дээгүүр хүн ам хамгийн их цаг буюу өдөрт дунджаар 49 минутыг хүүхэд асрахад зарцуулжээ.

Дундаж болон дунджаас доогуур аж байдлын түвшинтэй хүн ам боловсролын үйл ажиллагаанд өдөрт дунджаар 20 минутыг зарцуулдаг бол аж байдлын түвшин дээгүүр хүн ам 28 минутыг зарцуулж байна. Мөн аж байдлын түвшин дээгүүр хүмүүс аж байдлын бусад түвшний хүн амтай харьцуулахад хүмүүстэй харилцах болон спортоор хичээллэхэд их цагийг зарцуулж, унтах, амрахад бага цаг зориулдаг аж. Харин олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглахад зарцуулах цаг аж байдлын түвшин үл хамааран ойролцоо түвшинд байна.

Дүрслэл 98. Цаг ашиглалт, өрхийн аж байдлын түвшнээр, ажлын болон амралтын өдрөөр

15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Аж байдлын түвшин сайжрах тусам ажлын болон амралтын өдрийн цаг ашиглалтын ялгаа нэмэгдэх хандлагатай. Аж байдлын түвшин доогуур хүн амын хувьд амралтын өдөр, ажлын өдрийн ялгаа бараг ажиглагдахгүй байна. Харин аж байдлын түвшин дээгүүр хүн ам ажлын өдөр хөлстэй хөдөлмөрт илүү их цаг зарцуулж, амралтын өдөр өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний цагаа нэмэгдүүлж чадаж байна.

ДҮРСЛЭЛ 99.




ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ТҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛСАН ХУГАЦАА, ӨРХИЙН АЖ БАЙДЛЫН ТҮВШНЭЭР, ХҮЙСЭЭР

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, минутаар, 2023


ДООГУУР

ДУНДЖААС
ДООГУУР


ДУНДАЖ



ДУНДЖААС ДЭЭГҮҮР



ДЭЭГҮҮР



Дүрслэл 100. Цаг ашиглалт, өрхийн аж байдлын түвшнээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ДООГУУР				ДУНДЖААС ДООГУУР			
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	72	87	56	0.22	164	206	135	0.21
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	296	360	226	0.23	60	86	42	0.34
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	185	115	262	-0.39	182	120	225	-0.30
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	24	8	42	-0.68	54	29	72	-0.43
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	5	4	5	-0.11	10	11	9	0.10
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	5	4	6	-0.20	20	16	22	-0.16
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	21	19	23	-0.10	26	25	26	-0.02
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	20	21	20	0.02	34	37	32	0.07
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	91	99	83	0.09	131	150	117	0.12
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	71	73	68	0.04	72	75	70	0.03
Хоол идэх, цай уух	101	107	94	0.06	89	93	88	0.03
Унтах	549	543	555	-0.01	598	592	602	-0.01

Хөлстэй, хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд зарцуулах цагт илрэх хүйсийн ялгаа аж байдлын түвшин үл харгалзан ажиглагдах боловч аж байдлын түвшин ахих тусам хөлстэй хөдөлмөр дэх эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа буурч байна. Харин хөлсгүй хөдөлмөр дэх эмэгтэйчүүд давамгайлсан хүйсийн ялгаа дунджаас доогуур, дундаж, дунджаас дээгүүр түвшинд аж байдлын түвшин сайжрахын хэрээр буурах боловч дээгүүр түвшний аж байдалтай хүн амын хувьд хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа нэмэгдэж байна.

ДУНДАЖ				ДУНДЖААС ДЭЭГҮҮР				ДЭЭГҮҮР			
Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
221	283	174	0.24	260	315	221	0.18	289	343	242	0.17
27	33	22	0.20	18	25	13	0.32	5	6	4	0.20
170	114	212	-0.30	158	106	195	-0.30	125	75	167	-0.38
56	37	71	-0.31	56	35	71	-0.34	60	42	75	-0.28
8	7	10	-0.18	7	8	7	0.07	6	6	6	0.00
20	26	15	0.27	20	22	19	0.07	28	29	27	0.04
24	25	24	0.02	24	24	25	-0.02	29	32	26	0.10
37	37	37	0.00	47	54	42	0.13	55	55	55	0.00
124	140	111	0.12	123	138	112	0.10	126	143	110	0.13
82	80	83	-0.02	79	76	80	-0.03	83	81	85	-0.02
81	85	79	0.04	81	84	78	0.04	81	84	78	0.04
590	573	602	-0.02	567	553	577	-0.02	555	544	565	-0.02

Боловсролын үйл ажиллагаанд доогуур, дунджаас доогуур аж байдлын түвшинд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү цаг зарцуулдаг бол дундаж аж байдлын түвшинтэй хүн амын хувьд эмэгтэйчүүд боловсролд эсрэг хүйсээсээ илүү цаг зарцуулж байна. Харин аж байдлын түвшин дунджаас дээгүүр, дээгүүр болоход боловсролын үйл ажиллагаанд зарцуулах цагт илрэх хүйсийн ялгаа бараг арилж байна.

Аж байдлын түвшин үл харгалзан чөлөөт цаг болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах, хооллоход эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс арай илүү цаг зориулдаг бол эмэгтэйчүүдийн хувьд унтах, амрахад эрэгтэйчүүдээс ялимгүй илүү цаг зарцуулдаг.



-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 101. Цаг ашиглалт, өрхийн аж байдлын түвшнээр, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 15, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Аж байдлын түвшин хамааралгүй суурьшлын хөдөөд суурьшлын бусад байршилтай харьцуулахад хөдөлмөр эрхлэлт өндөр. Мөн нийслэл хотод амьдарч буй хүн амын аж байдлын түвшин сайжрах тусам хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг нь нэмэгддэг. Сумын төвд аж байдлын түвшин доогуур хүн ам хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулж буй нь өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ялангуяа өрхийн хэрэгцээнд зориулж мал аж ахуй эрхэлдэг аж байдлын түвшин доогуур өрхүүд сумын төвд их байгааг харуулж байна.

ДУНДАЖ

ДУНДЖААС
ДЭЭГҮҮР

ДЭЭГҮҮР

274
210
228
329

305
231
246
345

301
249
321
363

234
239
231
180

217
236
215
151

188
205
187
176

932
991
981
931

918
973
979
944

951
986
932
901

Суурьшлын аль ч байрилд аж байдлын түвшин сайтай хүн ам хөлсгүй хөдөлмөрт бага цаг зарцуулж байна. Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд хөдөөгийн хүн ам аж байдлын түвшин үл харгалзан бага цаг зарцуулдаг. Мөн нийслэлд амьдардаг аж байдлын түвшин доогуур ангиллаас бусад ангилалд багтах хүн ам хөлстэй хөдөлмөрт идэвхтэй цаг зарцуулдаг тул өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээнд бага цаг зарцуулж байна.

ЦАГ АШИГЛАЛТ БА АХУЙН НӨХЦӨЛ ХАНГАГДСАН БАЙДАЛ

БИЕ ДААСАН ТОХИЛОГ СУУЦ (ХАУС) БОЛОН ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ХҮН АМ ХӨЛСГҮЙ ХӨДӨЛМӨРТ ХАРЬЦАНГУЙ ИХ ЦАГ ЗАРЦУУЛДАГ.

Цаг ашиглалтын судалгаагаар хүн амын ахуйн нөхцөл хангагдсан байдлыг өрхийн сууцны төрөл болон ундны ус, цахилгаан, халаалтын эх үүсвэрээр авч үзэв. Ахуйн нөхцөл нь өрхийн гишүүдийн хөлсгүй хөдөлмөр дэх цаг ашиглалтад илүү нөлөөлж, ахуйн нөхцөл сайн хангагдсан байх нь хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цагийг хэмнэнэ гэж төсөөлж байна. Сууцны төрлөөр хүн амын цаг ашиглалтыг хэмжихдээ гэр, орон сууцны байшин, бие даасан тохиолог сууц, сууцны тусдаа байшин, нийтийн байр гэсэн сууцны таван төрлөөр (зориулалтын бус сууц, бусад сууц төрлийг хамруулаагүй) авч үзсэн.

Сууцны төрөл дундаас бие даасан тохиолог сууц (хаус) болон гэрт амьдардаг өрхийн хүн ам хөлсгүй хөдөлмөрт харьцангуй их цаг зарцуулж байна. Харин орон сууцны байшинд амьдардаг хүн ам хөлсгүй хөдөлмөрт хамгийн бага цаг зарцуулжээ. Энэ ялгаа гэрийн ажилд зарцуулах цагт ижил илрэх буюу орон сууцны байшинд амьдардаг бол гэрийн ажилд зарцуулах цагаа тодорхой хэмжээгээр хэмнэх боломжтой байдаг аж. Тухайлбал орон сууцанд амьдардаг хүн ам долоо хоногийн нэг өдөрт дунджаар 2 цаг 4 минутыг гэрийн ажилд зарцуулж байгаатай харьцуулахад нийтийн байранд амьдардаг хүн ам 21.0 хувиар их, сууцны тусдаа байшинд амьдардаг хүн ам 30.6 хувиар их цаг зарцуулдаг ба гэрт амьдардаг хүн ам 46.0 хувиар их, бие даасан тохиолог сууцанд амьдардаг хүн ам 58.9 хувиар тус тус их цагийг гэрийн ажилд зарцуулжээ.

ААНБ-д ажиллах зонхилсон хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд орон сууцны байшин, нийтийн байр, бие даасан тохиолог сууцанд амьдардаг хүн ам илүү цаг зарцуулдаг бол гэр болон сууцны тусдаа байшинд амьдардаг хүн ам өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөлстэй хөдөлмөрт илүү цаг зарцуулна.

Гэрт амьдардаг хүн амын хөлстэй болон хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг их тул чөлөөт цагт бусад төрлийн сууцанд амьдардаг хүн амтай харьцуулахад хамгийн бага цаг зарцуулж байна. Эсрэгээрээ орон сууцанд амьдардаг хүн ам хөлсгүй хөдөлмөрт бусад төрлийн сууцанд амьдардаг хүн амаас бага цаг зарцуулсны үр дүнд чөлөөт цагт хамгийн их цаг зарцуулдаг.

Дүрслэл 102. Цаг ашиглалт, сууцны төрлөөр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Нийтийн байр (ажилчдын, оюутны, бусад)

Сууцны тусдаа байшин

Бие даасан тохилог сууц

Орон сууцны байшин

Гэр

Дүрслэл 103. Цаг ашиглалт, сууцны төрлөөр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ГЭР				ОРОН СУУЦНЫ БАЙШИН			
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	128	152	107	0.17	263	317	220	0.18
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	173	234	119	0.33	6	7	5	0.17
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	181	117	238	-0.34	124	72	164	-0.39
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	38	19	54	-0.48	58	42	72	-0.26
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	7	5	9	-0.29	6	6	6	0.00
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	19	18	21	-0.08	42	42	41	0.01
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	20	18	21	-0.08	27	29	25	0.07
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	29	29	29	0.00	61	64	58	0.05
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	104	113	97	0.08	128	146	114	0.12
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	75	75	76	-0.01	81	78	85	-0.04
Хоол идэх, цай уух	88	94	82	0.07	80	82	77	0.03
Унтах	577	566	587	-0.02	565	555	573	-0.02

Сууцны төрөл дундаас нийтийн байранд амьдардаг хүн амын хөлстэй, хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа бусад сууцанд амьдардаг хүн амтай харьцуулахад хамгийн бага. Гэрт болон бие даасан тохилог сууцанд амьдардаг хүн амын хувьд хөлстэй хөдөлмөрт эрэгтэйчүүд давамгайлсан хүйсийн харьцаа хамгийн өндөр.

Харин хөлсгүй хөдөлмөрийн хувьд сууцны төрлөөс үл хамааран эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү цаг зарцуулах ба гэр, орон сууцны байшин, сууцны тусдаа байшинд амьдардаг хүн амын хувьд эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн ачаалал илүү их байна.

БИЕ ДААСАН ТОХИЛОГ СУУЦ				СУУЦНЫ ТУСДАА БАЙШИН				НИЙТИЙН БАЙР (АЖИЛЧДЫН, ОЮУТНЫ, БУСАД)			
Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй	Хүйсийн харьцаа
213	248	187	0.14	198	239	165	0.18	241	252	234	0.04
28	55	8	0.75	56	75	41	0.29	13	20	9	0.38
197	163	221	-0.15	162	109	204	-0.30	150	149	151	-0.01
48	20	68	-0.55	51	29	69	-0.41	38	7	56	-0.78
9	20	1	0.90	7	8	6	0.14	10	4	13	-0.53
26	25	27	-0.04	36	35	38	-0.04	32	34	30	0.06
32	37	28	0.14	27	27	27	0.00	18	8	24	-0.50
43	42	43	-0.01	40	47	36	0.13	35	40	34	0.08
122	108	133	-0.10	122	136	110	0.11	143	172	126	0.15
111	137	95	0.18	73	76	73	0.02	81	79	83	-0.02
72	76	69	0.05	91	95	87	0.04	85	93	80	0.08
539	509	560	-0.05	575	564	584	-0.02	594	582	600	-0.02


-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй

1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 104. Цаг ашиглалт, сууцны төрлөөр, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Сууцны төрлөөс үл хамааран хөдөөд хөлстэй хөдөлмөрт зарцуулах цаг өндөр байх хандлагатай. Гэрт амьдардаг хүн ам хөдөө амьдардаг бол бусад суурьшилд гэрт амьдардаг хүн амтай харьцуулахад хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулж, хөлсгүй хөдөлмөрт бага цаг зарцуулна.

Бие даасан тохилог сууцанд амьдардаг хүн нийслэл хотод амьдардаг бол бусад суурьшилд ижил төрлийн сууцанд амьдардаг хүн амтай харьцуулахад хөлстэй хөдөлмөрт хамгийн бага цаг зарцуулж, хөлсгүй хөдөлмөрт их цаг зарцуулж байна.

Орон сууцны байшин, сууцны тусдаа байшинд амьдардаг хүн хөдөө амьдардаг бол бусад суурьшилд ижил төрлийн сууцанд амьдардаг хүн амтай харьцуулахад хөлстэй хөдөлмөрт их цаг зарцуулж, хөлсгүй хөдөлмөрт хамгийн бага цаг зарцуулна. Нийтийн байранд амьдардаг хүн мөн хөдөө, эсвэл аймгийн төвд амьдардаг бол бусад суурьшилд ижил төрлийн сууцанд амьдардаг хүн амтай харьцуулахад илүү цагийг хөлстэй хөдөлмөрт зарцуулж, хөлсгүй хөдөлмөрт бага цаг зарцуулна.

БИЕ ДААСАН
ТОХИЛОГ СУУЦ

СУУЦНЫ ТУСДАА
БАЙШИН

НИЙТИЙН БАЙР
(АЖИЛЧДЫН,
ОЮУТНЫ, БУСАД)

75
300
250
-

262
219
245
340

243
220
306
335

341
230
208
-

229
227
218
179

202
220
187
111


1,024
910
982
-

949
994
977
921

995
1,000
947
994

Дүрслэл 105. Цаг ашиглалт, ундны усны эх үүсвэрээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 106. Цаг ашиглалт, ундны усны эх үүсвэрээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ТӨВЛӨРСӨН СИСТЕМ		БИЕ ДААСАН СИСТЕМ		ЗӨӨВРИЙН	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	314	218	281	171	142	111
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	8	5	38	23	230	121
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	75	166	125	222	108	221
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	41	71	32	71	19	56
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	6	8	7	6	7
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	41	41	37	33	20	26
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	29	25	18	23	24	24
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	63	57	49	39	30	28
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	145	114	134	106	118	102
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	80	85	77	79	74	71
Хоол идэх, цай уух	83	78	80	73	102	92
Унтах	555	574	561	593	567	581

Ундны ус, цахилгаан, халаалтын эх үүсвэрийн ялгаа нь хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд илүү нөлөөлнө гэж таамаглаад хөлсгүй хөдөлмөрийг онцолвол ундны усаа төвлөрсөн системээс авдаггүй өрх төвлөрсөн системтэй өрхтэй харьцуулахад өдөрт дунджаар 22-52 минутыг хөлсгүй хөдөлмөрт илүү зарцуулж байна. Зөвөрөөр ундны усаа авдаг хүн амын дунд эмэгтэйчүүд давамгайлсан хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа илүү өндөр байна.

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй


1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ЦАГ АШИГЛАЛТЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Дүрслэл 107. Цаг ашиглалт, цахилгааны эх үүсвэрээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 108. Цаг ашиглалт, цахилгааны эх үүсвэрээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ТӨВЛӨРСӨН СИСТЕМ		БИЕ ДААСАН СИСТЕМ		ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРГҮЙ	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	277	188	84	50	56	56
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	35	20	368	233	312	132
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	96	191	114	264	117	211
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	37	71	7	38	7	59
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	7	7	4	5	8	0
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	38	38	7	8	26	51
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	26	25	19	18	10	7
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	53	45	23	23	34	56
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	142	113	92	78	94	70
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	77	77	75	72	96	53
Хоол идэх, цай уух	86	80	104	93	127	87
Унтах	566	585	543	558	553	658


Цахилгааны эх үүсвэргүй байхад эсрэгээрээ төвлөрсөн системд холбогдсон хүн амаас өдөрт дунджаар 32 минутаар бага цагийг хөлсгүй хөдөлмөрт зарцуулж байна. Цахилгааны эх үүсвэр нь төвлөрсөн бус байхад хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа нэмэгдэж байна.

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй


1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ЦАГ АШИГЛАЛТЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Дүрслэл 109. Цаг ашиглалт, халаалтын эх үүсвэрээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 110. Цаг ашиглалт, халаалтын эх үүсвэрээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

	ТӨВЛӨРСӨН СИСТЕМ		БИЕ ДААСАН СИСТЕМ		ЕРДИЙН ГАЛЛАГАА	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	315	219	270	219	178	123
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	8	5	42	22	182	92
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	74	166	105	189	115	226
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	40	71	32	77	22	60
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	6	9	4	6	8
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	42	41	44	40	23	27
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	29	25	26	30	22	23
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	64	56	56	26	34	33
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	145	115	126	93	123	105
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	80	85	79	74	75	72
Хоол идэх, цай уух	82	78	87	82	95	85
Унтах	555	573	564	584	565	586


Халаалт нь төвлөрсөн системтэй хүн амтай харьцуулахад бие даасан болон ердийн галлагаатай өрхийн хүн амын хөлсгүй хөдөлмөрт зарцуулах цаг 23-37 минутаар илүү байна. Хөлсгүй хөдөлмөр дэх хүйсийн ялгаа халаалтын төвлөрсөн системд холбогдоогүй бол мөн л нэмэгдэж байна.

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй

0 – хүйсийн ялгаа байхгүй


1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

ЦАГ АШИГЛАЛТЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА



Дүрслэл 111. Цаг ашиглалт, өрхийн сууцны ахуйн нөхцөл хангагдсан эсэхээр

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



	АХУЙН НӨХЦӨЛ САЙТАЙ ӨРХ		АХУЙН НӨХЦӨЛ ДУТУУ ХАНГАГДСАН ӨРХ		АХУЙН НӨХЦӨЛ МУУ ХАНГАГДСАН ӨРХ		АХУЙН НӨХЦӨЛ ХАНГАГДААГҮЙ ӨРХ	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөр эрхлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаа	311	222	273	163	135	103	21	49
Өрхийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	10	6	46	26	242	130	375	201
Гэрийн ажил хийх болон гэр бүлийн гишүүдэд туслах, үйлчилгээ үзүүлэх	80	168	122	222	109	225	135	265
Өрхийн гишүүдийг цалин хөлсгүй асрах	39	72	37	70	17	53	3	91
Цалин хөлсгүй, сайн дурын ажил, сургалт, бусад ажил	6	6	9	7	5	8	10	0
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа	42	41	33	34	19	24	3	0
Хүмүүстэй харилцах болон олон нийтийн арга хэмжээ	27	26	24	23	22	24	12	8
Чөлөөт цаг, урлаг, спортын үйл ажиллагаа	65	54	42	39	31	29	17	12
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хэрэглэх	142	111	135	110	117	101	85	85
Бусад хувийн хэрэгцээний үйл ажиллагаа	80	83	73	74	75	72	80	36
Хоол идэх, цай уух	82	77	84	78	101	91	148	110
Унтах	556	574	562	594	567	580	551	583

Цаг ашиглалтын судалгаагаар өрхийн сууцны ахуйн нөхцөл хангагдсан байдлыг дараах 4 төрөлд ангилав. Үүнд:

1. Ахуйн нөхцөл сайтай өрх (3 нөхцөл хангагдсан)
2. Ахуйн нөхцөл дутуу хангагдсан өрх (2 нөхцөл хангагдсан)
3. Ахуйн нөхцөл муу хангагдсан өрх (1 нөхцөл хангагдсан)
4. Ахуйн нөхцөл хангагдаагүй өрх (нэг ч нөхцөл хангагдаагүй)

Үүнд өрхийн сууцны ахуйн нөхцөл хангагдсан байдлыг тодорхойлохдоо:

1. Ундны усны эх үүсвэрээр хангагдсан - Төвлөрсөн болон бие даасан усан хангамжийн системтэй өрхүүдийг хамаарна. Ингэхдээ халуун, хүйтэн устай эсвэл зөвхөн хүйтэн устай эсэхийг харгалзаж үзэхгүй.
2. Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан - Өрхийн цахилгааны эх үүсвэрийн төрөл хэлбэрээс үл хамааран цахилгааны ямар нэг эх үүсвэртэй бол цахилгаанаар хангагдсан гэж үзсэн.
3. Халаалтын эх үүсвэрээр хангагдсан - Төвлөрсөн болон бие даасан халаалтын системтэй өрхүүдийг хамаарна.

-1 - тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эмэгтэйчүүд цаг зарцуулсан, эрэгтэйчүүд цаг зарцуулаагүй
 0 – хүйсийн ялгаа байхгүй
 1- тодорхой үйл ажиллагаанд зөвхөн эрэгтэйчүүд цаг зарцуулсан, эмэгтэйчүүд цаг зарцуулаагүй

Дүрслэл 112. Цаг ашиглалт, өрхийн сууцны ахуйн нөхцөл хангагдсан эсэхээр, хүйсээр, хүйсийн харьцаа

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023



Дүрслэл 113. Цаг ашиглалт, өрхийн сууцны ахуйн нөхцөл хангагдсан эсэхээр, суурьшлаар

Долоо хоногийн нэг өдөрт 12, түүнээс дээш насны хүн амын дундаж цаг ашиглалт, үйл ажиллагаагаар, минутаар, 2023

АХУЙН НӨХЦӨЛ
САЙТАЙ ӨРХ

АХУЙН НӨХЦӨЛ ДУТУУ
ХАНГАГДСАН ӨРХ

Хөлстэй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа

НИЙСЛЭЛ	285	254
АЙМГИЙН ТӨВ	217	213
СУМЫН ТӨВ	246	243
ХӨДӨӨ	374	303

Хөлсгүй хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа





НИЙСЛЭЛ	188	242
АЙМГИЙН ТӨВ	211	258
СУМЫН ТӨВ	198	232
ХӨДӨӨ	138	201

Өөрийгөө хөгжүүлэх болон хувийн хэрэгцээний үйл ажиллагаа

НИЙСЛЭЛ	967	944
АЙМГИЙН ТӨВ	1,012	969
СУМЫН ТӨВ	996	965
ХӨДӨӨ	928	936

АХУЙН НӨХЦӨЛ МУУ
ХАНГАГДСАН ӨРХ

АХУЙН НӨХЦӨЛ
ХАНГАГДААГҮЙ ӨРХ



Ахуйн нөхцөл хангагдсан байдлаар хүн амын хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд зарцуулсан цагийг харьцуулбал ахуйн нөхцөл муу хангагдсан, эсвал хангагдаагүй хүн ам ахуйн нөхцөл сайтай хүн амтай харьцуулахад өдөрт дунджаар 20 минутыг хөлсгүй хөдөлмөрт илүү зарцуулж байна. Харин ахуйн нөхцөл дутуу хангагдсан ангилалд багтах хүн ам ахуйн нөхцөл муу хангагдсан, эсвал хангагдаагүй хүн амтай харьцуулахад 32 минутыг хөлсгүй хөдөлмөрт илүү зарцуулж байна.

Ахуйн нөхцөл хангагдаагүй байх тусам хөлсгүй хөдөлмөрт эмэгтэйчүүд илүү цаг зарцуулах хүйсийн ялгаа нэмэгдэж байна.

Суурьшлын ялгаагаар ахуйн нөхцөл хангагдаагүй хүн ам нийслэл хотод амьдардаг бол хөлсгүй хөдөлмөр эрхлэлтэд илүү их цаг зарцуулах шаардлагатай байна. Харин төвөөс алсрах тусам энэ шаардлага буурч байна.

4.9.

ЦАГ АШИГЛАЛТЫН ТЭНЦВЭРТ БА ЗОХИСТ БАЙДАЛ

Амьдралын нөхцөл, үүрэг хариуцлага, сонголт зэрэг олон хүчин зүйлээс хамаараад хүмүүс зарим үйл ажиллагаанд хэт их цаг зарцуулах, зарим үйл ажиллагаанд огт цаг зарцуулахгүй байх нь бий. Гэхдээ хүн амын цаг ашиглалтад тодорхой хэмжээний тэнцвэр, зохист байдал хангагдах нь зүйтэй. Мөн цаг ашиглалтын үйл ажиллагааны олон янз байдлыг хадгалах, тодорхой төрлийн үйл ажиллагааг цаг ашиглалтдаа оруулах замаар илүү баялаг амьдралын хэв маягийг бүтээх боломжтой.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй буюу ердийн ажлын нэг өдөр найман цагаас хэтрэхгүй байх тухай заасан. Мөн долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар 56 цагаас илүүгүй, өдөрт ажиллах илүү цагийн хязгаар дөрвөн цагаас илүүгүй байхыг тогтоожээ. Харин насанд хүрээгүй хүний долоо хоногийн ажлын цаг 30-аас илүүгүй байхаар тусгасан байна.¹⁴ Түүнчлэн Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын ажлын цагтай холбоотой баримт бичгүүдэд¹⁵ долоо хоногт ажлын цагийг 40 байх зарчмыг тогтоосон байдаг.


